

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

**2021 №3 (77)
19 дэх жилдээ**

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Батбуян БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Улсын бүртгэлийн дугаар 237

ISBN 978-99929-62-31-3

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батсүх АЛТАНСҮХ
ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР
ДОКТОР (Ph.D)

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Жаргалсайхан МӨНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жутьяа НЯМДУЛАМ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батхишиг ЛХАГВАСҮРЭН
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Буриад ЛХАГВАРАГЧАА
ДОКТОР (Ph.D)

Шархүү ЧУЛУУНБАТ
ДОКТОР (Ph.D)

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН:

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:

Бэгзсүрэн ЖАМСРАН

ГАРЧИГ

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТӨРИЙН БОДЛОГО

“Ковид-19 цар тахлын үеийн эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ” цахим хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмж		5
--	--	---

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Гадаадын зарим улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хийсэн шинжилгээ	Д.Батбаяр	8
Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо	Э.Батболд	19
Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ойлголт, хууль бус хэрэглээ	Б.Бямбазаяа	24
Эдийн засгийн өсөлтийг хангахад компанийн бондын үр нөлөө	П.Уранмандах	31
Нэмэгдсэн өртгийн албан татвар оногдуулахад тулгамдсан асуудал	Г.Хулан	37
Хил дамнасан цахим худалдааны бодлого, анхаарах асуудал	Ц.Сонор	45
Газар хөдлөлтийн үеийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, анхаарах зарим асуудал	Н.Амартүвшин	52
Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил, тулгамдаж буй зарим асуудал	Б.Зоригт	57

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Монгол орны ой, ойг хамгаалах талаарх эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал	А.Баасанцэрэн	66
--	---------------	----

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хүний эрхэд суурилсан эрүүгийн процесс дахь мөрдөн байцаалт: анхаарах асуудал	Н.Манлайбаатар	70
---	----------------	----

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, тулгамдсан зарим асуудалд	А.Амарсайхан	74
Хэсгийн байцаагчийн объектын судалгааг нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд ашиглах нь	Г.Бямбадорж	78
Монгол улсын дотоодын цэрэгтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаадын зарим орны цэрэгжсэн байгууллагын үйл ажиллагааг шинжих нь	П.Оюунболд	84
Цэргийн алба хаагчид тэтгэвэр тогтоож, олгохтой холбогдсон тулгамдсан зарим асуудал	С.Лхагвадорж	93

ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ

The Relationship Between Eu Law And International Law-Autonomy Versus Völkerrechtsfreundlichkeit	Namsrai Battulga	101
--	------------------	-----

ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТӨРИЙН БОДЛОГО

“КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЛЭЭ” ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Дотоод хэргийн их сургууль, “Суурийн Жанцан сан”-тай хамтран Ковид-19 цар тахлын үед эрүүгийн хууль тогтоомжийг хэрэглэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлох, хүний эрхийг хамгаалах, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар санал, зөвлөмж боловсруулан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх зорилгоор “Цар тахлын үеийн эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ” цахим хэлэлцүүлгийг 2021 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулав.

Энэхүү хэлэлцүүлэгт Хүний эрхийн Үндэсний Комисс, Улсын Их Хурлын Тамгын газар, шүүх, Улсын ерөнхий прокурорын газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын Үндэсний аврах бригад, Дотоод хэргийн их сургууль, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын криминологичдын холбооны ажилтан, албан хаагчид болон эрдэмтэн, судлаачдын 90 гаруй төлөөлөл оролцлоо.

Хэлэлцүүлэгт оролцогчид Ковид-19 цар тахлын үед гарсан хүний эрхийн зөрчил, хууль зүйн туслалцаа авах эрх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад тулгамдсан болон анхаарах асуудал, шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, өмгөөллийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, эдгээр байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал, хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг хангах, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн нөхцөл байдал тэдгээрийн эрхийн хэрэгжилтийг сайжруулах, түүнчлэн, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг асуудлыг хэлэлцэж, эдгээр асуудалд талууд хамтран ажиллаж, ахиц дэвшил гаргахыг эрмэлзэх нь нэн чухал болохыг онцлон тэмдэглэж, оролцогчдын санал, дүгнэлтийг тусгасан дараах Зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэл 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөр дуусч байгаа тул уг хугацааг сунгах эсэх, сунгахгүй тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой гаргасан түр журмуудад заасан цаашид үргэлжлэх харилцаатай зарим зохицуулалтыг судалж саналаа гарган хууль тогтоогчид болон холбогдох байгууллагад уламжлах;
2. Ковид-19 цар тахлын үед хорих ангид хэт их бөөгнөрөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор анх удаа гэмт хэрэг үйлдсэн, жирэмсэн, ~~бага бага~~ насны хүүхэдтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй, архаг, хууч өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон насанд хүрээгүй ялтнуудын үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, ял эдэлсэн хугацаа, ялтны хувийн байдал зэргийг харгалзан өршөөл үзүүлэх, хорих ялыг зорчих эрхийг хязгаарласан ялаар солих асуудлыг судалж, хууль тогтоогчдод уламжлан шийдвэрлүүлэх;
3. Ковид-19 цар тахлын үед Зөрчлийн тухай хуульд сонгох шийтгэлтэй байхаар заасан зөрчилд аль болох баривчлахаас өөр шийтгэл оногдуулах, зайлшгүй шаардлагаар оногдуулсан шийтгэлийн биелэлтийг түр хугацаанд хойшлуулах, түдгэлзүүлэх боломжтой эсэхийг судалж, саналаа холбогдох байгууллагад уламжлах;
4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (худал мэдээлэл тараах), Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (худал мэдээлэл тараах), Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.13-т заасан (илт худал мэдээлэл) гэсэн хууль зүйн ойлголтыг нэг мөр ойлгох талаар албан ёсны тайлбар гаргах;
5. Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын болон Цагдаагийн ерөнхий газрын дарга нарын хамтран батлах “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам”-ыг даруй батлах; Уг журмыг Монгол

Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээгээр баталгаажуулсан халдашгүй чөлөөтэй байх, хувийн нууцаа хамгаалуулах хүний эрхийг хангахад үр дүнтэй хамгаалах зохицуулалтыг технологид суурилсан шийдэлд нийцүүлэн тусгах, хяналт, хариуцлагыг тодорхой заах;

6. Цагдан хоригдох хугацаанд коронавируст халдвар авсан, тусгаарлагдсан хоригдогчийн талаарх мэдээллийг ар гэрийнхэн болон өмгөөлөгчид шуурхай мэдээлэх, энэ харилцааг зохицуулсан журмыг батлан мөрдүүлэх;
7. Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан зөрчил, гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлсан журмаар зохицуулах боломжийг судлах, холбогдох саналаа хууль тогтоогчдод уламжлах;

Хоёр. Өргөдөл, гомдол шийдвэрлэх чиглэлээр

8. Ковид-19 цар тахлын үед шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах, түүнчлэн шүүхийн шийдвэрийг хорих байрны захиргаа цахимаар хүлээн авах, гомдол гаргах нөхцөлийг бүрдүүлж зохицуулах;
9. Ковид-19 цар тахлын үед шүүхэд цахимаар гаргасан гомдол шийдвэрлэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх;

Гурав. Хууль зүйн туслалцаа авах чиглэлээр

10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудын тэнцвэрт байдлыг хангах үүднээс гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллах байгууллагуудын тогтоол шийдвэрт өмгөөлөгчдийг хамруулахаар тусгах;
11. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед баривчлагдсан, цагдан хоригдсон, ял эдэлж буй этгээдийн хууль зүйн туслалцаа авах эрхийг бүрэн хангах зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг авах, тэдэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл бололцоог хангасан, ойлгомжтой журам зохицуулалтыг гаргаж мөрдүүлэх;
12. Ковид-19 цар тахлын үед өмгөөлөгчдийг цагдан хорих, хорих ангид очиж ажиллахад тээврийн хэрэгслээр зорчих QR код олгох, халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх заавар зааварчилгаанд нийцүүлэн үйлчлүүлэгчтэйгээ биечлэн болон цахимаар ганцаарчлан уулзах нөхцөлийг хангах уулзалтын өрөөний агааржуулалт, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах;

Дөрөв. Баривчлагдсан, цагдан хоригдсон, ял эдэлж буй этгээдийн эрхийг хамгаалах чиглэлээр

13. Ковид-19 цар тахлын үед баривчлагдсан, цагдан хоригдсон, ял эдэлж буй этгээдийн эрүүл мэндийн суурь үзлэг, үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдгээрийн дархлааг дэмжих хүнс амин дэмийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;
14. Ковид-19 цар тахлын үед хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийг цагдан хоригдох болон хүлээлгэнд байх хугацаанд хүүхдээ хөхүүлэх цаг гаргах нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх;
15. Ковид-19 цар тахлын үед хорих анги, цагдан хорих, захиргааны журмаар баривчлах болон эрүүлжүүлэх, саатуулах байруудын ариутгал халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахиулах чиглэлээр гар угаах цэгүүд болон ундны цэвэр ус дутагдалтай хэсгүүдэд ус, ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу байгуулах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;
16. Ковид-19 цар тахлын үед хорих анги, цагдан хорих ангийн эмнэлэг, хорих ангийн үйлдвэрлэлийн бүсэд коронавируст халдвар авахаас урьдчилан сэргийлэн хоригдогчдын хөдөлгөөнийг нарийвчлан зохицуулах, тэдэнд тогтмол гараа угаах, ариутгах боломжийг бүрдүүлэх, үйлдвэрийн болон гал тогооны багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулах;
17. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай этгээд цагдан хоригдсон тохиолдолд түүнд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж, холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

Тав. Бусад

18. Ковид-19 цар тахлын үед гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, холбогдох байгууллагуудын уялдаа холбоо, хяналтыг сайжруулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангах, хохирогчийг хамгаалахад онцгой анхаарч ажиллах;
19. Ковид-19 цар тахлын үед цахим сүлжээ ашиглан үйлдэгдэж буй мөрийтэй тоглоом зохион байгуулах, хонжворт сугалаа, азтан шалгаруулах үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, хууль бус үйлдлийг таслан зогсоох;
20. Төрийн албан хаагч, хууль сахиулагчийг эсэргүүцсэн зөрчил, гэмт хэргийг шалгах ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, буруутай этгээдэд тухай бүр хариуцлага хүлээлгэж байх;
21. Ковид-19 цар тахлын үед эрсдэл бүхий нөхцөлд үүрэг гүйцэтгэж байхдаа коронавируст халдвар авсан төрийн тусгай албан хаагчдад нөхөн олговор олгох, даатгалд хамруулах, даатгалаас нөхөн төлбөр авах зохицуулалтын хэрэгжилтийг хангах, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа гаргаж, шийдвэрлүүлэх;
22. Ковид-19 цар тахлын үед үүрэг гүйцэтгэсэн эмнэлэг, цагдаа, онцгой байдал зэрэг төрийн байгууллагын албан хаагчдад илүү цагийн хөлс, урамшуулал олгох.

--- о О о ---

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ГАДААДЫН ЗАРИМ УЛСАД ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*Д.Батбаяр
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд гадаадын зарим улс оронд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, тэдгээрийн үр дүн, манай улсад хэрэгжүүлж болох зарим төсөл, хөтөлбөрийн талаар судлаачийн үзэл бодлын талаар дурдсан болно.

Түлхүүр үг. Гэр бүлийн хүчирхийлэл, төсөл, хөтөлбөр, үр дүн.

Үндсэн хэсэг. Дэлхийн улс орнуудад гэр бүлийн хүчирхийллийн талаар явуулсан судалгаа, тоо баримтаас үзвэл ихэнх тохиолдолд эмэгтэйчүүд хүчирхийллийн хохирогч болдог гэдгийг баталсан байна.

Залуучуудын үйлдсэн хүчирхийллээс үүдэлтэй дарамт ачааллыг бага, дунд орлоготой улс орнуудад илүүтэй үүрдэг ч урьдчилан сэргийлэх бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг судалсан судалгаа, үнэлгээнүүд бараг бүгд Австрали, Их Британи, Баруун Европын хэдэн улс, АНУ зэрэг өндөр орлоготой улс оронд хийгдсэн байна. Хувь хүн, ойрын хүрээллийн эрсдэлт хүчин зүйлсэд анхаарсан бодлого, хөтөлбөрийн үр нөлөөг үнэлсэн судалгаанууд цөөнгүй байдаг бол орон нутгийн ба нийгмийн түвшний эрсдэлт хүчин зүйлсэд нөлөөлөх бодлого, стратегийн үр нөлөөг судалсан нь бага байна.

Урьдчилан сэргийлэх стратегиуд нь бага наснаас анхаарч эхэлж байгаа нь сайшаалтай ч бага насанд үзүүлсэн үйлчилгээ, дэмжлэг нь өсөж том болохын хэрээр өсвөр болон залуу насанд хүчирхийллээс хамгаалж чадаж байгаа эсэхийг авч үзсэн урт хугацааны судалгаа цөөн байна.¹

Англи улсад зөрчлийн талаарх цагдаагийн дуудлагын 90 гаруй хувь нь нөхөр нь эхнэрээ, найз залуу нь найз охиндоо гаргасан түрэмгий зангийн дуудлага байдаг байна. Өнөө үед дэлхийн 40 гаруй улс оронд гэр бүлийн хүчирхийллийг хориглосон ямар нэгэн хуультай болсон байна.

Зарим ардчилал өндөр хөгжсөн улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг үзэхэд асуудлыг хууль тогтоомжийн замаар шийдвэрлэх нь ихээхэн үр дүнтэй байна.² Тусдаа бие даасан хуультай байх нь илүү үр дүнтэй. Хууль нь үйлчилдэггүй Де-юре ба Де фактогийн хооронд ихээхэн хийдэлтэй улс орнуудад бас нэг ажиллагаагүй хууль гаргах нь утга учиргүй гэсэн санал байдаг. Харин хууль нь “бэлэг тэмдэг” болоод ч гэсэн байж байх нь гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлж, тусдаа хуультай байх нь тус нэмэр болж мэдлэг дээшлэх, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод хүчирхийлэлтэй тэмцэх арга замыг зааж өгдөг.

Лондоны Их сургуулийн экологи, нийгмийн шинжлэх ухааны факультетын дэргэдэх хүүхэд, эмэгтэйчүүдийн талаарх хүчирхийллийг судлах төвийн профессор Лиз Келлийн тодорхойлсноор:

- Анх удаа үйлдсэн эрх зүйн зөрчилд хамгаалалтын шийдвэр хэрэглэх боломжтой иргэн-эрх зүйн арга хэмжээгээр хязгаарлагдаж /Испани, Финланд/ эсвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хэмээн буруутгагдсан этгээдийг хүүхдүүдтэйгээ харьцахыг нь хязгаарлах арга хэмжээ авдаг.

¹ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. УБ., 2017. 10 дахь тал

² Антони Гидденс. “Социологи” УБ. 2006 он. Эмэгтэйчүүд өөрсдийн дуу хоолойг нийтэд хүргэхийн тулд олон жил уйгагүй зүтгэсний эцэст багагүй амжилт гаргасан байдаг байна.

- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг арга хэмжээг иргэний болон эрүүгийн байцаан шийтгэх арга хэмжээ болгон нэгтгэн нийлүүлсэн орнууд /Кипр, Мексик, Никарагуа, АНУ-ын зарим муж улсууд/
- Төр өөрөө тусламжийн алба байгуулах, мөн түүнчлэн төрийг ашиглан төрийн нэрийн өмнөөс хүчирхийлэл үйлдэх үйлдлийг ор мөргүй арилгах, мөн урьдчилан сэргийлэх төсөлд хөрөнгө мөнгө гаргах тухайд хүлээх хариуцлагыг ч тусгаж өгсөн “цомхон хуулиуд” байдаг / Кипр, Австри, Дани, Финланд, Швед/
- Шинэ Зеланд, Австри хоёр улс нь гэр бүлийн хүчирхийлэлийн тухай нэлээд “шинэтгэн сайжруулагч” хуультай ажээ.

Европ, Хойд Америкт болзох харилцаатай залуучуудын дунд бэлгийн хүчирхийллийн тархалт эмэгтэйчүүдийн хувьд 1.2-32.9 хувь, эрэгтэйчүүдийн хувьд 1-19 хувь байна.³ Бага болон дунд орлоготой зарим орны хүн амзүй, эрүүл мэндийн мэдээллээр⁴ 15-19 насны охидыг хүч хэрэглэн бэлгийн хавьталд оруулсан тохиолдол Киргиз Улсад хамгийн бага буюу 0 хувь, Камерун Улсад хамгийн их буюу 22 хувь байна. 15-49 насны охид, эмэгтэйчүүдийн дунд хүч хэрэглэн анхны бэлгийн харьцаанд оруулсан тохиолдол Зүүн Тиморт 1 хувь, Балбад 29 хувь байжээ.

Монгол улсад эмэгтэйчүүдийн эрх дэлхийн улсуудаас ямар хэмжээнд байгаа вэ, олон өнцгөөс харж болох ч Монгол Улс дэлхийн түвшинд бол эмэгтэй хүний эрх сайн хангагдсан улс мөн гэж хэлж болохоор байна. Үүнийг хууль, эрх зүйн орчноос харж болохоос гадна, нийт масс хүмүүсийн ахуй, амьдралын хэвшил соёл ёс заншил зэргээс хангалттай харж болно.

Дэлхийн бусад улс орнуудын эмэгтэй хүний эрх Монгол Улсын эмэгтэйчүүдийн эрх хоёрыг харьцуулж харахад маш амархан ба Монгол энэ талаар ази тивдээ тэргүүлэх улсын нэг гэж судлаачид үздэг байна. Энэ амжилтын үндэс мэдээж манай нүүдэлч ахуй соёл дээр барууны соёл иргэншлийг хамгийн сайн шингээж өөрийн болгож авсанд байгаа юм.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гадаадын улс орнуудад маш олон төсөл, хөтөлбөрүүд хэрэгжсээр ирсэн байдаг бөгөөд түүний заримаас нь үзвэл:

Гэрээр зөвлөгөө өгөх сувилагчийн хөтөлбөр⁵

АНУ, Их Британи, Нидерланд улсад “Сувилагч, гэр бүлийн түншлэл” хөтөлбөр бол анхны хүүхдээ төрүүлсэн, голдуу бага орлоготой болон гэрлээгүй эхчүүдэд жирэмсэн ба нярай үеийн үйлчилгээг сувилагч гэрээр үзүүлэх хөтөлбөр юм. АНУ-аас эхтэй уг хөтөлбөр өдгөө Нидерланд, Их Британи зэрэг өндөр орлоготой орнуудад хэрэгжиж байна.

Хөтөлбөрт өмнө нь төрж байгаагүй, голдуу бага орлоготой, гэрлээгүй, өсвөр насны жирэмсэн эмэгтэйчүүдийг хамруулж, сувилагчийн үйлчилгээг гэрээр үзүүлдэг байна. Сувилагч нь жирэмсний үеэс эхлэн хүүхдийг 2 нас хүртэл сард нэг удаа гэрээр нь очно.

Сувилагч эрүүл мэндийн эерэг зан үйл, хүүхэд асрах чадвар, эхчүүдийн хувийн хөгжил (гэр бүл төлөвлөлт, боловсрол сурлагын амжилт, ажил эрхлэлт)-д хувь нэмэр болох зүйлсийг зааж сургадаг байна. Жирэмсний сүүлийн гурван сараас эхлэн хүүхэд 2 нас хүртэл үргэлжлэх хөтөлбөр нь нэг эмэгтэйд 12500 орчим ам. доллар зарцуулдаг. “Сувилагч, гэр бүлийн түншлэл” хөтөлбөрийг санамсаргүй түүврийн загвартай, өөр өөр орон нутаг, хүн амыг хамруулсан 3 судалгаагаар үнэлжээ.

Хүүхэдтэй зүй бус харьцах явдал, гэмтэл 20-50 хувиар буурч, өсвөр ба 20 гаруй насандаа дахин төрөх хувь хэмжээ 10-20 хувиар буурч, боловсрол багатай эсвэл сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай эхчүүдийн хүүхдүүдийн танин мэдэхүй, боловсролын үр дүн сайжирсан⁶ эерэг дүн гарчээ.

1970 онд Англи улсад “Адил тэнцүү цалин хөлсний тухай” хууль батлагдахаас өмнө ижил хөдөлмөр эрхэлдэг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдээс илүү цалин авдаг байсан. 40-өөд жилийн

³ Leen E, Sorbring E, Mawer M, Holdsworth E, Helsing B, Bowen E. Prevalence, dynamic risk factors and the efficacy of primary interventions for adolescent dating violence: An international review. *Aggression and Violent Behavior*. 2013;18(1):159–74

⁴ Hidden in plain sight: A statistical analysis of violence against children. UNICEF: New York; 2014. 18. Zohoori N, Ward E, Gordon G, Wilks R, Ashley D, Forrester T. Non-fatal violence-related injuries in Kingston, Jamaica: a preventable drain on resources. *Injury Control and Safety Promotion*. 2002;9(4):255–62.

⁵ Olds DL. Preventing child maltreatment and crime with prenatal and infancy support of parents: the nurse-family partnership. *J Scand Stud Criminol Crime Prev*. 2008;9(S1):2– 24

⁶ Olds DL. Preventing child maltreatment and crime with prenatal and infancy support of parents: the nurse-family partnership. *J Scand Stud Criminol Crime Prev*. 2008;9(S1):2– 24

өмнөөс ажил эрхлэлт дээр эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийн тэгш эрхийг зөрчих зөрчил эрс байгассан гэж үздэг.⁷ Ийм хэдий ч эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах асуудал түвэгтэй хэвээр байна. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг төрөөс хангахын тулд “Хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг” хууль гаргаснаар тэр бүхнийг шийдвэрлэх боломжгүй.⁸

Эцэг, эхийн боловсролын хөтөлбөр

Энэ хөтөлбөр нь хөгжиж буй орнуудад үр дүнтэй хэрэгжих боломжтойг харуулсан туршлага бий болж байна. Хөгжиж буй 9 оронд хийсэн 12 судалгааны тоймд⁹ эцэг эхийн боловсролыг дэмжсэн янз бүрийн үйл ажиллагаа, арга хэмжээг агуулсан стратегиуд үр дүн сайтай байх магадлалтай гэж дүгнэжээ.

Эцэг эхийн боловсролын хөтөлбөрийг ихэвчлэн нийгмийн ажилтан, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтэн, эсвэл бэлтгэгдсэн мэргэжлийн бус хүний удирдлага дор голдуу бүлгээр, эрчимтэй дэмжлэг, туслалцаа шаардлагатай гэр бүлд ганцаарчилсан хэлбэрээр хэрэгжүүлдэг.

Эцэг эхийн боловсролын хөтөлбөр нь богино буюу 3 сар хүртэлх хугацаатай, долоо хоногт нэг удаагийн давтамжтай үйлчилгээ хүргэдэг. Хөтөлбөрүүд дотроо хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэгтэй байдаг ба бүх эцэг эхийг хамруулсан үйл ажиллагаанаас гадна илүү дэмжлэг шаардах бүлэг эцэг эхийг тусгайлан хамруулсан үйл ажиллагааг багтаана. Бурунди, Өмнөд Африкийн туршлага Бурунди Улсад 12 настай хүүхдийн зан үйл, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах зорилготой эцэг эхийн боловсролын богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлжээ.¹⁰

Хөтөлбөр нь тус бүр 20 оролцогчтой, сэтгэлзүй, боловсролын агуулгатай, 2.5-3 цагийн хоёр семинараас бүрдэж байв. Эхний семинар нь хүүхдийн сэтгэлзүй, сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэлтэй болгох, хоёр дахь семинар нь эцэг эхчүүдийн ашигладаг хүмүүжлийн болон асуудал шийдэх аргууд, ялангуяа бие махбодын хатуу шийтгэл ашиглахаас зайлсхийх асуудалд төвлөрчээ.

Семинарыг орон нутгийн мэргэжлийн бус хоёр зөвлөх удирдан явуулсан ба тэднийг 3 сарын хугацаанд сургаж бэлтгэсэн байна. Энэ арга хэмжээг эцэг эхийн асуулгаар үнэлж үзэхэд хүүхдүүдийн, ялангуяа хөвгүүдийн хүмүүжлийн доголдол буурсан дүнтэй байсан ба эцэг эхчүүд хөтөлбөрийг эергээр үнэлсэн байв.

“Насан туршийн эрүүл мэндийг тэтгэх гэр бүлийн хүмүүжил” төсөл

Өмнөд Африкийн “Насан туршийн эрүүл мэндийг тэтгэх гэр бүлийн хүмүүжил” төсөл нь хязгаарлагдмал нөөцтэй орчинд хэрэгжүүлэх өртөг зардал багатай, ашгийн төлөө бус, үр дүн нь нотлогдсон эцэг эхийн боловсролын хөтөлбөр боловсруулж, туршин өргөн хүрээнд тараан түгээх зорилготой.

Багц хөтөлбөр нь хүүхэдтэй зүй бус харьцахаас урьдчилан сэргийлж, улмаар цаашдын амьдралдаа үе тэнгийн дарамт дээрэлхэлт, бэлгийн хамтрагчийн хүчирхийлэл үйлдэхээс сэргийлэх зорилготой бөгөөд асуудал шийдвэрлэх багийн ажил, хүчирхийллийн бус хүмүүжлийн эерэг аргууд, хүүхдийг түр хугацаагаар “завсарлуулах” арга, түүнийг ашиглахтай холбоотой зөвлөгөө, хүүхэд өсгөхөд хэрэгтэй ур чадварууд эзэмшүүлэх дадлага ажил зэргийг багтаадаг.

Хөтөлбөрт хамрагдсан эцэг эхчүүдийн хувьд хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргуудыг илүүтэй ашиглаж, хатуу ширүүн аргуудыг бага хэрэглэх, хүүхдэд тавих эцэг эхийн хараа хяналт сайжрах, шийтгэлийн бус аргуудыг илүү хэрэглэх, стресс багасаж сэтгэцийн эрүүл мэнд сайжрах үр дүн гарсан байхад төслийн үндсэн зорилго оршиж байна.

Төслийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг үнэлэх зорилготой судалгааны эхний шатны дүгнэлтээс харахад эцэг эхийн хамрагдалт сайн, дундаас нь гарах явдал бага байсан ба төсөл нь эцэг эхчүүдийг хүүхэд хүмүүжүүлэх эерэг, шийтгэлийн бус аргуудыг давамгайл ашиглахад чиглүүлж чадаж байна гэсэн эерэг төлөв ажиглагджээ.¹¹

⁷ Минжүүрдорж. Б. Даяаршиж буй дэлхий: Харьцуулсан эрх зүй судлал. УБ. 2010 он. 50-р тал

⁸ /Barbara R. Bergmann, cited in Justise, Gender, and Family, 153/

⁹ Knerr W, Gardner F, Cluver L. Improving positive parenting skills and reducing harsh and abusive parenting in low- and middle-income countries: A systematic review. Prev Sci. 2013; DOI 10.1007/ s11212-012-0314-1.

¹⁰ Jordans MJ, Tol W, Ndayisaba A, Komproe I. A controlled evaluation of a brief parenting psychoeducation intervention in Burundi. Social Psychiatry and Psychiatric Epidemiology. 2013;48(11):1851–9.

¹¹ Parenting for Lifelong Health 2015. Geneva: World Health Organization; 2015 ([http:// www.who.int/violence_injury_prevention/violence/child/plh/en/](http://www.who.int/violence_injury_prevention/violence/child/plh/en/), accessed 3 June 2015).

Төвөөр дамжуулан хэрэгжих хөтөлбөрүүдийн дундаас эрсдэлт бүлгийн хүүхэд, гэр бүлд чиглэсэн, мөн эцэг эхийн боловсролын асуудалд анхаарсан хөтөлбөрүүд илүү үр нөлөөтэй байх хандлага ажиглагджээ. Мөн ганцаарчилсан болон бүлгээр ажиллах аргазүйг хослуулсан хөтөлбөр нь аль нэг аргыг дангаар ашигласан хөтөлбөрөөс илүү үр дүнтэй байгааг судалгаа тогтоожээ.¹²

Бага, дунд орлоготой Бангладеш, Бразил, Ямаик, Кени, Мавритус, төв Азийн хэд хэдэн улсад олон бүрэлдэхүүн хэсэгтэй Бага насны хүүхдийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжиж байна. Гэвч бага, дунд орлоготой оронд хэрэгжсэн хөтөлбөрийн үр дүнгийн үнэлгээ хийсэн нь цөөн байна.¹³

“Сургууль, гэр бүл хамтдаа” хөтөлбөр

Олон гэр бүлийг нэг зэрэг хамруулдаг “Сургууль, гэр бүл хамтдаа” (Families and Schools Together буюу FAST) хөтөлбөр нь нэг ангийн түвшний бүх хүүхэд, тэдний гэр бүлийнхэнд зориулсан 8 долоо хоногийн хичээлийн дараах үйл ажиллагаа юм.

Хөтөлбөр нь эцэг эх, гэр бүлийн бусад хүмүүс, сургууль, орон нутгийн иргэдийг нэг дор цуглуулж, хүүхдийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэхийн тулд орон нутаг даяараа харилцаа холбоотой байж, стрессээс хамгаалдаг хүчин зүйлсийг бэхжүүлэх зорилготой үйл ажиллагааг хамтран хийх боломж олгодог.

Хөтөлбөрт хамрагдагсад хичээлийн дараа гэр бүлээрээ сургууль дээр ирж, хамт хооллоод, нийтийн арга хэмжээнд оролцдог. Нэг удаагийн хөтөлбөрт 80 хүртэлх тооны гэр бүл хамрагдан 10, 10-аараа бүлэг болж хуваагдаад, оногдсон ангид орж ажиллана. Бүлэг бүрийг тусгайлан бэлтгэгдсэн баг удирдан чиглүүлэх ба энэ багт эцэг эх, ахлах ангийн сурагч, сургуулийн ажилтан, мөн сэтгэцийн эрүүл мэнд, мансууруулах бодисын даслыг эмчлэх чиглэлийн мэргэжилтэн зэрэг хүмүүс багтана.

Багш, сургалтын менежер нь эцэг эхчүүдээ дэмжин, бүлгийн ажилд наад зах нь нэг удаа заавал оролцохыг уриалан ажилладаг байна. Шинээр шилжиж ирсэн сурагчдын гэр бүл уг хөтөлбөрт оролцон, хүүхдийнхээ нэг ангийнхны эцэг эх, гэр бүлийнхэнтэй танилцахын зэрэгцээ хүүхдэдээ нэмэлт цаг гаргаж, дэмжин ажиллах боломжтой болдог. Хөтөлбөрийн зорилго нь:

- Гэр бүлийн эв нэгдэл, эцэг эх, хүүхдийн холбоог бэхжүүлэх;
- Хүүхдийн сургууль дээрх амжилтыг бэхжүүлэх;
- Гэр бүлийн хүрээнд согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах;
- Гэр бүлийн стресс, нийгмээс тусгаарлагдах байдлыг багасгах¹⁴ зэрэг болно.

Гэр бүлийн чадварыг хөгжүүлэх замаар залуу хүмүүсийн дундах хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах дэлхий нийтийн санаачилгын хүрээнд НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн алба “Сургууль, гэр бүл хамтдаа” хөтөлбөрийг Казахстан, Киргизстан, Тажикстан улсуудын есөн бага сургуульд хэрэгжүүлжээ.¹⁵

Хөтөлбөрийн үр дүнд гэр бүлийн эв нэгдэл 21 хувиар сайжирч, гэр бүл дэх зөрчил 52 хувиар бууран, эцэг эх, хүүхдийн холбооны чанар, бат бөх байдал 27 хувиар, нийгмийн харилцаан дахь хүүхдийн найрсаг байдал 44 хувиар өсөж, сахилга батын зөрчил, хэт хөдөлгөөншил 7 хувиар буурсан гэж эцэг эхчүүд мэдээлжээ.¹⁶

¹² Bilukha O, Hahn RA, Crosby A, Fullilove MT, Liberman A, Moscicki E et al. The effectiveness of early childhood home visitation in preventing violence – a systematic review. *American Journal of Preventive Medicine*. 2005;28(2):11–39

¹³ Coren E, Barlow J, Stewart-Brown S. The effectiveness of individual and group-based parenting programmes in improving outcomes for teenage mothers and their children: a systematic review. *Journal of Adolescence*. 2003;26(1):79–103.

Mikton C, Butchart A. Child maltreatment prevention: a systematic review of reviews. *Bull World Health Organ*. 2009;87(5):353–61.

¹⁴ Compilation of evidence-based family skills training programmes. Vienna: UN Office on Drugs and Crime; 2010.

¹⁵ McDonald L, Doostgharin T. UNODC Global Family Skills Initiative. *Social Work and Social Sciences Review*. 2013;16(2):51–75.

Maalouf W, Campello G. The influence of family skills programmes on violence indicators: Experience from a multi-site project of the United Nations Office on Drugs and Crime in low- and middle-income countries. *Aggression and Violent Behavior*. 2014;19(6):616–24.

¹⁶ Maalouf W, Campello G. The influence of family skills programmes on violence indicators: Experience from a multi-site project of the United Nations Office on Drugs and Crime in low- and middle-income countries. *Aggression and Violent Behavior*. 2014;19(6):616–24.

Хөтөлбөр хэрэгжсэнээр эцэг эхчүүд хүүхдийнхээ хичээл, сургалтад илүү оролцох болж, хүүхдүүдийн сургууль дээрх зан үйл сайжирсан гэж багш нар үзжээ.

Амьдрах ухааны болон нийгмийн харилцааны ур чадвар нь сургууль, хөдөлмөрийн талбар дахь амжилтын суурь болж, улмаар өсвөр болон залуу насандаа хүчирхийлэлд холбогдохоос хамгаалах хүчин зүйл болдог байна.

Амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөрүүд нь нийгмийн харилцааны явцад гардаг зөрчил, сөргөлдөөнийг үр нөлөөтэй, хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэхэд хүүхэд, залуучуудыг сургах зорилготой. Амьдрах ухааны ур чадвар эзэмшүүлэх зарим хөтөлбөр сургуулийн бүх хүүхдийг хамруулдаг бол зарим нь түрэмгий дээрэнгүй зан үйл гаргадаг хүүхдүүдийг сонгон хамруулдаг.¹⁷

Колумб Улсад хэрэгжсэн амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх сургалт

Сургуульд түшиглэсэн амьдрах ухааны ур чадвар хөгжүүлэх “Амар тайван анги танхим” (Aulas en Paz) хөтөлбөрийг Колумб Улсын 27 сургуульд хэрэгжүүлжээ. Хөтөлбөр нь 3 үндсэн хэсэгтэй.

Эхний хэсэгт амьдрах ухааны ур чадвар, бусдыг ойлгож хандах, уур уцаараа хянаж удирдах, идэвхтэй сонсох ур чадварыг хүүхдүүдэд зааж, дадлага хийлгэжээ.

Хоёр дахь хэсэг нь эцэг эх, асран хамгаалагчдад зориулагдсан ба тэд жилийн туршид 4 удаагийн сургалт семинарт оролцон, хүүхэд залуучуудын хөгжил, зөрчлийг шийдвэрлэх аргуудад суралцжээ. Үүний зэрэгцээ, өмнө нь түрэмгий зан үйл гаргаж, хэрэг зөрчилд холбогдож байсан хүүхдүүдийн эцэг эхчүүдэд жилд 4 удаа гэрээр нь очиж зөвлөгөө өгөн, долоо хоног бүр утсаар холбогддог байна.

Гурав дахь хэсэг нь түрэмгий зан үйл гаргадаг хүүхдүүдэд түрэмгий бус зан үйлийн сайн загварыг ажиглаж, суралцах боломж олгох зорилгоор сахилга бат сайтай хүүхдүүдтэй нэг бүлэг, баг болгон ажиллуулах үйл ажиллагаа юм.

Хөтөлбөр нь нэг жилийн 40 удаагийн хичээлээс бүрдэх ба хичээл бүр нь 45 минут үргэлжилнэ. Хөтөлбөрийн эхэн болон төгсгөлд хийсэн үнэлгээгээр хүүхдүүдийн дунд түрэмгий зан үйл буурч, сахилга бат сайжирсан байжээ.¹⁸

Үе тэнгийн дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх Испани Улсын туршлага

“Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг Севиллийн их сургуулийн төсөл” (The Proyecto Sevilla Antiviolenencia Escolar) нь үе тэнгийнхний дарамт дээрэлхэлтийг урьдчилан сэргийлэх зорилгоор Испанийн 29 орон нутагт хэрэгжүүлсэн хөтөлбөр юм.

Уг хөтөлбөрийн хүрээнд үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудлыг сургуулийн хэмжээнд хариуцах элч буюу тусгайлсан ажилтан томилох, сургалтын агуулгыг шинэчлэх, сургуулийн бүх хүүхдийг нийгмийн харилцааны ур чадвар, энэрэнгүй хандлага хөгжүүлэх сургалтад хамруулах, мөн бусдыг дээрэлхэх үйлдэлд оролцсон сурагчдыг эрчимтэй хөтөлбөрт хамруулах зэрэг үйл ажиллагаа багтжээ.

Хөтөлбөрийн үр дүнг үнэлэх зорилгоор санамсаргүй түүврийн аргаар 4900 сурагчийг сонгон судалгаа авсан ба уг хөтөлбөр нь үе тэнгийн дарамт, дээрэлхэлтэд өртөх явдлыг 25 - аас 15 хувь болгож бууруулсан дүн гарчээ.¹⁹

Танзани Улсын Занзибарт хэрэгжүүлсэн хичээл сурлага дэмжих радио хөтөлбөр

Занзибарын “Боловсролыг бэхжүүлэх радио хичээл” хөтөлбөр нь хүрч үйлчлэхэд хэцүү хүн амд боловсролын үйлчилгээг амжилттай хүргэж байгаагийн жишээ юм. Алслагдсан орон нутгуудад бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээг хүргэх хэд хэдэн загварыг боловсруулж, турших зорилготой уг төслийг Занзибар мужийн Боловсролын яам болон Мэргэжлийн сургалт, боловсролын хөгжлийн төв хамтран хэрэгжүүлж байна.

Хөтөлбөрийн хүрээнд хэл ярианы хөгжил, тоо, амьдрах ухааны хичээлүүдийг радиоогоор зааж байна. Одоогийн байдлаар хөтөлбөрийн зөвхөн боловсролын үр нөлөөг үнэлээд байгаа ба цаашид энэ хөтөлбөр хүүхэд өсөж том болохын хэрээр өсвөр болон залуу

¹⁷ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. УБ.2017. 36 дахь тал

¹⁸ Chau E. Aulas en Paz: A multicomponent program for the promotion of peaceful relationships and citizenship competencies. Conflict Resolution Quarterly. 2007;25(1):79– 86

¹⁹ Ortega R, Del Rey R. Aciertos y desaciertos del proyecto Sevilla Anti-violencia Escolar (SAVE). Revista de educación. 2001;324:253–70.

насандaa хүчирхийлэлд холбогдохоос хамгаалж чадаж байгаа эсэхийг судалж тогтоох хэрэгтэй байна.²⁰

Өмнөд Африк, Танзани Улсад хэрэгжүүлсэн болзооны харилцаан дах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх хөтөлбөр

Өмнөд болон Зүүн Африкийн бүсийн өсвөр насныхны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх төсөл нь 12-14 насны хүүхдүүдэд эрүүл аюулгүй бэлгийн зан үйл төлөвшүүлэх зорилгоор сургуульд түшиглэсэн шинэлэг хөтөлбөрүүд боловсруулан, хэрэгжүүлэх зорилготой.

Төслийн үндсэн зорилго нь бэлгийн замаар дамжих халдвар, өсвөр насныхны дундах бэлгийн харилцагчийн хүчирхийллийг урьдчилан сэргийлэх явдал юм. Өсвөр насныхны дунд хийсэн явцын судалгаа, бусад судалгааны дүнд тулгуурлан төслөөс сурагчдыг эрүүл аюулгүй бэлгийн зан үйлд сургах зорилгоор хөтөлбөр боловсруулж, туршин сайжруулснаа Кейп Таун, Дар эс Салаам хотын сургуулиудад хэрэгжүүлэхээр бэлтгэлээ хангаад байна. Хөтөлбөрийг боловсруулахдаа чанарын болон тооны үзүүлэлтээр хөтөлбөрийн явцыг үнэлэх боломжтой байхаар төлөвлөжээ.²¹

Мексик: Сургуулиа төгсөх нөхцөлтэй залуучуудын урамшууллын хөтөлбөр

Опортунидадес (Боломж) хөтөлбөр бол Мексикийн ядуурлыг бууруулах үндсэн хөтөлбөр юм. Хөтөлбөр нь өрхийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор мөнгөн тэтгэмж олгодог ба үүнд тухайн өрхийн 22 хүртэлх насны хүүхдүүдэд сургуулиа төгсөх нөхцөлтэйгөөр олгох боловсролын тэтгэмж багтдаг.

Хэд хэдэн удаагийн үнэлгээгээр уг хөтөлбөр нь залуучуудын сургуульд хамрагдалт, сургуульд суралцах нийт жил, сургууль завсардалтын хувь хэмжээ, ажил олох магадлал зэрэгт эерэг нөлөө үзүүлсэн дүн гарчээ. 1997 онд хөдөөний ядуу орон нутгуудад хэрэгжиж эхэлсэн уг хөтөлбөр яваандаа хот суурин газрыг хамруулан тэлсээр, одоо дөрвөн сая орчим өрхөд хүрч үйлчилж байна.²²

АНУ: Үе тэнгийн зуучлал “Үе тэнгийнхэн амар амгаланг бий болгоно” хөтөлбөр

Энэ нь бага, дунд сургуулийн сурагчдыг хамруулсан сургуульд түшиглэсэн үе тэнгийн зуучлалын хөтөлбөр юм. Хөтөлбөрийн зохицуулалтыг хариуцах үүрэгтэй насанд хүрэгчид буюу багш, сургуулийн сэтгэл зүйч, эмч зэрэг хүмүүс 3 өдрийн сургалтад хамрагдаж, үе тэнгийн зуучлагчаар ажиллах сурагчдыг сургаж бэлтгэх арга зүй эзэмшинэ.

Үе тэнгийн зуучлагчид нь анги хамт олноосоо сонгогдсон 15-24 сурагчаас бүрдсэн баг байна. Хөтөлбөрийн зохицуулагч нэг хичээлийн жилдээ тус бүр 3-5 цагийн нийт 3 удаагийн сургалтыг үе тэнгийн зуучлагчдад хийнэ.

Сургалтаар үе тэнгийн зуучлагчид бусдад хэрхэн үлгэрлэх, харилцааны явцад үүссэн зөрчлийг хүчирхийлэлгүйгээр шийдвэрлэх чадвар сул үе тэнгийн хүүхдүүддээ эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ хэрхэн үзүүлэх зэрэгт суралцана.

Санамсаргүй түүврийн аргаар хөтөлбөрийн оролцогчдыг хяналтын бүлэгтэй харьцуулсан хоёр ч удаагийн үнэлгээгээр хөтөлбөр хэрэгжүүлсэн сургуулийн дүүргүүдэд сахилгын шийтгэл, зодоон, хичээл таслалтын тоо хэмжээ буурсан дүн гарчээ. Хөтөлбөрт оролцогчдын аюулгүй байдлын мэдрэмж, өөрийн чадварт итгэх итгэл, өөрийгөө хүндлэх сэтгэл зэрэг нь хяналтын бүлэгтэй харьцуулахад өссөн дүнтэй гарчээ.²³

Бразил Улсын залуучуудын хичээлийн бус цагийн хөтөлбөр

Абриндо Эспасос (Нээлттэй сургууль) хөтөлбөрийг ЮНЕСКО, Бразилийн Боловсролын Яам хамтран “Нээлттэй сургууль: залуучуудын боловсрол, соёл, урлаг, спорт, ажил хөдөлмөрийн хөтөлбөр” нэртэй бодлогын хүрээнд 2004 оноос хэрэгжүүлжээ. Хөтөлбөр нь амралтын өдрөөр залуучуудад зориулсан спорт, соёл, урлаг, чөлөөт цагийн арга хэмжээ, анхан шатны мэргэжлийн боловсрол олгох сургалтууд зохион байгуулдаг байна. Хөтөлбөрийн дундаж зардал нь нэг сардаа нэг сурагчид 1-2 ам доллар байдаг.

²⁰ Education Development Center. Radio Instruction to Strengthen Education (RISE). Report. Dar es Salam:2010.

²¹ PREPARE. Promoting Sexual and Reproductive Health among adolescents in southern and eastern Africa 2014 [website] (<http://prepare.b.uib.no/>, accessed 3 June 2015).

²² Fernald LC, Gertler PJ, Neufeld LM. 10-year effect of Oportunidades, Mexico's conditional cash transfer programme, on child growth, cognition, language, and behaviour: a longitudinal followup study. The Lancet. 2009;374(9706):1997–2005.

²³ Landry R. Peers making peace: Evaluation report. Houston, TX: Research and Educational Services; 2003.

Үнэлгээгээр хөтөлбөрт хамрагдсан сургуулиудын дотор болон гадуур орчинд хүчирхийллийн гаралт бусад сургуулиас бага байгаа нь тогтоогджээ. Сан-Паоло хот 2003-2006 онд “Нээлттэй сургууль” хөтөлбөрийг 5306 сургуульд хэрэгжүүлсний дараа гэмт хэрэг 46 хувиар буурчээ. Рио-де-Жанейро хотод “Нээлттэй сургууль” хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 12 сарын дараа үнэлгээ хийхэд хөтөлбөрийн сургуулиуд бусад сургуулиас хүчирхийллийн түвшнээр 31 хувиар бага гарсан ч хоёр төрлийн сургуулийн хүчирхийллийн түвшнийг хөтөлбөр эхлэхээс өмнө ямар хэмжээнд байсныг тодорхойлоогүй байжээ.²⁴

Эмчилгээ заслын хөтөлбөр

Уг хөтөлбөрт түрэмгий зан гаргаж, хүчирхийлэл үйлдэж байсан, эсвэл ийм зан байдал гаргах өндөр эрсдэлтэй залуучуудад хандсан танин мэдэхүй, зан үйлийн, сэтгэл зүй, харилцааны ур чадвар хөгжүүлэх зорилготой эмчилгээ заслын аргууд багтдаг.

Эмчилгээ заслын хөтөлбөрүүд нь ганцаарчилсан юмуу бүлгийн зохион байгуулалттай байх ба залуучуудын нийгмийн хүрээлэл, гэр бүлийг нь давхар хамруулах боломжтой. Хөтөлбөрийн үйл ажиллагааг мэргэшсэн засалч, нийгмийн ажилтан, заримдаа сургалтад хамрагдсан сайн дурынхан хэрэгжүүлдэг.²⁵

Логик сэтгэлгээ, сэргээн заслын олон улсын хөтөлбөр

Хүчирхийлэлд холбогдох эрсдэлтэй залуучууд, насанд хүрээгүй гэмт хэрэгтнүүдэд чиглэсэн олон бүрдэлт “Логик сэтгэлгээ, сэргээн засал” хөтөлбөр нь зан үйлийн эерэг сонголт хийж заншихад нь тус болох танин мэдэхүйн ур чадваруудыг хөгжүүлэх зорилготой бөгөөд 20 улсад хэрэгжиж байна.

Хөтөлбөр нь 6-12 хүнтэй бүлгээр долоо хоног бүр 2-4 удаа 2 цагаар хичээллэх нийт 36 удаагийн сургалтаас бүрдэнэ. Сургалтад нийгмийн харилцааны ур чадвар, зөвшилцөх чадвар, сэтгэл хөдлөлийн хяналт зохицуулалт, үнэт зүйл ба шүүмжлэлт үндэслэл гаргах ур чадвар хөгжүүлэх зорилгоор дүрд тоглох, сэтгэн бодох, суралцах тоглоом, дасгалуудыг ашигладаг.²⁶

Анх Канадад боловсруулан хэрэгжүүлсэн уг хөтөлбөр 20 улсад хэрэгжсэнээс Финлянд, Герман, Исланд, Иран, Их Британи улсуудад хөтөлбөрийн үнэлгээ хийгджээ. Мета шинжилгээгээр хөтөлбөрт оролцогчдын дунд давтан гэмт хэрэг 14 хувиар буурсан дүн гарчээ. Хөтөлбөрийн үнэлгээнүүдийн зарим нь л хүчирхийллийг бууруулах асуудлыг авч үзсэн байх ба Канадад хөтөлбөрт оролцогчдын дунд хүчирхийлэлт гэмт хэрэг дахин үйлдсэний улмаас баривчлагдах магадлал 49 хувиар буурсан тооцоо гарчээ.²⁷

Залуучуудын мэргэжлийн сургалтын хөтөлбөр

Аргентин, Чили, Доминиканы Бүгд Найрамдах Улсад “Залуус” (JÓvenes) хөтөлбөр бол эмзэг бүлгийн залуучуудад ажлын туршлагатай болох боломж олгон, ажил хайхад нь тусалж, зөвлөгөө өгч, амьдрах ухааны ур чадварт сургадаг хөтөлбөр юм. Уг хөтөлбөр анх Чилид эхэлсэн ба улмаар Аргентин, Доминиканы Бүгд Найрамдах Улс авч хэрэгжүүлээд байна.

Хөтөлбөрийн үнэлгээгээр оролцогчид нь хяналтын бүлгийнхэнтэй харьцуулахад ажил олох илүү өндөр магадлалтай, яваандаа илүү өндөр цалин авч байсан дүн гарчээ. Улс орон, оролцогчийн нас, хүйсээс хамааран хөдөлмөр эрхлэлтийн түвшин 10 хувь байснаас 26 хувь болж нэмэгдсэн байв. Ерөнхийдөө насаар залуу, мөн эмэгтэй оролцогчид ажилд орох илүү магадлалтай байжээ.²⁸ Хөтөлбөр нь залуучуудыг хүчирхийллээс хамгаалах нөлөө үзүүлж байгаа эсэхийг одоогоор үнэлж үзээгүй байна.

Зөвлөн дэмжих менторын хөтөлбөр

²⁴ Abramovay M. Abrindo espaços Bahia: avaliação do programa: UNESCO: Observatório de Violências nas Escolas: Universidade Católica de Brasília: UNIRIO; 2003 ([http:// unesdoc.unesco.org/images/0013/001313/131368por.pdf](http://unesdoc.unesco.org/images/0013/001313/131368por.pdf), accessed 11 June 2015).

²⁵ Залуучуудын дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэх нь: нотлох баримтын тойм. УБ.2017. 52 дахь тал

²⁶ Ross RR, Ross R. Thinking straight: The reasoning and rehabilitation program for delinquency prevention and offender rehabilitation. Air Training & Publications; 1995.

²⁷ Joy Tong L, Farrington DP. How effective is the “Reasoning and Rehabilitation” programme in reducing reoffending? A meta-analysis of evaluations in four countries. Psychology, Crime & Law. 2006;12(1):3–24.

²⁸ Cunningham W, Cohan LM, Naudeau S, McGinnis L. Supporting youth at risk: A policy toolkit for middle-income countries. Washington D.C.: World Bank; 2008.

Зөвлөн дэмжих менторын ажил гэж арвин туршлагатай хүн өөрийн мэдлэг, туршлага, мэдээлэл, үзэл бодлоо хуваалцах замаар залуу хүний эерэг хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой түншлэлийг хэлдэг.²⁹

Менторын зарим хөтөлбөр хүүхдийн сурлагын амжилтыг ахиулах, эсвэл хүчирхийллээс сэргийлэх гэх мэт тодорхой зорилт дэвшүүлэн ажилладаг бол зарим нь хамгаалах хүчин зүйлсийг бэхжүүлж, эрсдэлт хүчин зүйлсийг багасгах чиглэлийг баримтлан өсвөр насны хүүхэд, залуу хүмүүсийн эрүүл, эерэг хөгжлийг дэмжих ерөнхий зорилгын хүрээнд ажилладаг.

“Том ах, том эгч” зөвлөн дэмжих хөтөлбөр

“Том ах, том эгч” хөтөлбөр нь өнөөдрийн байдлаар Бермуд, Болгар, Израиль, Оросын Холбооны Улс, Баруун Европ, Хойд Америкийн хэд хэдэн орон зэрэг 12 улсад хэрэгжиж байна. Хөтөлбөр нь зөвлөгч, зөвлүүлэгчийн хооронд дэмжин туслах чин хүсэлд суурилсан халамжит, энэрэнгүй харилцаа бий болно гэсэн хүлээлтээр насанд хүрсэн сайн дурын зөвлөгчийг өсвөр насны зөвлүүлэгч хүүхэдтэй тохируулан сонгон ажиллуулдаг.

Тохируулах сонголтууд хийгдсэний дараа мэргэжлийн бэлтгэл хангасан хөтөлбөрийн ажилтан тэдний харилцаа, хамтын ажиллагаанд мониторинг хийн, хянаж ажиллана. Нэг зөвлөгч нэг л хүүхэдтэй ажиллах ба нэг жил юмуу түүнээс урт хугацааны туршид долоо хоногт 3-5 цагийн ганцаарчилсан уулзалт хийдэг.

Зорилтуудаа зөвлөн дэмжих харилцаа эхлэх үед хүүхэд, түүний эцэг эх, зөвлөгч хамтран тодорхойлох ба асуудалтай зан үйл, хичээл таслалт, сурлагын амжилт, бусад хүүхэдтэй холбоо харилцаа тогтоох зэрэг асуудлаар, эсвэл шинэ ур чадварт суралцах зэрэг байх жишээтэй. Тодорхой кейсд хяналт тавих үүрэгтэй кейс менежер нь зөвлөгч, зөвлүүлэгчтэй байнгын холбоотой байж, харилцаа хэрхэн хөгжиж байгааг тогтмол ажиглаж үнэлнэ. Тус хөтөлбөр нь согтууруулах ундаа, мансууруулах бодисын хэрэглээ, бие махбодын хүчирхийлэл, хичээл таслалтыг бууруулах, хүүхэд, эцэг эхийн харилцааны чанарыг сайжруулах нөлөө үзүүлж байгаа нь нотлогдоод байна.³⁰

Кардифф хотын загвар

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Кардиффын загвараар³¹ хүчирхийллээс үүдсэн гэмтлийн улмаас эмнэлгийн яаралтай тусламж үзүүлсэн тохиолдол бүрт хүний нэрээс бусад “хэн, юу, хэзээ, хаана, яаж” гэсэн мэдээллийг цуглуулж, цагдаад бүртгэгдсэн хүчирхийллийн хэргийн мэдээлэлтэй нэгтгэнэ. Эрүүл мэнд ба цагдаагийн байгууллагын мэдээллийг нэгтгэснээр ирээдүйд гарах хүчирхийллийн хэв маягийг урьдчилан таамаглаж, халуун цэгүүдийг нарийвчлал сайтай тогтоох боломжтой болж, цагдан сэргийлэх болон бусад үйл ажиллагааг чиглүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх боломжтой болно.

Өнөөг хүртэл халуун цэгийн цагдан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж иржээ:

- цагдан сэргийлэх зорилтот ажиллагаа буюу тодорхой халуун цэгүүд дэх хүчирхийллийн хэргийн гарах цаг, байршилтай уялдуулан цагдаагийн бие бүрэлдэхүүнийг байршуулах;
- архи, согтууруулах ундаа худалдах зөвшөөрөлтэй, хүчирхийлэлтэй байнга холбогддог үйлчилгээний газруудыг онцгой анхаарал, хяналтдаа авах;
- архины тусгай зөвшөөрөл олгодог өргөдөл шийдвэрлэх, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэдэг байгууллагатай мэдээлэл солилцох;
- тодорхой төрлийн зэвсэгтэй холбоотой эрсдэлийг бууруулахад чиглэсэн стратеги, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх (*жишээлбэл, хуванцар сав ашиглах шаардлага тавих, шилний олдцыг бууруулах, хүйтэн зэвсгийг хураах ажиллагаа*);

²⁹ Tolan P, Henry D, Schoeny M, Bass A. Mentoring Interventions to affect juvenile delinquency and associated problems. Campbell Systematic Reviews. 2008;16.

³⁰ University of Colorado, Boulder?Institute of Behavioral Science,?Center for the Study and Prevention of Violence. Blueprints for healthy youth development 2014 [cited 2014 15.12.2014] (<http://www.blueprintsprograms.com>, accessed 3 June 2015).

³¹ Warburton A, Shepherd JP. Tackling alcohol-related violence in city centres: effect of emergency medicine and police intervention. Emergency Medicine Journal. 2006;23(1):12–7.

- мансууруулах бодис, согтууруулах ундааны хяналт зэрэг нийгмийн эрүүл мэнд, нийгмийн бодлогын нийтийн хөтөлбөрүүдтэй мэдээлэл солилцох (*жишээлбэл, мансууруулах бодис, архины үйлчилгээ*)

Кардиффын загварын үр дүнгийн үнэлгээг хийхдээ Кардифф хотын хэмжээнд тодорхой хугацаанд эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт хандсан хүчирхийлэлтэй холбоотой гэмтэл, цагдаад бүртгэгдсэн хүчирхийллийн хэргийн гаралтыг Их Британийн ижил төстэй нөхцөлтэй ч салбар дамнасан мэдээлэл солилцооны ийм бодлого хэрэгжүүлээгүй хотуудын үзүүлэлттэй харьцуулжээ. Уг үнэлгээгээр бусад хоттой харьцуулахад Кардифф хотын хөтөлбөр нь эмнэлэгт хандалтыг 42 хувиар, цагдаад бүртгэгдсэн гэмтлийн тоог 32 хувиар бууруулж чадсан үр дүн илэрчээ. Мөн үнэлгээгээр гэмтэл учруулаагүй хүчирхийллийн хэргийг (“нийтлэг танхайн хэрэг” гэж нэрлэдэг) цагдаад бүртгүүлэх явдал 38 хувиар нэмэгдсэн дүн гарсан ба үүнийг судлаачид танхайн хэрэг, түүний урьтач нөхцөл байдалд (жишээлбэл, маргаан) цагдаа илүү шуурхай бөгөөд илүү олон давтамжтайгаар хариу үзүүлдэг болж, танхайн хэргийг хохирогч, гэрчүүд мэдээлэх нь нэмэгдэж, улмаар цагдаад хэрэг бүртгэх нь нэмэгдсэнээр тайлбарлажээ.³²

Цаашилбал, Кардиффын хөтөлбөрт зардал, үр ашгийн шинжилгээ хийж, 2007 онд уг хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй бол Кардифф хотын төсөвт хүчирхийллийн улмаас үүсэх байсан эдийн засаг, нийгмийн өртөг зардлаас 6,9 сая фунт хэмнэгдсэнийг тооцоолжээ. Үүнд 2007 онд эрүүл мэндийн үйлчилгээнд зарцуулах байсан 1,25 сая фунт, эрүүгийн шүүхийн тогтолцооноос зарцуулах байсан 1,62 сая фунт багтжээ. Үүнтэй харьцуулахад, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал бага байсан бөгөөд тухайлбал, програм хангамж, урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүдийг бэлдэн шинэчлэхэд 107,769 фунт, хөтөлбөрийн нэг жилийн үйл ажиллагааны зардал 210,433 фунт болжээ (2003 оны үнийн түвшин).

Хөтөлбөр хэрэгжүүлснээр гарсан зардал, нийгмийн өгөөжийн харьцаа 2003-2007 онд нийт дүнгээрээ хөтөлбөрт зарцуулсан нэг фунт бүрт 82 фунтийн өгөөж гарсан гэх ба задалж харвал эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой нэг фунтын зардал нь 14,80 фунтийн өгөөж, эрүүгийн эрх зүйн салбарт зарцуулсан нэг фунт бүрт 19.1 фунтийн өгөөж гарсан байна.³³

Бразил Улсад согтууруулах ундааны олдцыг хязгаарлах арга хэмжээг багтаасан цогц хөтөлбөр хэрэгжүүлэх замаар хүчирхийллийг урьдчилан сэргийлж байгаа нь

Бразилийн Диадема хотод архитай холбоотой хүчирхийллийг бууруулах бүх нийтийн хөтөлбөр хэрэгжүүлжээ.³⁴ Энэ хотод шөнийн цэнгээний газруудыг 23:00 цагт хаах тухай шинэ хууль гаргаж, хотын болон мужийн түвшний цагдаагийн байгууллагууд хамтран авто машин, баар цэнгээний газар, хараа хяналтгүй орчин зэрэг өндөр эрсдэлтэй газруудыг хянах “Нэгдсэн ажиллагаа” төсөл эхлүүлжээ.

Гэмт хэрэг их гардаг газруудад хяналтын камер суурилуулжээ. Мөн хүчирхийлэл үйлдэх өндөр эрсдэлтэй залуучуудыг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах арга хэмжээ авч, сургуулийн амралтаар (үндэсний хэмжээнд залуучуудын өдөөсөн гэмт хэргийн оргил үе) төрөл бүрийн үйл ажиллагаа зохиох чөлөөт цагийн клуб байгуулж, хууль бус мансууруулах бодисын хэрэглээг бууруулах зорилгоор амьдрах ухааны сургалтын хөтөлбөр хэрэгжүүлжээ. Эдгээр санал санаачилгын үр дүнд хүн амины хэрэг 1999 онд 389 байсан бол 2003 онд 167 болж, дээрмийн хэрэг 1999 онд 5192 байсан бол 2003 онд 4368 болж тус тус буурчээ.³⁵

³² Florence C, Shepherd J, Brennan I, Simon T. Effectiveness of anonymised information sharing and use in health service, police, and local government partnership for preventing violence related injury: experimental study and time series analysis. *British Medical Journal*. 2011;342:d3313.

³³ Florence C, Shepherd J, Brennan I, Simon TR. An economic evaluation of anonymised information sharing in a partnership between health services, police and local government for preventing violence-related injury. *Injury Prevention*. 2014;20(2):108–14.

³⁴ Duailibi S, Ponicki W, Grube J, Pinsky I, Laranjeira R, Raw M. The effect of restricting opening hours on alcohol-related violence. *American Journal of Public Health*. 2007;97(12):2276–80.

³⁵ Shaw M, Travers K, editors. Strategies and best practices in crime prevention, in particular in relation to urban areas and youth at risk. *Proceedings of the workshop held at the Eleventh United Nations Congress on Crime Prevention and Criminal Justice*, Bangkok, Thailand; 2005.

Никарагуад мансууруулах бодистой холбоотой хүчирхийллийг бууруулсан нь

Никарагуагийн цагдаагийн Насанд хүрээгүйчүүдийн асуудал эрхлэх тасаг мансууруулах бодистой холбоотой хүчирхийллийг бууруулах зорилгоор гурван шаттай хөтөлбөр хэрэгжүүлжээ.

Хөтөлбөрийн хүрээнд сургуулийн сурагч хүүхэд, залуучуудад мансууруулах бодис, согтууруулах ундаа, хүчирхийллийн талаар боловсрол олгох сургалтуудыг эрүүл мэндийн боловсролын хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлэх, мансууруулах бодисоос хамааралтай болох, хүчирхийлэлд холбогдох өндөр эрсдэлтэй хүүхэд, өсвөр насныхан, тэдний гэр бүлийнхэнд нийгмийн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, гэмт бүлэглэлийн гишүүн хүүхэд, залуучуудад туслах (жишээлбэл, албан ёсны ажлын байр олоход туслах) зэрэг арга хэмжээ багтжээ. Уг хөтөлбөрийн чанарын үнэлгээгээр боловсролын болон нийгмийн сэтгэл зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэшсэн боловсон хүчин дутагдаж, ажлын байранд зуучлуулсан гэмт бүлэглэлийн гишүүдээс цөөн хэд нь л тогтвортой ажилласан байжээ.³⁶

Колумб Улсын Меделин хотын орчны тохижилтийн төсөл

2004 онд Колумб Улсын Меделин хотын удирдлагууд хотын захын ядуу хорооллуудыг хотын төвтэй холбосон нийтийн тээврийн үйлчилгээ бий болгожээ. Орон нутгийн хөрөнгө оруулалттай зэрэцүүлэн хотын захын хорооллуудад дамжин өнгөрөх тээвэрлэлтийн зориулалттай дэд бүтцийг сайжруулах төсөл хэрэгжсэн байна.

Хөтөлбөрт хамрагдсан хорооллуудыг харьцуулах зорилгоор хамрагдаагүй хороололд хүчирхийллийн хувь хэмжээг орчны тохижилтын хөтөлбөр эхлэхээс өмнө (2003 онд) болон дараа (2008 онд) үнэлсэн бөгөөд үүнд 466 оршин суугчийн урт хугацааны мэдээлэл, Прокурорын газраас авсан хүн амины хэргийн тоо баримтыг ашиглажээ. Тохижилт хийгдсэн хорооллуудад хүн амины хэргийн гаралт бусад хорооллоос 66 хувиар буурч, оршин суугчдын үнэлгээгээр хүчирхийллийн түвшин 75 хувиар буурсан³⁷ байна.

“Боломж руу нүүх” хөдөлбөр

“Боломж руу нүүх” хөтөлбөрийг АНУ-ын Орон сууц, хот байгуулалтын департамент туршилтын журмаар хэрэгжүүлжээ. Таван хотын (Балтимор, Бостон, Чикаго, Лос-Анжелес, Нью-Йорк) ядуу дүүргийн нийтийн сууцанд амьдардаг гэр бүлүүдийн дундаас чинээлэг юмуу дунд түвшний амьдралтай дүүрэг рүү нүүх өрхүүдийг орон сууцны эрхийн бичгийн сугалаагаар сонгожээ. Сугалаанд хожсон өрхүүдээс туршилтын бүлэг үүсгэн, ядуурлын үзүүлэлт нь 10 хувиас хэтрэхгүй хороолол руу нүүх нөхцөлтэй эрхийн бичиг олгожээ. Энэ бүлэгт мөн тохирох хороолол, орон сууц олох талаар зөвлөгөө, дэмжлэгийн үйлчилгээ үзүүлжээ.

Хөтөлбөрийн хоёр дахь бүлэгт суурь стандартад нийцсэн ямар ч орон сууц авах нөхцөлтэй, гэхдээ байршлын хувьд хязгаарлалтгүй буюу өөрсдөө шийдээд хаана ч авч болох нийтлэг эрхийн бичиг олгожээ. Хяналтын бүлэгт эрхийн бичиг өгөөгүй бөгөөд тэд нийгмийн нийтлэг үйлчилгээг ашиглах боломжтой байв. Хөтөлбөрийн үнэлгээгээр төсөл хэрэгжсэнээс хойших эхний 4 жилд туршилтын бүлэгт хүчирхийлэл, хүчирхийлэлт гэмт хэрэг үйлдэн баривчилагдах явдал нэлээд буурсан³⁸ байсан боловч энэ үр дүн урт хугацаандаа тогтвортой хадгалагдаж чадаагүй байна.

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх Альянс байгууллагын Ямаик Улс дахь салбар

2004 онд Ямаик Улсын Эрүүл мэндийн сайд Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх альянс олон улсын сүлжээний салбарыг өөрийн улсдаа байгуулжээ. Нээлтийн ажиллагаан дээр хэлсэн үгэндээ тэрбээр хүчирхийлэл, үүн дундаа залуу хүмүүсийн дундах хүчирхийллийг урьдчилан сэргийлэхэд нийгмийн эрүүл мэндийн арга хандлагаар олон салбарууд хамтран ажиллахын чухлыг онцолжээ.

³⁶ Sistematización del modelo policial comunitario proactivo de Nicaragua. 1st Edition. Managua; Policía Nacional de Nicaragua: 2011 p62 (<http://www.policia.gob.ni/cedoc/sector/revistas/sistematizacion.pdf>, accessed 11 June 2015).

³⁷ Cerda M, Morenoff JD, Hansen BB, Hicks KJT, Duque LF, Restrepo A et al. Reducing violence by transforming neighborhoods: A natural experiment in Medellín, Colombia. *American Journal of Epidemiology*. 2012;175(10):1045–53.

³⁸ Sciandra M, Sanbonmatsu L, Duncan GJ, Gennetian LA, Katz LF, Kessler RC et al. Longterm effects of the Moving to Opportunity residential mobility experiment on crime and delinquency. *Journal of Experimental Criminology*. 2013;9(4):451–89.

Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх альянс нь дэлхий нийтийн хэмжээнд дараах 6 зорилтыг хангахаар ажилладаг байна:

- Хүчирхийллийг урьдчилан сэргийлэхтэй холбоотой мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг эрчимжүүлэх;
- Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх зорилготой үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, хяналт мониторингийг дэмжих;
- Хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл цуглуулах чадавхыг нэмэгдүүлэх;
- Хүчирхийллийн анхан шатны урьдчилан сэргийлэлтийг сурталчлан таниулах;
- Хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг сайжруулах;
- Хүчирхийллийн урьдчилан сэргийлэлтийг нийгмийн болон боловсролын бодлогод суулган хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг юм. Эдгээр зорилтыг хангахын тулд Ямаиц Улсад Хүчирхийллийг урьдчилан сэргийлэх ажлыг удирдах Үндэсний Хороо, мөн оролцогч талуудын төлөөллийг багтаасан Ажлын хэсэг байгуулжээ.³⁹

Дүгнэлт

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр гадаадын олон улс оронд төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр иржээ. Тэдгээр хэрэгжүүлсэн олон төсөл, хөтөлбөрүүд бүгд амжилттай хэрэгжиж чадаагүй ч ихэнхи нь тодорхой үр дүнд хүрсэн нь сайшаалтай байна.

Гэвч төсөл, хөтөлбөрүүд бүрэн хэрэгжиж чадаагүй нь тухайн улс орны үндэсний зан заншил, амьдралын хэвшмэл хандлага, эдийн засгийн чадавхи, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал гэх мэт олон хүчин зүйл нөлөөлдөгтэй салшгүй холбоотой.

Колумб Улсын Меделин хотын орчны тохижилтийн төсөл, Бразил Улсад согтууруулах ундааны олдцыг хязгаарлах арга хэмжээг багтаасан цогц хөтөлбөр, Зөвлөн дэмжих менторын хөтөлбөрүүдийг манай улсад хэрэгжүүлэх боломжтой гэж судлаачийн хувьд үзэж байна.

Санал

Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1. ХЗДХЯамны захиалгаар гадаадын улс орнуудад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдэд судалгаа хийлгэх.
2. Манай улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр цөөнгүй төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд тэдгээрийн нөлөөллийн үр дүнг тооцох судалгааг ДХИС-ийн эрдэмтэн, судлаачдаар хийлгүүлэх.
3. ХЗДХЯам, ДХИС хамтран Колумб Улсын Меделин хотын орчны тохижилтийн төсөл, Бразил Улсад согтууруулах ундааны олдцыг хязгаарлах арга хэмжээг багтаасан цогц хөтөлбөр, Зөвлөн дэмжих менторын хөтөлбөрүүдийг манай улсад хэрэгжүүлэх боломжийг судлах ажлын хэсгийг байгуулж ажиллуулах.

³⁹ Preventing injuries and violence: a guide for ministries of health. Geneva: World Health Organization; 2007.

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО

Э.Батболд

ДХИС-ийн магистрант, цагдаагийн хошууч

Товч агуулга. Гэмт хэрэг, зөрчил гарах боломжийг багасгахад хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах нь үр дүнтэй. Өөрөөр хэлбэл, тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын ажлаар дамжуулж иргэдийн сэтгэл зүйд хүрснээр урьдчилан сэргийлэх ажил маань үр дүнд хүрдэг.

Энэхүү өгүүлэлд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын онол, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллийн байгууллагын ач холбогдол, холбогдох нэр томьёо, түүний агуулга, үр нөлөөг тодорхойлох, Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагын өнөөгийн үүрэг оролцоог тоймлон судаллаа.

Түлхүүр үг. Гэмт хэрэг, зөрчил, хэвлэл мэдээллийн байгууллага, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил.

Үндсэн хэсэг. Монгол Улсад сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтээс харахад эрүүгийн хууль тогтоомжид заасан 200 гаруй гэмт хэргээс цөөн хэдэн төрлийн гэмт хэрэг Монгол Улсад гарч буй нийт гэмт хэргийн 80 гаруй хувийг тогтмол эзэлж байна. Тухайлбал, хулгайлах гэмт хэрэг нийт бүртгэгдэж буй гэмт хэргийн 30 гаруй хувийг, бусдын бие махбодод гэмтэл учруулах төрлийн гэмт хэрэг 30 орчим хувийг, мөн залилан мэхлэх гэмт хэрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг тус тус 10 орчим хувийг эзэлж, харин мансууруулах эм, сэтгэгдэд нөлөөт бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн нийгэмд учруулах хор уршиг, аюул нэмэгдсээр байгаа бөгөөд гэмт үйлдлийн тоо хурдацтай өсөж байна.

Бид хүн амынхаа аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, гэмт явдалтай тэмцэх, гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн дорвитой арга хэмжээнүүдийг авч байх нь өнөөгийн нийгмийн тулгамдаад байгаа томоохон асуудлуудын нэг болоод байна.

Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь иргэдийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аливаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж хамгаалах, хууль зөрчигчдөд хариуцлага тооцох, хэрэг маргааныг таслан шүүх замаар нийгэмд шударга ёс, дэг журмыг тогтооход оршдог. Тиймээс зөвхөн хууль, шүүх эрх мэдлийн байгууллагууд төдийгүй төрийн институтын ямар ч байгууллага үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулж байх ёстой байдаг.

Гэмт хэргийн улмаас 2017 онд 37173 хүн хохирч байсан бол 2019 онд 30782 болж 6391 буюу 17,2 хувиар, 2017 онд гэмт хэргийн улмаас 10513 хүн гэмтсэн бол 2019 онд 8727 болж, 1786 буюу 16,9 хувиар, 2017 онд гэмт хэргийн улмаас 1129 хүн нас барсан бол 2019 онд 930 хүн нас барж, 199 буюу 17,6 хувиар⁴⁰ тус тус буурчээ. Статистикийн эдгээр эерэг үзүүлэлт нь 2019 онд “Нэг хором”, “Ойлгоё, Хүндэлье”, “Unfriend хөдөлгөөн”, “Ятгах тусам нягтал” зэрэг нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион явуулснаар гэмт хэргийн гаралт тодорхой хувиар буурсан гэж үзэж болно. Эдгээр ажил арга хэмжээнүүдийн 80% нь хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажилласан бөгөөд энэ нь иргэдийн ой тоонд тогтож, сэтгэхүйд нөлөөлж чадсан гэсэн үг юм.

Монголын хэвлэлийн хүрээлэнгээс жил бүр тайлан товхимлыг гаргадаг бөгөөд 2020 оны “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр” тайланд багтсан зарим үзүүлэлтээс дурдвал, 2013 оноос хойш мэдээллийн хэрэгслийн тоо жил бүр буурч байсан бол 2018 онд 14-өөр, 2019 онд 45-аар нэмэгдэж 502 болсон⁴¹ байна.

“Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 32 дугаар зүйлд “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг.” гэж хэвлэл мэдээллийн байгууллагын үүргийг тусгайлан тусгасан байна. Тухайлбал, “Хэвлэл мэдээллийн байгууллага гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээ, сурвалжлага хийх, нэвтрүүлэг

⁴⁰ 2020 – Цагаан мэдээ

⁴¹ “Монголын хэвлэл мэдээлэл - Өнөөдөр”, тайлан. УБ.2020 он

бэлтгэхдээ гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг олон нийтэд таниулах, сэрэмжлүүлэхийг гол зорилго болгоно⁴² гэж заасан байдаг. Энэ нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх, практикт хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын бодлого, чиглэл тодорхой хэмжээгээр өөрчлөгдөж, иргэд, олон нийтийн сэтгэл зүйд хүрч ажиллах боломж нөхцөлийг тодорхойлох, гадаад улс орнуудын туршлагыг нэвтрүүлэх, түүнтэй холбоотой судалгааны ажлыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага өнөөдрийг хүртэл байсаар байна.

Олон түмнийг нийтлэл, нэвтрүүлгийн тусламжтайгаар үнэн бодитой мэдээллээр шуурхай, тогтмол хангах зорилго бүхий тогтмол хэвлэл, радио, телевиз, мэдээллийн агентлаг, баримтат кино, цахим хэвлэл зэрэг мэдээллийн сувгийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэж нэрлэдэг.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гаргаж буй мэдээлэл нь үнэн бодитой, тогтмол, шуурхай, хүртээмжтэй, багтаамж сайтай, идэвхтэй, ашигтай, чиглэсэн зорилготой байх зэрэг шинжээрээ бусад бүх төрлийн мэдээллээс ялгардаг.

Мэдээллийн хэрэгсэл бүр өөрийн гэсэн онцлог шинж, давуу талын ачаар мэдээллийн зах зээлд орон зайгаа эзэлж, байнгын хүлээн авагчаа бий болгодог, өрсөлдөх шинэ боломжийг эрж хайдаг, нийтлэл, нэвтрүүлгийг агуулга хэлбэр, ур чадвар, арга барилын хувьд үргэлж шинэчилж, хөгжүүлэн баяжуулж байдаг. Энэ нь оршин тогтнох, амьдрах чадварын эх үндэс болдог байна.

2002 оны Ази номхон далайн телевизүүдийн холбооны чуулган Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бөгөөд энэхүү чуулганд анх контент гэдэг нэр томъёо Монголд нэвтэрсэн бөгөөд контент гэдэг нь бүтээл юм.

Бүтээл нь анимэйшн, кино, телевизийн нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл зэрэг хэлбэр ард иргэдэд хүрч буй бүтээлүүд юм гэж тодорхойлсон ч зарим урлаг судлаачид контент нь **бүтээл** гэхээсээ илүү **агуулга** гэж үзэх нь зөв гэдэг байр суурьтай байдаг. Өөрөөр хэлбэл хэл зүйн шинжлэх ухааны үүднээс тодорхойлж үзвэл Я.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д “Бүтээл - бүтээсэн; уран бүтээл; үр бүтээлтэй ажиллах”⁴³ гэж тайлбарласан байгаа бол агуулгыг “үйл ажиллагааны мөн чанар; ярианы гол санаа, сэдэв”⁴⁴ хэмээн тайлбарласан байгаа нь эрх зүйн зохицуулалтад контентын чанар гэхээсээ илүүтэйгээр үр дүнд илүү анхаарал хандуулсан гэлтэй.

2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн “Соёлын тухай хууль”-д “Үндэсний нэвтрүүлэг”⁴⁵ гэж телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа тухайн нэвтрүүлгийн зохиолч, ерөнхий найруулагч, продюссерийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, сурвалжлах багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх, бүх төрлийн бүтээлийг, “Үндэсний кино” гэж зохиолч, ерөнхий найруулагч, продюссерийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл зураг авалт, дуу бичлэг, эвлүүлгийн багийн бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй хувь нь Монгол Улсын иргэн байх бүх төрлийн кино байхаар заажээ. Түүнчлэн, Олон нийтийн радио, телевизийн нэвтрүүлж байгаа уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 60 хувиас доошгүй нь, хүүхдэд зориулсан уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн 70 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байна. Олон нийтийн телевизээс бусад Монгол Улсад бүртгэлтэй өргөн нэвтрүүлгийн телевиз, радио, кабелийн сувгаар дамжуулж байгаа уран сайхны, нийтлэл, танин мэдэхүйн нэвтрүүлгийн нийт агуулгын 50 хувиас доошгүй нь хүүхдэд зориулсан, нийт агуулгын 60 хувиас доошгүй нь үндэсний нэвтрүүлэг байхаар заасан байдаг. Кино театр, үзвэрийн цэгээр сар тутам түгээх кинонд үндэсний киноны эзлэх хувь, 1P телевизийн уран сайхан, нийтлэл, танин мэдэхүйн видео санд байршсан нийт хөтөлбөрт үндэсний кино, нэвтрүүлгийн цагийн эзлэх хувь 40 хувиас доошгүй байхаар хуульд тусгасан байдаг байна.


⁴² Төрийн мэдээлэл. 2019. №42. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

⁴³ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ.1966. 119 дэх тал.

⁴⁴ Мөн бүтээл. 21 дэх тал. Агуулга гэж 1. Юм үзэгдэл, үйл ажлын мөн чанар: агуулга чанар (дотоод мөн чанар) - Уул явдлын агуулга чанарыг бүгдээрээ хүүрнээ. Ч.Лхамсүрэн. Хурандаа; 2. Ном, зохиолын гол санаа: агуулга сайтай (гол санаа сайн), утга агуулга [хоршоо] (гол санаа)

⁴⁵ Төрийн мэдээлэл. 1996. №7. Соёлын тухай хууль.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын дагуу Харилцаа холбооны тухай хуулийн 8.1, 9.1.2-ийг тус тус үндэслэн иргэн, хуулийн этгээд нь харилцаа холбооны сүлжээгээр “Контентийн үйлчилгээг эрхлэхэд холбогдсон харилцаанд орохдоо” энэхүү зохицуулалтыг баримтална гэжээ.



Харилцаа холбооны зохицуулах хороо нь Харилцаа холбооны тухай хуулиар олгогдсон

бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсад тоон контентийн хөгжлийг дэмжих, зах зээлийн өрсөлдөөний таатай орчныг бүрдүүлэх, нийтийн ашиг сонирхолд нийцсэн, чанартай үйлчилгээгээр олон нийтийг хүртээмжтэй хангахад чиглэсэн харилцааг зохицуулах зорилгоор тоон контентийн зохицуулалт хийдэг. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.16.3-ийн дагуу контентийн зохицуулалт хийж байна.

Тоон контентийн бодлого, зохицуулалтын үндсэн зорилго, зарчим нь :

- Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэмжин хамгаалж, үндэсний ашиг сонирхол, эв нэгдэл, хууль ёсыг дээдлэх;
- Үндэсний аюулгүй байдлыг хангаж, үндэсний үнэт зүйлийг хэвшүүлэх, эх орон, үндэс угсаа, ололт дэвшлээрээ бахархах, үндэсний ашиг сонирхол, ёс зүй, хууль, төрт ёсны үзлийг дээдлэх үнэт зүйл бүхий нийгмийн сэтгэл зүйг төлөвшүүлэхэд тоон контентийн үйлчилгээний хувь нэмэр, оролцоог нэмэгдүүлэх;
- Олон талт, нягт нямбай, шударга, тэнцвэртэй бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг дэмжин хамгаалах;
- Залуу үе, хүүхэд багачуудын хүмүүжил, ёс суртахуунд эерэг нөлөө үзүүлэхүйц контентийг түгээх;
- Бүтээж тууривах, шинэ бүтээл, шинэлэг санаа, санаачилгыг дэмжин, дэлхийн жишигт хүрсэн контентийг бүтээхийг дэмжих;
- Шинэ техник, технологийн хэрэглээг дэмжин хөгжүүлэх, нэвтрүүлэх;
- Нийтийн ашиг сонирхолд нийцсэн чанартай үйлчилгээгээр олон нийтийг хүртээмжтэй хангах.⁴⁶

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсад тоон контентийн үйлчилгээ эрхлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулдаг. Энэхүү ажлын хүрээнд Google Forms – оор нийт 271 иргэд саналаа ирүүлсэн байдаг.


Монгол орны хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн сүүлийн 3 жилээр харьцуулсан судалгаа бөгөөд 2019, 2020 онуудад “Нэг хором”, “Ойлгоё, Хүндэлье”, “Unfriend хөдөлгөөн”, “Ятгах тусам нягтал” зэрэг нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион явуулснаар гэмт хэргийн гаралт тодорхой хувиар буурсан гэж дээрхи судалгааны дүн гарчээ. Эдгээр ажил арга хэмжээнүүдийн 80% нь хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч ажилласан бөгөөд энэ нь иргэдийн ой тоонд тогтож, сэтгэхүйд нөлөөлж чадсан гэсэн үг юм.

⁴⁶ <https://crc.gov.mn/k/1b/1j>

Энэхүү асуулга нь иргэдийн мэдээллийг олж авдаг сувгийг тодорхойлох зорилготой байсан бөгөөд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 241 буюу 88.9% нь Facebook, 199 буюу 73.4% нь Телевизээс мэдээ мэдээллийг авдаг байна. Иймд бид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, контентыг энэ 2 сувгаар дамжуулж иргэдэд хүргэхэд үр дүнд хүрнэ.

1. Та ихэвчлэн мэдээ, мэдээллийг хаанаас авдаг вэ?


271 responses



Энэхүү асуулга нь иргэдийн аль телевизийн сувгаас ихэвчлэн мэдээ мэдээллийг олж авдгийг тодорхойлох зорилготой бөгөөд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 177 буюу 65.3% нь МҮОНТ, 138 буюу 50.9% нь Боловсрол телевизийг үздэг байна. Иймд бид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, контентыг энэ 2 сувгаар

8. Хэрвээ ТВ-ээр хууль эрх зүйн болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэвтрүүлгийг бэлтгэн гаргавал та үзэх үү?

264 responses




дамжуулж иргэдэд хүргэхэд үр дүнд хүрнэ.

Энэхүү асуулга нь иргэдийн хууль эрх зүйн мэдлэг болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэвтрүүлгийн эрэлт хэрэгцээг тодорхойлох зорилготой бөгөөд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 67.4% нь цаг заваараа үзнэ гэж хариулсан. Иймд бид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, контентыг боломжит цагаар дамжуулж иргэдэд хүргэхэд үр дүнд хүрнэ.

Энэхүү судалгаа нь хууль эрх зүйн мэдлэг болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэвтрүүлгийг нэвтрүүлэх боломжит цагийг тодорхойлох зорилготой бөгөөд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 131 буюу 48.5% нь 18:00-22:00 цагт үзэх боломжтой байгаа нь судалгаанаас харагдаж байна. Иймд бид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, контентыг тухайн оргил цагт телевизээр цацах нь үр дүнд хүрнэ.

3. Та ихэвчлэн хэдэн цагт ТВ үздэг вэ?

270 responses



Хэвлэл мэдээллийн салбарт цахим шилжилт эрчимтэй явагдаж байна. 2020 оны эхний байдлаар 154 мэдээллийн сайт цаг үеийн мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж байгаагаас 20 нь орон нутагт ажиллаж байна.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглаж, өөрийн контентыг түгээх, сурталчлах, хэрэглэгчидтэй харилцах нь түгээмэл болж байна. Тухайлбал, телевизүүдийн 85 хувь нь албан ёсны фейсбүүк хуудсаараа нэвтрүүлэг дамжуулж, үзэгчдийн санал, сэтгэгдлийг хүлээн авч байна. Түүнчлэн, цахимаар сонсох боломжтой радиогийн тоо гурваар нэмэгдсэн бол веб сайтаар нь дамжуулан нэвтрүүлгийг нь хүлээн авах боломжтой 23 телевиз байна.

Иймд бид иргэдийн хууль эрх зүйн мэдлэг олгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэдийн үзэх боломжтой цаг буюу 18:00-22:00 цагт, МҮОНТ, Боловсрол телевизээр дамжуулах нь үр дүнд хүрэх нь тодорхой байна. Энэ 2 телевиз нь өдөр тутмын мэдээ мэдээллээ өөрийн Facebook page хуудсаараа тогтмол мэдээллэдэг тул олон хүнд хүрэх боломж өндөр байна гэж дээрх судалгаанаас харагдаж байна.

Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтарч гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголтод тулгуурласан мэдээ мэдээлэл, контентыг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой болох нь 2019, 2020 онд зохион байгуулсан нөлөөллийн арга хэмжээнүүдийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран үр дүнтэй зохион байгуулснаар гэмт хэрэг, зөрчил өмнөх онуудынхаас 11.4 хувиар буурсан нь нотолж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах нөхцөл бололцоо, зохион байгуулалтын хууль эрх зүйн оновчтой тогтолцоо, төрийн бодлогын бодит дэмжлэгээр дамжин сайжруулах, өргөн хүрээний нэгдсэн бодлого боловсруулах, улмаар түүнд нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна.

Санал

Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах аргаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэл, контент бэлтгэх гарын авлага, зөвлөмж боловсруулах, төсөв мөнгийг шийдвэрлэх;
- Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг дарга нартай идэвхитэй хамтран ажиллах;
- Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч нарт хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлийн сургалт семинар зохион байгуулах;
- Хүүхэд болон насанд хүрэгчдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх агуулга бүхий теле хичээл болон контентыг бий болгож, тогтмол нэг цагт нэвтрүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын оролцоотой хүүхдийг бага наснаас нь мэдлэг, дадал олоход хэвшүүлэхэд анхааран ажиллах;

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ОЙЛГОЛТ, ХУУЛЬ БУС ХЭРЭГЛЭЭ

*Б.Бямбазая
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

Товч агуулга. Олон улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээ хурдацтай тархаж байна. НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэдээллээр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын үйлдвэрлэл сүүлийн 15 жилд 3 дахин нэмэгдсэн, 269,4 сая хэрэглэгч байна гэжээ.

Энэхүү өгүүлэлд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын ойлголт, төрөл, хэлбэр, ангилал болон Монгол Улсад өсвөр насны хүн, залуучуудын дунд энэ бодисын хэрэглээ, хор уршгийн талаарх мэдээлэл ямар түвшинд байгааг авч үзсэн.

Түлхүүр үг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хэрэглэгч, өсвөр насны хүн, төрийн бус байгууллага.

Үндсэн хэсэг. Монгол Улстай хил залгаа оршин тогтнодог хоёр том гүрэн болох ОХУ, БНХАУ нь хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бодисын хууль бус хэрэглээ, түүнийг тойрсон гэмт хэргийн гаралт, ХДХР-ийн халдвартын тархлалтаараа дэлхийд 4-т багтаж байгаа нь анхаарал татсан асуудал болоод байна.

Монгол Улс Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай НҮБ-ын 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцид 2001 онд, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцид 2008 онд тус тус нэгдэн орсон бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр олон улсын өмнө үүрэг хариуцлага хүлээдэг.

Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг болон түүнд холбогдогчдын тоо жил бүр 30 - 35 хувиар тогтмол өсч, нас нь залуужиж, улмаар насанд хүрээгүй хүүхдүүд холбогдох явбал нэмэгдэж байгаа талаар Цагдаагийн байгууллагаас тогтмол сэрэмжлүүлж, анхааруулж байгаа билээ. Тодруулбал хар тамхины дамжуулагч гэгддэг байсан Монгол орон арван жилийн дотор “хэрэглэгч” улс болтлоо ахисан нь хар тамхи хэрэглэгч хүмүүсийн тоо өссөнийг гэрчилж байгаа юм.

2019 оны эхний найман сарын байдлаар улсын хэмжээнд хар тамхи, мансууруулах бодистой холбоотой нийт 169 гэмт хэрэг бүртгэгдэж, 294 холбогдогчийг шалгахад нийт холбогчдын 49 хувийг 19-25, 43 хувийг 26-35, долоон хувийг 46-55 насныхан эзэлж байна.⁴⁷

Мансууруулах төрлийн бодис гэдэг нь байгальд зэрлэг байдлаар ургадаг олсны ургамал, намуу цэцэг, мексикийн мөөг, кокийн бут зэргийг хамруулан ойлгох бөгөөд эдгээр мансууруулах үйлчилгээтэй түүхий эдийг химийн урвалд оруулах, нийлэгжүүлэх буюу синтетик хэлбэрт оруулснаар цэвэр кокайн, герин буюу дэлхий нийтээр хэлж хэвшсэн “Хар тамхи”- ыг гаргна авдаг. Бусад хар тамхи, мансууруулах бодисын бүх төрлүүдийг дээрх кокайн, героиноос гарган авдаг ба түүнээс гаргаж авсан бусад бодисоор анагаах ухаанд олон төрлийн тайвшруулах, өвчин намдаах зэрэг эм тариа үйлдвэрлэдэг байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай Монгол Улсын хуулийн 3.1.1. “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенци, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг⁴⁸ ойлгоно.

Монгол Улс хар тамхитай тэмцэх чиглэлээр дараахи олон улсын гэрээ конвенцид нэгдэн орсон байна. тухайлбал:

- Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенц;

⁴⁷ <https://police.gov.mn/a/4634>. Хар тамхитай тэмцэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Даваанямтай хийсэн ярилцлагаас хэсэгчилэн авав.

⁴⁸ Төрийн мэдээлэл. 2002. №46. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай Монгол Улсын хууль

- Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай" Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1971 оны Конвенц;⁴⁹
- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын 1988 оны конвенц;⁵⁰

Байгалийн болон нийлмэл аргаар гарган авсан бүлэг мансууруулах бодисыг "опиат" гэж нэрлэдэг байна. Халуун дулаан уур амьсгалтай оронд ургадаг бүлэг мансууруулах бодисыг "конопли" гэж нэрлэх бөгөөд удаан хэрэглэвэл сэтгэцийн өвчнөөр өвчлүүлэх бодисуудыг хамааруулан ойлгоно.

Ер нь эмнэлэгийн бус зориулалтаар, өөрөөр хэлбэл мансуурах зорилгоор хэрэглэгдэж буй сэтгэцэд нөлөөт бодис, эм бэлдмэлүүдийг монголчууд бид нийтэд нь хар тамхи гэж нэрлэж, албан ёсны бичиг баримтад тэр чигээр нь хэрэглэх явдал түгээмэл тохиолддог бөгөөд энэ нь тухайн нэр томъёоны хувьд хүмүүст хоёрдмол, буруу ойлголт өгөх хор уршигтай юм.

Дээрх байдлаар дүгнэвэл эмх замбараагүй хэрэглээнээс бий болох эрүүл мэндийн болон нийгмийн сөрөг үр дагаварыг нь харгалзан, мансуурах үйлчилгээтэй бодис болохыг нь тогтоож, хяналтаас гадуур эмнэлэг, судалгаа шинжилгээний бус зорилгоор хэрэглэхийг хориглон, тусгай жагсаалтанд оруулсан бодис, эм бэлдмэлүүдийг хууль, эрх зүйн үүднээс мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодис хэмээн тооцдог.

Нийгмийн талаас нь авч үзвэл хэрэглэсэн хэнийг ч зан үйлийн болон ёс суртахууны зөрчилрүү түлхэн, улмаар гэмт хэрэг үйлдэхэд хүргэж, улс нийгэмд нөхөгдөшгүй гарц учруулах чадвах бүхий бодис, түүнийг агуулсан эм бэлдмэлүүдийг мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт бодис гэж үзэж болно.

Хүн эдгээр бодисыг агуулсан ургамалыг түүж хатаан үнэрлэх, зажлах, татах, түүнийгээ цааш боловсруулж судсанд тарих, шахмал хэлбэрт оруулж уух зэргээр хэрэглэж эхэлснээр хар тамхи, мансууруулах бодисын байнгын хэрэглэгч бий болж үүнийг даган эрэлт хэрэгцээ ихсэж, улмаар бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчид ч бий болжээ.

Түүнчлэн хүнд өвчтөн зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд (маш хүнд хагалгаа, хорт хавдрын үед гэх мэт) эмчийн хяналтын дор, эмнэлэгийн нөхцөлд хэрэглэдэг.

Нөгөө нь хор уршгийг нь мэдэхгүйгээс бусдад уруу татагдах, бусдыг ухамсаргүйгээр дуурайх, сонирхож саваагүйтэх, сэтгэлийн хямралаас гарах гэж үзсэнээс болж хууль бусаар олж аван хэрэглэдэг.

Хүмүүсийг хар тамхи, мансууралд оруулж байгаа гол зүйлийн нэг бол түүний талаар тодорхой мэдлэггүй байх явдал юм. Ер нь олон хүчин зүйлээс болж хүмүүс хар тамхинд орж донтодог. Эдгээрээс гол хүчин зүйлс нь саваагүй сониуч зангаасаа болж, бусдын нөлөөнд орсноос болж хар тамхи, мансууруулах бодисыг бага багаар хэрэглэх болж аажмаар түүнд бүрэн урхилагдаж, хор уршгийг мэдэх болсон үедээ нэгэнт гүн донтож, байнга хэрэглэхийг сэтгэл санаа, бие махбодид шаардаж эхэлдэг нь хамгийн аймшигтай юм.

Дэлхийн хэмжээнд 269 сая гаруй хүн мансууруулах бодис хэрэглэж байгаагаас 11-21 сая хүн нь судсаар хар тамхи хэрэглэгч. Тэдний 6,6 сая ХДХВ ба ДОХ-ын халдвартай байна.⁵¹

"Алтан гурвалжин", "Алтан шинэ сар"-ын бүс нутгийн мансууруулах бодисын хууль бус эргэлтийн хэмжээ өсч, Хятад, Бирм, Лаосын мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх байгууллагуудын хамтарсан судалгаагаар 2015-2016 оны ургац ид авч буй үеийн байдлаар Бирмийн хойд бүс нутгийн намуу цэцгийн тариалангийн талбай 665 мянган га-д хүрсэн нь өмнөх жилийнхээс 3.7 хувиар өсч, 600 гаруй тонн хар тамхи, 60 гаруй тонн героин үйлдвэрлэх боломжтой болсон байна.⁵² Мөн энэ бүс нутагт үйлдвэрлэдэг мөсөн хэлбэрт мансууруулах бодисын үйлдвэрлэлийн жилийн дундаж хэмжээ героины хэмжээнээс үлэмж давж гарчээ. Лаосын хойд бүс нутгийн намуу цэцгийн тариалангийн талбай 80 мянган га-д хүрсэн нь өмнөх жилийнхээс 13.7 хувиар өссөн үзүүлэлт аж. Хятадын мансууруулах бодисын шинжилгээний төвийн тооцоогоор гаднаас оруулж ирж буй "Алтан гурвалжин"-ы бүс нутгийн

⁴⁹ 1971 оны 2 дугаар сарын 21-ний өдөр баталж, 1976 оны 8 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1999 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр нэгдэн орсон.

⁵⁰ 1988 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2001 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр нэгдэн орсон.

⁵¹ ДЭМБ-ын 2018 оны тайлангаас хэсэгчилэн авав.

⁵² World drug report 2016 /UNODC research/

героин, мөсөн хэлбэрт мансууруулах бодисын хэмжээ Хятадын дотоод дахь хэмжээнээс 95.2 ба 87 хувиар тус тус их байгаа аж.⁵³

Манай улсын хувьд хар тамхи хэрэглэгчдийн тоогоор дэлхийд тэргүүлэгч хоёр улс /ОХУ, БНХАУ/-ын дунд оршиж байгаа нь эрсдэлд өртөх магадлал өндөр гэж болно.

Хар тамхины хэрэглээ болон тархалтаар нь улс орнуудыг гурван хэсэгт хуваадаг. Эхний хэсэгт хар тамхины наймаачдыг дамжуулан өнгөрөгч орон бөгөөд хар тамхины хэрэглээ байхгүй гэж үздэг орнууд. Дараагийн ангилалд тодорхой хэрэглэгчтэй хар тамхины наймаа хүрээгээ тэлж буй хүлээн авагч орнууд багтдаг. Гурав дахь ангилалд гаргагч буюу хамгийн хүнд ангилал болох хар тамхийг дамжуулж, хүлээн авч, гаргадаг орнууд багтана. 2005 онд манай улсын дамжуулан өнгөрөгч орны ангилалд бүртгэгдэж байсан бол өнөөдөр гаргагч орон болчихсон байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Энэ бол Улс үндэстэн дамжиж үйлдэгддэг гэмт хэрэг бөгөөд бусад төрлийн гэмт хэргийг бодвол нууц далд аргаар үйлдэгддэг, хохирогчгүй гэмт хэрэг гэж үздэг. Хэргийн 55 хувьд нь Монголд ургаж байгаа өвс ургамал хэрэглэсэн, татсан, тээвэрлэсэн байдал гарч байна.

Монгол Улсын 21 аймгийн тодорхой бүс нутагт мансууруулах үйлчилгээтэй каннабис өвс ургамал ургадаг. Түүнийг түүж бэлтгэх, зарж борлуулах, хэрэглэх, тээвэрлэхтэй холбоотой гэмт хэрэг ихэвчлэн гардаг. Үлдсэн 45 хувийг манай улсад үйлдвэрлэдэггүй химийн аргаар гаргаж авдаг бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх тээвэрлэх гэмт хэрэг бүрдүүлж байна.⁵⁴

Дэлхийд хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлтийн сүлжээ үүсгэн идэвхтэй ажиллаж байгаа Алтан гурвалжин /Тайланд, Лаос, Мьянмарын хилийн бүс/, Алтан хавирган сар /Афганистан, Пакистан, Ираны хилийн бүс/, Мөнгөн гурвалжин /Колумб, Болив, Перу, Мексикийн хилийн бүс нутаг/, Хар гурвалжин /Нигер, Гана, Кени, Судан, Өмнөд африк/ гэгдэх Африкийн орнуудын гэмт бүлэглэлүүд Төв болон Зүүн өмнөд Азийн орнуудын иргэдийг хар тамхины хууль бус наймаанд элсүүлэх, татан оролцуулах, тээвэрлүүлэх явдал газар авч байна.⁵⁵

Монгол 700 орчим мансууруулах бодис хэрэглэгч байгаа гэсэн судалгаа хагас жилийн өмнө байсан Мансууруулах бодис хэрэглэгчдийн дунд хийсэн судалгаагаар 18 хувь нь татдаг, долоон хувь үнэртдэг, 12 хувь тариураар тарьж хэрэглэдэг байна. Харин тэдний дийлэнх хувийг 18-24 нас, цаашлаад 29 хүртлэх насны хүмүүс эзэлж байгаа бөгөөд нийт хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал, бухимдал, нийгмийн сөрөг үзэгдлийн улам бүр ихэсч, улмаар архидалт, тамхидалд хавтгайрч, өнөөдрийн байдлаар дэлхийн хэмжээнд архи, тамхины хэрэглээгээрээ эхний 10 байранд болсон төдийгүй хэрэглэгсэд нь улам бүр залуужиж байна.

Олон улсын хяналтын байдаг мансууруулах буюу сэтгэцэд нөлөөт бодисуудыг гарлынх нь хувьд гурав ангилж болно. Үүнд:

- Байгалийн гаралтай;
- Хагас нийлэгжүүлэх аргаар гарган авсан;
- Нийлэгжүүлэх аргаар гарган авсан гэж ангилдаг

Химийн шинжлэх ухаан хөгжихийн хирээр хүн төрөлхтөн бараг дурын бодисыг нийлэгжүүлэх (synthesis) аргаар гарган авах болсон бөгөөд үүнтэй хобогдуулан олон улсын хяналтад байдаг мансууруулах буюу сэтгэцэд үйлчлэх байдлаар нь ангилах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал:

- Төв мэдрэлийн системийг дарангуйлагч буюу оюуны идэвхийг сааруулах, хэт тайвшруулах, нойрсуулах үйлчилгээтэй бодисууд;
- Төв мэдрэлийн системийн өдөөгч бодисууд буюу сэтгэцийн идэвхийг сэргээж, сэтгэл санааг, хий хөөрөлд оруулах үйлчилгээтэй бодисууд;
- Сэтгэцийн хосолмол үйлчилгээтэй буюу дээрх шинж тэмдгүүдийн аль алиныг нь үзүүлэх үйлчилгээтэй буюу дээрх шинж тэмдгүүдийн аль алиныг нь үзүүлэх үйлчилгээтэй бодисууд (каннабионидууд) гэж ангилж болно.

⁵³ 2016 年中国毒品形势报告

⁵⁴ <https://police.gov.mn/a/4634>. Хар тамхитай тэмцэх тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Г.Даваанямтай хийсэн ярилцлагаас хэсэгчилэн авав.

⁵⁵ <https://www.customs.gov.mn/2014-03-24-06-25-31/2015-02-04-06-28-11/526-2015-02-06-07-21-57>

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай Монгол Улсын хуульд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт” гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадаглах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагааг;

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх” гэж байгальд ургадаг мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг түүж цуглуулах, тарьж ургуулах, хураан авах, цэвэршүүлэх, дахин боловсруулж хувирган өөрчлөх, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн хэлбэрээр гаргаж авахыг;

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эд” гэж хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан, тус улсад хяналтад байлгавал зохих мансууруулах үйлчилгээ бүхий ургамал болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ;

“Мансууруулах дон” гэж мансууруулах төрлийн бодисоос хамааралтай сэтгэцийн өвчнийг тус тус ойлгодог байна.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг дор дурьдсан зорилгоор дараах байгууллага ашиглаж болохыг Монгол Улсын хууль тогтоомжид тусгасан байдаг. Тухайлбал:

- Эмчилгээ, шинжилгээ, судалгааны зорилгоор эрүүл мэндийн болон эрдэм шинжилгээний байгууллага;
- Лабораторийн шинжилгээ хийх, сургалт явуулах зорилгоор мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэд хяналт тавих үүрэгтэй байгууллага;
- Харьцуулалт хийх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоох, илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага;
- Эмийн ургамлыг тарималжуулсан тохиолдолд сэтгэцэд нөлөөт бодис, түүний түүхий эдийг үйлдвэрлэх, экспортлох тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгж.
- Эмчийн заалтаар мансуулах болон сэтгэцэд нөлөөт эм хэрэглэх жор авсан өвчтөн уг эмийг хэрэглэж болно.

Шинжилгээ судалгааны зорилгоор ашиглах мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын болон байгууллагын жагсаалт, ашиглах журмыг Засгийн газар батална.

Цагдаа, тагнуул, хил хяналтын болон холбогдох бусад байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн хуульбус эргэлтийг таслан зогсоох, энэ төрлийн зөрчил, гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.⁵⁶

Мансууруулах бодисын нөлөөлөл

Мансууруулах бодисын хор уршгийг тоочоод баршгүй юм. Оюун ухаан доройтож, донтоно, Гоо сайхан алдагдана. (*арьсны өнгө харлаж, нүүр барзайна, ус унана, хумс хугарна, эрт хөгширнө*) Зүү тариурыг хэрэглэсэнээс ДОХ, халдварт шар өвчин авах, тараах аюултай, бэлгийн сулралд орно, үргүй болно, үр удам нөлөөлснөөр тахир дутуу, эрхтэн согогтой, ухаан сааталтай хүүхэд төрнө гэх мэт маш олон сөрөг үр дагавартай.

Сэтгэцэд идэвхит эм бодис гэдэг нь хүний төв мэдрэлийн системийн үйл ажиллагааг цочроож эхлээд сэтгэлийн хөөрөлд үүсгэж , тодорхой хугацааны дараа саатал болон хувирч улмаар булчин сулруулах, нойр хүрэх, мэдрэл тайвшруулах, сэтгэл түгшүүрийг түр арилгах мансууруулах үйлчилгээг үзүүлдэг эм бодисууд юм. Сэтгэц идэвхит эм бодисыг замбараагүй хэрэглэхэд “Дондох эмгэг” үүсгэдэг.

Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Сонгино-хайрхан дүүрэг, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын ерөнхий боловсролын сургуулийн 1067 хүүхдийг хамруулан 2017 оны 10 дугаар сарын 23-наас 11 дүгээр сарын 26-ны хооронд тест болон ярилцлагын аргаар судалгаа авсан байна.⁵⁷

Судалгаанд орон нутаг болон нийслэлийн нийт 1067 сурагч оролцсоноос 529 нь эрэгтэй, 538 нь эмэгтэй сурагч байна. Үүнээс 7 дугаар ангийн 60 хүүхэд, 8 дугаар ангийн 157

⁵⁶ Төрийн мэдээлэл. 2002. №46. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай Монгол Улсын хууль

⁵⁷ “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” криминологи судалгааны тайлан. УБ. 2017. 2 дахь тал

хүүхэд, 9 дүгээр ангийн 215 хүүхэд, 10 дугаар ангийн 243 хүүхэд, 11 дүгээр ангийн 189 хүүхэд, 12 дугаар ангийн 203 хүүхэд оролцсон байна.

Судалгаанд оролцогчдын хувьд энэ төрлийн бодисын талаар ер нь сонсдог 37%, заримдаа сонсдог 41%, маш их сонсдог 18% бол огт сонсоогүй 4% байна. ЕБС-ийн сурагчдын 96% нь мансууруулах бодисын талаар мэдээлэлтэй байна. Судалгаанд оролцогчдын 28% нь мансууруулах бодисын талаарх мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернэт, 15% сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз нөхдөөс мэдээлэл авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй байна.

Судалгаанд оролцогчдын 41% нь мансууруулах бодисын хэрэглээ өсвөр үеийнхний дунд түгээмэл байдаг, 15% нь маш түгээмэл, 20% нь мэдэхгүй, 13% нь бага, 5% нь маш бага, 6% нь түгээмэл бус байдаг гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 320 нь мансууруулах бодис хэрэглэсэн хүн огт хараагүй, 230 нь 1-2 хүн харсан, 70 нь 3-5 хүн харсан гэсэн бол 447 нь мансууруулах бодис хэрэглэсэн олон хүн харсан гэжээ. Судалгаанд оролцогчдын 74% нь мансууруулах бодис огт хэрэглэж байгаагүй, 13% нь ганц удаа хэрэглэж байсан, 2% нь хааяа хэрэглэдэг гэсэн бол 11% нь олон удаа хэрэглэж байсан гэсэн байна.

Хэн нэгэн мансууруулах бодисын хор уршгийн талаар танд хэлж хол байх тухай зөвлөж байсан уу? гэсэн асуултад сурагчдын 46% нь маш их зөвлөдөг, 25% нь хааяа зөвлөдөг, 17% нь ганц хоёр удаа л зөвлөж байсан гэсэн бол 12% нь огт зөвлөж байгаагүй гэсэн байна.

Мансууруулах бодисын талаарх мэдээллийг хаанаас авдаг вэ гэсэн асуултанд нь нийслэлд судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 250 нь интернэтээс авсан, хөдөө орон нутагт судалгаанд оролцогчдын хамгийн их буюу 162 нь телевиз, кинон дээрээс мэдээлэл авдаг. Мэдээлэл аваагүй нь хөдөө орон нутагт 9 буюу нийслэлд 19 тус тус байна.

Мансууруулах бодисыг сонирхох маягаар хэрэглэж үзэж байсан уу? гэсэн асуултанд огт хэрэглэж байгаагүй гэсэн үзүүлэлт нь хамгийн өндөр нийслэлд 389, хөдөө орон нутагт 362 байна. Олон удаа хэрэглэсэн гэсэн үзүүлэлт нь нийслэлд 41, хөдөө орон нутагт 9 байна. Хааяа хэрэглэдэг гэсэн үзүүлэлт нь нийслэлтэй харицуулвал хөдөө орон нутагт 5-аар илүү буюу 15 байна. Ганц удаа хэрэглэж байсан гэсэн үзүүлэлт нь нийслэлд 62, хөдөө орон нутагт 64 байна.

Оролцогчдын 37% нь мансууруулах бодисын талаар ер нь сонсдог, 41% нь заримдаа сонсдог, 18% нь байнга сонсдог гэсэн бол 4% нь огт сонсоогүй гэсэн байна. Үүнээс үзэхэд сурагчдын 96% нь уг бодисын талаар ямар нэг хэмжээгээр мэдээлэлтэй байна. Сурагчдын 28% нь мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын тухай мэдээллийг телевиз, киноноос, 27% нь интернэт, 15% нь сонин сэтгүүл, 10% нь гэр бүл хамаатан садан, 12% нь найз нөхдөөсөө мэдээлэл авсан гэсэн бол 4% нь энэ талаарх мэдээлэл огт аваагүй гэсэн байна. Үүнээс үзэхэд энэхүү бодисын талаарх мэдээллийг интернет, телевиз, киноноос авах нь түгээмэл байна.

Хэдийгээр дунд сургуулийн сургалтын хөтөлбөрт “Эрүүл мэнд” гэдэг хичээл бие даасан судлагдахуун болж 2004-2015 оны хооронд заагдаж, түүнд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршиг, үр дагавар, зайлсхийх аргыг заадаг байсан ч хүүхдүүд энэ талаар мэдээлэл, мэдлэг хомс байгаа нь сургалтын агуулга, хөтөлбөрт өөрчлөлт оруулах, багш нарын заах арга барилыг өөрчилж мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, тусгайлан бэлтгэх шаардлагатайг харуулж байна.⁵⁸

Нийслэл болон орон нутгаар харьцуулан үзэхэд нийслэлийн хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ нь орон нутгаас өндөр үзүүлэлттэй байна. Нийслэл, орон нутгийн аль алинд нь уг бодисын мэдээллийг интернетээс авдаг нь өндөр үзүүлэлттэй гарсан ба нийслэл, орон нутгийн аль алинд нь хэрэглээний түвшин ахлах ангийнхны дунд тодорхой хэмжээнд байгаа нь анхаарал татаж байна.

Ахлах болон дунд ангиар харьцуулахад, дунд ангийн сурагчдын хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг архи, тамхи гэж үзэж байгаа бол ахлах ангийнхны хувьд хар тамхи гэж ойлгож байгаа бөгөөд тэдний хэрэглээний түвшин илүү байна. Дунд ангийн сурагчдын хувьд хэрэглээ харьцангуй бага хэдий ч уг бодисын тухай мэдээлэл их байгаа нь хүүхдийн энэ төрлийн бодист автах эрсдэлтэй байна.

⁵⁸ “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” криминологи судалгааны тайлан. УБ. 2017. 2 дахь тал

Мансууруулах бодисын нийлүүлэлт болон зах зээл

Европ нь мансууруулах бодисын гол төв болж, дотоодын үйлдвэрлэл болон импортоор хангагдаж байна. Хар тамхи мансууруулах бодис хууль бусаар нийлүүлж буй гол газрууд нь Өмнөд, Баруун, Хойд Америк бол Хятад Улс сэтгэцэд нөлөөлөх шинэ төрлийн бодисыг анхлан нийлүүлэгч орон болж байна. Мөн зарим эм бэлдмэлийн Европоор дамжуулан бусад тив рүү гаргаж байна.

Европ нь каннабис, синтетик эмийн үйлдвэрлэл зөвхөн орон нутгийн хэрэглээнд зориулагдсан байдаг бол зарим төрлийн синтетик эмийг экспортолдог. 1970-1980 онд каннабис, герин, амфетамины зах зээл Европт бий болж, 1990-ээд оноос кокаин, MDMA зэрэг бодисыг үйлдвэрлэж эхэлсэн. Сүүлийн 10 жилийн хугацаанд хууль бус эмийн зах зээлд гарсан өөрчлөлтүүд нь глобалчлал, шинэ технологи буюу эмийн үйлдвэрлэлд гарсан инноваци болон эдгээрийн даган боловсронгуй болж буй нууцаар худалдах маршрут, онлайн худалдаа зэрэг болно.

Эхэн үедээ зөвхөн цөөн тооны иргэд хар тамхи, мансууруулах бодисыг хэрэглээний журмаар /хагас нийлэгжүүлэх аргаар гаргаж авсан мансууруулах бодис/ бага хэмжээгээр хууль бусаар нэвтрүүлэх байдлаар үйлдэгдэж байсан бол өнөөдөр уг гэмт хэрэг үйлдэгчид нь ашиг орлогын үндсэн эх үүсвэр болгох зорилгоор тээвэрлэж, зарж борлуулах гэмт хэргийг үйлдэх болсон.

Манай иргэд энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож буй байдлыг авч үзэхэд дийлэнх хувь нь БНХАУ-д үйлдэгдэж байна. Хил залгаа ӨМӨЗО-ны Эрээн хотод дээрх төрлийн мансууруулах бодисын хэрэглээ газар авсан, манай иргэд байнга зорчдог, биеэ үнэлэгч, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон иргэд энэ төрлийн гэмт хэрэгт хэрэглэгч гэсэн ангилалд байсан бол сүүлийн 2-3 жилийн хугацаанд энэ төрлийн гэмт хэргийн тээвэрлэгч гэсэн ангилалд хамаарах болоод байна.

Энэ төрлийн хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалттай гэмт бүлгүүдийн зүгээс манай иргэдийн Зүүн өмнөд Азийн орнуудад визгүй зорчих боломжтой байдал, гэнэн итгэмтгий зан, амар хялбар аргаар мөнгө олох зэрэг сул талуудыг нь ашиглан хууль бус эргэлтэнд татан оруулж байгаад анхаарах шаардлагатай юм.

Одоогоос 20 жилийн өмнө судалгаа хийхэд Улаанбаатар хотоос хэрэглэдэг хүүхэд олдоогүй харин 2017 онд хийгдсэн судалгаанд 1067 хүүхэд хамрагдсан үүнээс 201 хэрэглэдэг гэсэн тоон судалгаа хийгдсэн хүн ам цөөтэй манай улсын хувьд энэ нь их хэмжээний үзүүлэлт юм. Манай Монгол Улсад хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг үйл ажиллагаагаа 1999 оноос эхэлнэ ажиллаж байна. Олон олон судалгаа шинжилгээ бусад улс оронтой харьцуулалт хийсээр ирсэн.

Өнөөдрийн байдлаар Монголд “Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэг”, “Хар тамхитай тэмцэх мэдлэг”, “Хорт зуршлаас сэргийлэх нийгэмлэг” гэсэн хар тамхи, мансууруулах бодисын эсрэг нийгэмд үйлчлэх 5-6 ТББ үйл ажиллагаа явуулж байна.

ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсээс гаргасан тоогоор манай улсад хар тамхи болон энэ төрлийн мансууруулагч бодис хэрэглэгч 966 хүн байна.

2017 онд хар тамхи, мансуурах бодисын хэрэглээтэй холбоотой 117 хэрэгт 275 хүн холбогдож байсан бол 2019 онд 197 гэмт хэрэгт 403 хүн холбогдоод байна. Бүртгэгдсэн нийт холбогчдын 49 хувийг 19-25 насныхан, 43 хувийг 26-35, 7 хувийн 36-45 насныхан, үлдсэн нэг хувийг 46-55 насныхан эзлэн холбогдож байна. Дээрх тоо баримтаас харахад хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, үүнтэй холбоотой хэрэгт 35 хүртэл насныхан илүү холбогдож байна.⁵⁹

2019 оны эхний есөн сарын байдлаар мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлтэй холбоотой 193 хэрэгт 333 хүн холбогдон шалгагдаж байна. Үүний 23 хэрэг нь хөдөө орон нутагт бүртгэгдсэн. Үүнээс харахад энэ төрлийн хэрэг зөвхөн Улаанбаатарт биш хөдөө орон нутагт ч гарах болсныг харж болно.

Нийт хүний 282 нь буюу 85.4 хувь нь 18-35 насны залуучууд байгаа бол нийт холбогдогчийн дотор 13 сурагч, төрийн албан хаагч дөрөв байна. Шуудан илгээмж ашиглан гаднын орнуудаас Монгол Улс руу хар тамхи, мансууруулах бодис нэвтрүүлэх гэсэн 11 хэргийг илрүүлэн шалгаж байгаа. 2018 оны есдүгээр сартай харьцуулахад энэ жил 62 нэгж буюу 32.2

⁵⁹ <https://www.customs.gov.mn/2014-03-24-06-25-31/2015-02-04-06-28-11/526-2015-02-06-07-21-57>

хувиар өссөн байна. Харин холбогдогч нарын тоо 72 нэгж буюу 21.9 хувиар өссөн байна. 2018 онд нийт 412 хүн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 36 нь буюу 8.7 хувь, 2019 оны гуравдугаар улирлын байдлаар нийт 330 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 47 нь буюу 14.2 хувь нь энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг давтан үйлдсэн байна.⁶⁰

2019 оны 1-р сарын байдлаар Гаалийн байгууллага мансууруулах бодис улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан 5 удаагийн үйлдлийгилрүүлж, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар бусад байгууллагатай хамтарсан арга хэмжээг зохион байгуулсаны үр дүнд АНУ, Канад, Их Британи, Герман, Испани, Нидарландаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг захиалан олон улсын шуудан илгээмжээр улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг тогтоож, таслан зогсоосон байна.

Дүгнэлт

Монгол улс нь Дэлхийн хэмжээнд газар нутгаараа маш томд тооцогддог ОХУ болон БНХАУ-ын хооронд оршин тогтнодог бөгөөд энэ хоёр улс нь мансууруулах бодис хэрэглэх, зөөвөрлөх, худалдаалах, тарих зэргээр маш өндөр түвшинд байгаа нь тулгамдсан асуудал болсон байна.

Энэ гэмт хэргийн мэдээлэл суртчилгаа муу явагдаж байгаагаас хүүхдүүдийн мэдлэг болон эцэг эхчүүдийн мэдлэг муугаас энэ гэмт хэргийн мэдээлэл хөдөө орон нутагт алслагдсан газаруудад энэ талын ямар ч мэдээлэл байхгүй анх оюутан болоод ирж байгаа хүүхдүүд гэнэн цайлган зангаасаа мөн мэдлэг муугаас болж энэ төрлийн гэмт хэрэг ихсэж бас залуужиж байна.

Эцэг эхчүүд үр хүүхдүүдээ хар тамхи, сэтгэцэд нөлөөт хорт бодисоос урьдчилан сэргийлэх, гарах үр дагавар, хор уршгийг нь эртхэн ярьж ойлгуулах ажлыг системтэйгээр явуулж эхлэхгүй бол харамсалтай явдал гарч болзошгүй нөхцөл байдалд бий болжээ.

Санал

Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Мансуурлаас урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг олон нийт, тэр дундаа хүүхэд залуучуудад таниулах, ойлголтыг зөв болгох, мэдлэгийг нэмэгдүүлэх ажилд хэвлэл мэдээллийн байгууллагуудын үүрэг оролцоог тодорхойлсон заалтыг хуульд тусгаж өгөх.
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан тандалтын тестээр шинжилгээ авч бодит нөхцлийг тодорхойлох ажил, арга хэмжээг бодлогын чанартайгаа зохион байгуулж, хэрэглэгчдийн тоог бодитой тогтоон, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
- ЕБС-д ахлах, дунд ангид сурдаг сурагчдын эцэг эхчүүдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, Хар тамхитай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн мэргэшсэн алба хаагчдыг оролцуулсан сургалтыг хагас жил тутам зохион байгуулж хэвших.

Ном зүй

- Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл. 2002. №46.
- ДЭМБ-ын 2018 оны тайлан.
- “Хүүхэд, өсвөр насныхны мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодист автах эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ” криминологи судалгааны тайлан. УБ. 2017
- World drug report 2016 /UNODC research/
- 年中国毒品形势报告2016
- police.gov.mn
- www.customs.gov.mn
- eagle.mn

⁶⁰ <http://eagle.mn/r/65679>. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын дарга, хурандаа Ж.Эрдэнэболдийн ЮгсЮн ярилцлагаас хэсэгчилэн авав

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ХАНГАХАД КОМПАНИЙН БОНДЫН ҮР НӨЛӨӨ

*П.Уранмандах
ДХИС-ийн магистрант*

Товч агуулга. Ямар ч улс орны аюулгүй байдалд гол байр суурийг эдийн засгийн аюулгүй байдал эзэлдэг. Тухайн улс орон эдийн засгийнхаа хувьд биеэ даасан, хараат бус, бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ хувьд төрөлжсөн, олон улсын зах зээлд идэвхтэй оролцогч, хэрэглэгч амынхаа аюулгүй амьдрах баталгааг хангаж чадаж байвал энэ оронд аюулгүй байдлаа хангах нөхцөл зүй ёсоор бүрэлдэж байна аа гэж ойлгож болох юм. Яагаад улс орнууд эдийн засгийнхаа аюулгүй байдалд илүү анхаардаг вэ? Үүнийг хангахын тулд ямар ямар стратегийг хангах ёстой вэ? гэдэг асуудал урган гарч байна. Тиймээс бидэнд эдийн засгийн аюулгүй байдлын талаарх төрийн бодлого, салбар хоорондын тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, шийдвэр гаргах арга замыг тодорхойлох шаардлага гарч байна. Эдийн засгийн аюулгүй байдлын талаар үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл юм гэж тодорхойлсон байдаг.

Эдийн засгийн аюулгүй байдал алдагдвал энэ нь цаашлаад улс орны тусгаар тогтнол, оршин тогтнох үндсийг ганхуулах эрсдэлтэй учраас бид улс орныхоо эдийн засгийн аюулгүй байдал нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг зөв тодорхойлж, аливаа аюул заналыг урьдчилан хараж сэргийлэн, тохирох арга хэмжээг цаг алдалгүй авах нь маш чухал юм. Өөрөөр хэлбэл эдийн засгийн аюулгүй байдлын давуу болон сөрөг нөлөөтэй хүчин зүйлс бүрийн чиглэлд судалгаа, шинжилгээ хийж, аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадвар, дархлааг бий болгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Бид эдийн засгийн аюулгүй байдлаа хангаад явж чадаж байна уу, эсвэл зөрчигдөж цаашлаад үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болохуйц хор уршиг дагуулж байна уу гэдгийг бид урьдаас таамаглан мэдэж, тооцоолон зохих арга хэмжээг авч зөв горимд оруулж байх нь нэн тэргүүний асуудал юм. Үндэсний аюулгүй байдлын стратегийн мөн чанар нь ард түмний язгуур ашиг сонирхол, үнэт зүйлс, гадаад, дотоод сөрөг хүчин зүйлсээс бүрэн хамгаалагдсан байхад оршдог. Тиймээс бидний анхаарах ёстой гол асуудал бол үндэсний аюулгүй байдлыг гол шалгуур болсон эдийн засгийн аюулгүй байдлыг хангах явдал юм. Бид аль орны хөгжлийг дуурайх бус өөрийн орны онцлог, нөөц бололцоо дээрээ тулгуурлан зөв стратеги бодлогыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Эдийн засгийн аюулгүй байдлын гол дархлаа бол эдийн засгийн тогтвортой өсөлт юм. Энэхүү өсөлтийг бий болгохын тулд бидэнд зөв бодлого стратеги зохицуулалт шаардлагатай. Монгол улсын аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.1.2 дээр дурдснаар хүн амын амьдралын үндсэн хэрэгцээ, эдийн засгийн бие даасан, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулахад санхүүгийн салбарыг олон улс, Европын Холбооны стандартад нийцүүлэн хөгжүүлнэ гэж тусгасан байна.

Тэгвэл эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэх, улсынхаа дотоод болон гадаад аюулгүй байдлыг бэхжүүлэх, санхүүгийн салбараа олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэхийн тулд бидэнд хөрөнгийн зах зээлийн хөгжил чухал юм. Гэвч манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил бусад улс оронтой харьцуулахад харьцангуй сул байгаа юм. Манай улсын хувьд санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь маш бага байдаг. Бид энэ зах зээлийг хөгжүүлж чадсанаар цаашид дотоодын зах зээлээ тэлэх, улам боловсронгуй болгох боломж бүрдэх юм. Ямар ч улс орны эдийн засгийн хөгжил дэвшлийг хөрөнгө оруулалтгүйгээр төсөөлөхөд бэрх. Иймээс хөрөнгө оруулалтын гол суваг болох хөрөнгийн зах зээлийн хөгжил дэвшлийн асуудал чухал болсон өнөө үед Монгол улсад хөрөнгийн зах зээлийг цаашид улам хөгжүүлэх боломж, бололцоог бүрдүүлэх нь чухал юм. Улс орны урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжигч үндсэн хэрэгсэл нь хөрөнгийн зах зээл юм. Сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн өсөлтөнд банкны сектороос илүүтэйгээр хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэх үүрэг нэмэгдсэнээр байна. Зах зээлд шилжсэн хөгжингүй орны эдийн засгийн өсөлт үнэт цаасны зах зээлээсээ шууд хамаардаг байна. Тиймээс бид бондын зах зээлийг цаашид зөв замаар хөгжүүлж чадвал энэ нь эргээд улсын эдийн засагт эерэгээр нөлөөлж, бодит салбар, үйлдвэрүүдийг хөгжүүлэх, цаашлаад макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах боломжтой.

Түлхүүр үг: Компанийн бонд, бонд, хөрөнгийн зах зээл, эдийн засаг.

Хөрөнгийн зах зээлийн ойлголт

Хөрөнгийн зах зээл (англи. Stock market) нь үнэт цаасны эргэлтийг худалдан авах, худалдах, солилцох эсвэл барьцаалах замаар үнэт цаасны эргэлтийг зохицуулах дэлхийн хэмжээний санхүүгийн болон эдийн засгийн хэрэглүүр юм. Хөрөнгийн зах зээл гэдэг нэр томъёо нь ерөнхийдөө төрөл бүрийн аж ахуйн нэгж, байгууллагууд янз бүрийн санхүүгийн гэрээ, бүтээгдэхүүнүүдийг худалддаг газрыг тодорхойлдог. Хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг гол бүтээгдэхүүн нь хувьцаа болон **Бонд** юм.

Аливаа улс орны засгийн газар, орон нутаг төрийн байгууллага, нэгжүүд өөрийн санхүүгийн чадавхыг өсгөх, улмаар төлөвлөсөн томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, үйл ажиллагаагаа өргөтгөх зорилгоор банк болон хөрөнгийн зах зээл дээрээс зээл авдаг. Энэхүү хөрөнгийн зах зээл дээрээс зээл авна гэдэг нь өөрийн үндсэн хөрөнгийг барьцаалан бонд гарган хөрөнгө босгож (татаж) буй хэлбэр юм. Бонд гэдэг нь мөнгө зээлэн авч буйг баталж байгаа үнэт цаас юм. Өөрөөр мөн “өрийн бичиг” гэж нэрлэдэг. Бонд худалдан авснаар засгийн газар, тухайн компанид хүүтэй мөнгө зээлдүүлж буй явдал юм. Хөрөнгө оруулагчдыг татдаг гол онцлог нь бондын хүү банкны хүүгээс илүү өндөр байх тохиолдол юм. Бондын хүүг бонд гаргаж буй засгийн газар, тухайн компани тогтооно. Яагаад засгийн газар, төр орон нутгийн байгууллага бонд гаргадаг вэ гэхээр урсгал, нэмэлт болон үйл ажиллагааны зардал, төсөл хөтөлбөрт санхүүжилт татах зорилгоор бонд гаргадаг. Бонд гаргах нь олон (том жижиг) хөрөнгө оруулагчдыг татах, энэ нь тэдний хайж буй хөрөнгийг босгох боломжийг олгодог. Монгол улсад хөрөнгийн зах зээл дээр бонд гаргахын тулд дараах 2 шалгуурын аль нэгийг хангасан байх шаардлагатай тавьдаг.

Шалгуур 1• Компанийн зах зээлийн үнэлгээ 10 тэрбум төгрөгөөс дээш байх• 3-аас дээш жил үйл ажиллагаа явуулсан байх• 10 тэрбум төгрөгөөс дээш Борлуулалтын орлоготой байх• 1 тэрбум төгрөгөө дээш ашигтай ажилласан байх• Хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх• Андеррайтерын компанитай гэрээ байгуулсан байх.

Шалгуур 2 (Доорх шалгууруудын аль нэгийг л хангасан байх)• Санхүүжилт татах бондын үнийн дүн болон хүүгийн төлбөртэй тэнцэх барьцаа хөрөнгөтэй байх• 3-аас доошгүй жил үйл ажиллагаа явуулсан байх• Бондын эргэн төлөлтөд Засгийн газар баталгаа гаргасан байх• Олон улсын болон дотоодын зөвшөөрөгдсөн зээлжих зэрэглэл тогтоох байгууллагаас өндөр зэрэглэлтэй байх зэрэг шаардлагуудыг тавьдаг. Дээрх хэсэгт хөрөнгийн зах зээл болон бондын зах зээлийн талаарх ерөнхий ойлголтыг дурдлаа.

Компанийн бонд

Бондын зах зээл дотроо компанийн бондын үүсэл хөгжлийн талаар, мөн манай улсад энэ нь хэр хөгжиж байгааг, энэ нь эдийн засгийн хөгжилд нөлөөтэй эсэх, цаашид хөгжүүлэхийн тулд ямар арга хэмжээг эрхзүйн болон бодлогын хувьд авч хэрэгжүүлэх шаардлагатай вэ гэдэг талаар товчхон авч үзье. Засгийн газраас гадна компаниуд санхүүгийн зах зээл дээр бонд гаргаж, санхүүгийн эх үүсвэр татах эрхтэй байдаг. Энэ зорилгоор компаниас гаргасан бондыг компанийн бонд гэнэ. Компанийн анхны бондын арилжаа 2001 оны 6-р сарын 8-нд явагдаж байсан. Манай улсын хувьд хөрөнгийн зах зээл үүсээд даруй 29 жилийн хугацаа өнгөрсөн хэдий ч компанийн бондын зах зээл 2001 оноос эхэлсэн түүхтэй. Энэ хугацаанд 16 компани олон нийтэд бондоо санал болгон гаргаж 25.6 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлжээ.

Анх 2001 онд Барилга корпорацаас “Шинэ зуун” бондыг гарган арилжаалсан. 2015 оныг хүртэл нийт 12 компани бонд гарган амжилттай арилжаалсан бөгөөд эдгээр бондыг гол төлөв барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд гаргасан байдаг.⁶¹ Манай улсын хувьд компанийн бондын ДНБ-д эзлэх хувь одоог хүртэл маш бага байдаг. 2018 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,511.8 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 71.5 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өссөн байна. 2020 онд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ өнгөрсөн онтой харьцуулахад 12.5 хувиар өсөж 3,029.7 тэрбум төгрөгт хүрч, 2019 оны жилийн эцсийн ДНБ-ий дүнд харьцуулахад 8.1 хувьтай тэнцэж байна. Харин хувьцааны хөрвөх чадвар 3.2 нэгжээр буурч 1.8 хувьд хүрсэн ба ТОП-20 индекс өмнөх оноос 336 нэгжээр буурч 19,285.8 нэгжид хүрсэн. 2020 онд нийт 65.4 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан ба нийт арилжааны 0.9 хувийг Засгийн газрын үнэт цаас, 7.8 хувийг

⁶¹ Санхүүгийн салбарын тойм-2017

хөрөнгө оруулалтын сан, **8.9 хувийг компанийн бонд**, 82.5 хувийг хувьцаа тус тус эзэлж байна. (САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО) Эндээс манай улсын хувьд хөрөнгийн зах зээлийн дийлэнх хувийг хувьцаа эзэлдэг нь харагдаж байна. Мөн хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь маш бага байна. Дээрх статистик мэдээнээс ерөнхийдөө манай улсын компанийн бондын хөгжил сул байна гэж дүгнэж болохоор байна.

Компанийн бондын арилжаа

2020 оны дүнгээр нийт 16 компанийн бонд Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдсан бөгөөд хамгийн өндөр үнийн дүнтэй бондуудыг ялган авч үзвэл үүнд: Барилга корпорацийн гаргасан шинэ зуун бонд-5.3 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй (2002 он), Жаст Агро ХХК-4.4 тэр бум төгрөгийн үнийн дүнтэй(2012он) байсан бол өнгөрсөн хугацаанд хамгийн өндөр үнийн дүнтэй бондыг Сүү ХК 2017 онд гаргасан бөгөөд нийт үнийн дүн нь 6 тэр бум байсан байна. Эндээс компаниуд бондоо хугацааны хувьд тогтмол бус гаргадаг нь харагдаж байгаа юм.⁶² Амжилттай арилжаалагдсан "Сүү бонд"-ын талаар товч авч үзвэл: 2017 оны 6 сард "Сүү" ХК нийтэд санал болгон Сүү бонд гаргасан бөгөөд анхдагч зах зээлийн арилжаагаар 60 мянган ширхэг "Сүү бонд"-ыг 6 тэрбум төгрөгөөр амжилттай арилжаалсан. 2017 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэн бөгөөд нийт 41.5 мянган ширхэг бондыг 4.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна. "Сүү бонд"-ын нийт хөрөнгө оруулагчдын 43 хувь нь иргэд, жижиг хөрөнгө оруулагчид байсан бол 57 хувь нь аж ахуйн нэгж, корпорацууд байжээ. Мөн энэхүү бондын арилжааны захиалгад нийт 115 хөрөнгө оруулагч оролцсоноос долоо нь аж ахуйн нэгж байсан байна.⁶³

Бондын зах зээлд тулгамдаж буй асуудал:

Монгол улсын хувьд томоохон бөгөөд чанартай үнэт цаас гаргагчид байхгүй, хөрөнгө оруулагчдын бааз суурь цөөн, хязгаарлагдмал бүтээгдэхүүний нэр төрөл нь хөрөнгийн зах зээлийн өсөлтөд саад болж байна. Хөрөнгө оруулалтын соёл дутмаг, хөрөнгө оруулагчдын боловсролын түвшин бага байгаагаас хөрөнгийн зах зээлд итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг алдагдуулж байна. Бонд, түүнийг гаргагчид, бондын зах зээлийн талаар найдвартай мэдээлэлгүй бол хөрөнгө оруулалтыг үргээх хор уршигтай байдаг. Хөрөнгө оруулалт хийхийн тулд сайн чанартай мэдээллийг хөрөнгө оруулагчид олж авсан байх хэрэгтэй. Компанийн засаглал, ил тод байдлын шаардлагыг нэмэгдүүлэх талаар сүүлийн үед авсан арга хэмжээтэй холбогдуулан СЗХ-ноос итгэл төрүүлэхийн тулд эдгээр шаардлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх сорилт тулгарч байна. Хөрөнгө оруулагчдын бааз суурийг бэхжүүлэн өргөжүүлэхэд хил дамнасан худалдааг дэмжих бусад арга хэмжээ орно. Тиймээс хөрөнгө оруулалтын сан, кастадионы талаарх зохицуулалтыг хэрэгжүүлж, уг зохицуулалтыг улсын сайн практиктай харьцуулах явдлыг хангаж өгөх нь нэн тэргүүний ажил болж байна.⁶⁴ Мэдээллийг хангалттай нээлттэй байлгах нь чухал биш, мэдээлэл нь бүх хөрөнгө оруулагчдад хялбар, хүртээмжтэй байдлаар хүрэх нь чухал юм. Бондын зах зээлийг хөгжүүлэхэд томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Монгол улсад бондын зах зээлийн хөгжил харьцангуй доод түвшинд байгаа нь дараах хүчин зүйлээс үндсэндээ шалтгаалж байгаа болно. Үүнд: бондыг тогтмол бус гаргадаг, хөрөнгө оруулагчдад зориулсан бондын мэдээллийн сан байхгүй, өрийн удирдлагад нөлөөлөх урт хугацааны нөлөөлөл, **зах зээлийн хөгжлийг тооцолгүй яаралтай санхүүжилтийг олоход онцлон анхаардаг.**

Шийдэл байна уу?

Цаашид үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуульд бондын зохицуулалттай холбоотой шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулах, бондын бүртгэлийн зохицуулалтыг хялбаршуулж, уян хатан болгох, биржийн бус зах зээлийн зохицуулалтын орчинг бүрдүүлэх чиглэлд санхүүгийн зохицуулах хорооноос онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа нь сайшаалтай. Мөн компанийн бонд болон бусад санхүүгийн арга хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалтын шийдвэр хөрөнгө оруулагчдаас гаргахад дэмжлэг үзүүлэх ил тод байдлыг хангах үүднээс Засгийн газрын болон компанийн бонд гаргасан байдал, нийт үлдэгдэл бондын хэмжээ, нөхцөлтэй холбоотой мэдээллийн төв санг байгуулах (СЯ—дунд хугацаа)

⁶² <http://www.tdbcapital.mn/page/ipo-fpo-statistic#1>

⁶³ <http://bloombergtv.mn>

⁶⁴ <http://documents1.worldbank.org>

гэсэн санаа нь зөв алхам юм. Зүүн Азийн бүс нутгийн улс орнуудын хувьд компанийн бондын зах зээлийн хэмжээг ДНБ-тэй харьцуулахад 2 хувь ба түүнээс дээш хувьтай байгаа бол манай улсын хувьд дээрх үзүүлэлт туйлын бага дүнтэй байна. Хөгжиж буй болон хөгжингүй орнуудын туршлага, ОУ-ын байгууллагаас гаргасан зөвлөмж, судалгааны ажлуудаас үзэхэд хөрөнгийн зах зээлийг эрчимжүүлж, урт хугацааны санхүүжилтийн тогтолцоо болгон төлөвшүүлэхэд зайлшгүй компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, зах зээлд оролцогчдын үйл ажиллагааны уялдааг сайжруулсан хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, зэрэглэл тогтоогч үндэсний компанийг бий болгох шаардлагатай талаар дурдсан байдаг.⁶⁵ Манай улсын хувьд яах аргагүй хууль эрх зүйн орчинг сайжруулах хэрэгтэй.

Яагаад эрх зүйн орчин чухал вэ?

Өнөөгийн байдлаар нээлттэй зах зээлд гаргах бондтой холбоотой харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд төрөөс компанийн нээлттэй бондыг дэмжих чиглэлээр УИХ-аас 2019 онд баталсан Татварын багц хуульд нээлттэй бондын хүүгийн орлогод ногдох татварын хувь хэмжээг бууруулж татварын таатай орчинг бүрдүүлсэн.⁶⁶ **Энэ нь цаашид компаниуд нээлттэй бонд гаргахад тасралтгүй нөлөөлөх давуу талтай юм.** Дээр дурьдсан хуулиудад компанийн бондын талаар нарийн тусгаагүй байгаа юм. Энэ дутагдалтай тал нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийн идэвхийг сулруулж улмаар олон улсад нэвтрэх боломжийг хязгаарлахад хүргэж болзошгүй юм. Өндөр орлоготой, хөгжиж буй статустай болохын тулд олон улсад нэвтрэх нь чухал юм. Хэрвээ бүс нутгийн хөрөнгийн зах зээлийн хооронд хил дамнасан гүйлгээг хялбаршуулах хууль эрх зүйн орчин бүрдүүлж чадвал олон улсад нэвтрэхэд чухал алхам болох юм.

МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ 2025 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР –(2017.он.299 р тогтоол)

Уг хөтөлбөр боловсруулах хэрэгцээ, шаардлага нь: Манай улсын хувьд хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ нь ДНБ-ий 6.2 хувийг эзэлдэг бөгөөд энэ нь бусад улс оронтой харьцуулахад бага үзүүлэлт юм. Үүнд энэ салбарын хууль эрх зүйн орчин боловсронгуй болоогүй, шаардлагатай дэд бүтэц хөгжөөгүй, компанийн засаглал хангалтгүй байгаа зэрэг нөлөөлж байна гэж үзсэн байна. Энэхүү хөтөлбөрөөс хөрөнгийн зах зээлтэй холбоотой хэсгийг авч үзвэл:

- хөрөнгө оруулагчид болон үнэт цаас гаргагчдын зах зээлд оролцох идэвх сэргэж, үйлчилгээ авах нөхцөл илүү хялбар болж, тэдгээрийн эрх ашиг хамгаалагдаж, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэнэ;
- үнэт цаас гаргагчид болон зуучлагч байгууллагуудын засаглал сайжирч, өрийн хэрэгслийн зах зээл идэвхжиж, үүсмэл хэрэгслийн болон цахим технологид суурилсан шинэ төрлийн бүтээгдэхүүний зах зээл төлөвшинэ;
- олон улсын банк, санхүүгийн байгууллагууд салбараа нээх, мэргэжлийн зуучлагчийн үйл ажиллагаа явуулах, гадаадын хөрөнгө оруулалтын урсгал бий болох, ил тод, нээлттэй, шударга, үр ашиг бүхий хөрөнгийн зах зээл бий болсон байна.

Монгол улсын цаашдын зорилт төлөвлөгөө нь хөгжиж буй орнуудын жишгийн дагуу явагдаж байна. Манай улсын ирээдүйд тавьсан зорилтуудад хөрөнгийн зах зээлээ хөгжүүлж чадсан гадаад улс орнуудын авч хэрэгжүүлсэн зорилтуудтай төстэй зорилтуудыг тусгаж өгсөн нь харагдаж байгаа юм.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн ирээдүйн хөгжил:

Бодлогын хувьд: Манай улсын хувьд улс орны тогтвортой байдал тийм ч сайн биш, энэ байдал нь гаднын болоод дотоод хөрөнгө оруулагчдын итгэлийг бууруулдаг талтай, улс орнуудын бодлого, хөтөлбөрүүд нь залгамж холбоотой байдаг бол манай улсын хувьд эсрэг тохиолдол их ажиглагддаг. Тиймээс бодлогын залгамж холбоог нэмэгдүүлэх нь хөрөнгийн зах зээлийг тууштай хөгжүүлэхэд чухал нөлөөтэй байх болно.

Татварын таатай орчинг бүрдүүлэх хүрээнд: Компанийн бондын хүүгээс авах татварыг чөлөөлөх, мөн хувьцаа эзэмшигчийн ногдол ашгаас авах татварыг хөнгөвчлөх нь зүйтэй юм. Татвар бага ногдуулснаар илүү олон хөрөнгө оруулагчдыг татаж, компаниуд бонд гаргах үйл явцын цар хүрээг тэлэхэд нөлөөлөх болно.

⁶⁵ <http://www.frc.mn/a/3140>

⁶⁶ <http://www.frc.mn/a/3140>

Салбарын мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах хүрээнд: Институцийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, Кастадионы үйлчилгээг бүрэн нэвтрүүлэх шаардлагатай.(Хөрөнгө оруулагчдын оруулсан хөрөнгө нь сангийн үйл ажиллагаанаас тусдаа байх бөгөөд хөрөнгө оруулагчдын хөрөнгийг хадгалж, хамгаалж байдаг талыг кастадион (custodian) гэдэг.)

Олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд: -Эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн зах зээлийн хөгжил чухал гэдгийг сурталчлах мөн мэдээллийн хэрэгслээр мэдлэг олгох. Хөрөнгийн зах зээлийн талаар олон нийтэд мэдлэг түгээх, энэ талаарх мэдээллийг боломжтой бүхий л сувгаар олон нийтэд таниулах, сурталчлах, тусгай сургалтуудыг зохион байгуулах шаардлагатай юм.

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах хүрээнд : -Back-office -Төлбөр тооцооны програм хангамжийг шинэчлэх шаардлагатай байгаа юм. Back-office энэ нь бүтээмжийг нэмэгдүүлж, зардлыг бага байлгахад тусалдаг. Мэдээллийн дэд бүтцийг сайжруулах, санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нь сонирхогч талуудад мэдээлэл дамжуулах боломжийг олгодог байна.

Гаднын улс орны туршлага:

Бид бондын зах зээлээ хөгжүүлж чадсан гадаад орны стратеги, туршлагаас суралцаж шаардлагатай бөгөөд хамгийн гол нь алийг нь авч хэрэгжүүлбэл манай улсын хөрөнгийн зах зээл хөгжих бэ? аль нь манай оронд илүү тохиромжтой бас илүү үр дүнтэй, өгөөжтэй бэ гэдгийг анхаарах нь зүйтэй. Малайз улсын бондын зах зээлийн хөгжлийн талаар авч үзье. 1997 оны Азийн санхүүгийн хямрал нь үнэт цаасны зах зээл болон банкны салбараас гадуур санхүүжилт шаардлагатайг тод харуулсан байна. Мөн Малайз улсын 1998 оноос хойших өр төлбөр нь ихээр өссөн байна. Тиймээс энэ улсын сан бүрдүүлэх санаачилга нь үнэт цаасны зах зээл гэхээсээ илүү бондын зах зээлрүүгээ шилжсэн байна. Малайз нь бондын зах зээлээрээ бүс нутагтаа 3 т ордог. Малайз улс нь хөрөнгийн зах зээлийн 2 том мастер төлөвлөгөөг баталсан байсан бөгөөд сүүлийн төлөвлөгөө нь өмнөх төлөвлөгөөн дээрээ суурилсан залгамж уялдаатай байсан. Энэ улсын мастер төлөвлөгөө 1 нь манай улсын хувьд илүү тохиромжтой юм. Учир нь хоёрдугаар төлөвлөгөө нь хөгжсөн зах зээл дээрээ суурилсан учраас бидний нөхцөл байдалд тохиромжгүй юм. Хөрөнгийн зах зээлийн мастер төлөвлөгөө нэг дээр гаргасан 152 зорилтоос бондын зах зээлтэй холбоотой чухал зорилтыг авч өөрийн орон дээрээ тусгавал:

- Бонд гаргах үйл явцыг хялбарчлах, холбогдох зардлыг бууруулах? (хугацааг чухал гэж үзсэн)
- Хоёрдогч зах зээлд нэвтрэх боломж? (хүртээмжийг улам нэмэгдүүлэх)
- Компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхэд холбогдох зохицуулах байгууллагын хамтын ажиллагааг дэмжих? Энэ хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

Зорилт А: Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг татаж, компанийн бондын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нь чухал юм. Зах зээлд хугацаа бонд гаргагчдад хамгийн чухал байдаг. Баталгаажуулах үйл явцыг удаашрал нь зах зээлийн нөхцөл байдал өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор эргэлзээг улам нэмэгдүүлж, улмаар бондын санхүүжилтийн өртгийг өндөр болгож магадгүй юм. Иймээс компанийн бондын зах зээлд гаргагч этгээдэд зах зээлд илүү шуурхай нэвтрэх, Бондын зах зээлд илүү ил тод байдлыг хангах зорилгоор ил тод байдалд суурилсан (компанийн бондын зах зээлийн үр ашигт нөлөөлөхгүй байх) зохицуулалтын тогтолцоог нэвтрүүлэх нь чухал гэж үзсэн бөгөөд энэ бол яа одоо манай улсад яригдаж байгаа асуудал юм.

Зорилт В: Хөрөнгө оруулалтын компани ба сангийн менежментийн компанийн бондын хөрөнгө оруулалтаас олж авсан хүүгийн орлогыг татвараас чөлөөлөх ёстой. Энэ нь бондын эрэлтийг нэмэгдүүлнэ гэж үзсэн. Манай улсын хувьд татвар авдаг. (10 хувийг 2020 онд 5 хувь болгож бууруулсан)

Мөн Малайз улс нь хөрөнгө оруулагчийн эрсдэлийг бууруулж, итгэлцлийг нэмэгдүүлэн жижиглэнгийн хөрөнгө оруулагчдыг бондын зах зээлд оролцохыг дэмжихэд илүү анхаарсан байна. Харин манай улсын хувьд жижиглэнгийн хөрөнгө оруулагчдын идэвх харьцангуй сул байна.

Дүгнэлт

Монгол улсад бондын зах зээл тэр дундаа компанийн бондын зах зээлийг хөгжүүлснээр компаниудын дэд бүтэц сайжирч, цаашид хэрэгжүүлэх урт хугацааны төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг олох бөгөөд Компанийн бонд нь IPO хийхээс илүү зардал багатай, хүүгийн ашиг хөрөнгө оруулагчид хүртэх боломжтой зэрэг олон давуу талтай. Манай улсын хувьд Компанийн бондыг хөгжүүлснээр хөрөнгийн зах зээлийн хөгжил болон улсын эдийн засагт ч нэлээдгүй хувь нэмэр оруулах боломжтой.

Манай улсын хөрөнгийн зах зээлийг цаашид хөгжүүлэхэд мэдээллийн ил тод байдал, цахим орчин, дэд бүтцийн хувьд хөгжил маань бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад доогуур байгаа нь хөрөнгийн зах зээл хөгжихөд саад болж байна, хамгийн гол нь улс төрийн тогтворгүй байдал, бодлогын залгамж байхгүй байгаа нь хөгжлөөс хойш татаж байна. Хэрэгжүүлэх төлөвлөгөө, дэвшүүлж буй стратегиудын хувьд монгол улс зөв замаар явж байгаа нь сайшаалтай.

Энэ хүрээнд компанийн бондын зах зээлийг хөгжүүлэхээр санхүүгийн зохицуулах хорооноос онцгой анхаарч эхэлсэн нь цаашид хөрөнгийн зах зээлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангахад нөлөөлнө гэсэн хүлээлттэй байна. Хүнсний салбарын компаниудын үйл ажиллагаа нь эдийн засгийн аль ч нөхцөлд тогтвортой байдаг бөгөөд “СҮҮ ХК” гэх мэт үйл ажиллагаа нь тогтворжсон компаниудын хувьд хөрөнгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэхэд хөрөнгө оруулагчдын итгэл хүлээлгэх нь өндөр байсан тул МХБ дээр маш эрэлттэй байсан бөгөөд богино хугацаанд амжилттайгаар худалдаалагдан, эргэн төлөгдсөн байгаа юм. Тэд босгосон хөрөнгөөрөө үйлдвэртээ шинэ савлагааны технологийг нэвтрүүлж, шинэ бүтээгдэхүүнүүдээ зах зээлд нийлүүлж чадсан байна. Энэ боломж ямар нэг салбараас үл хамааран бусад дотоодын аж ахуй нэгжүүдэд ч нээлттэй юм. Өнгөрсөн 29 жилийн хугацаанд ердөө 19 компани бонд гаргасан бөгөөд энэ бол үнэндээ хангалтгүй үзүүлэлт юм.

Гол нь бондыг урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэр байлгах нөхцөлийг бүрдүүлэх нь чухал, зах зээлийнхээ хөгжлийг тооцолгүй, яаралтай санхүүжилт олох зорилгоор бонд гаргааа болих цаг нь болсон, илүү томоор сэтгэж, компаниуд хөрөнгө оруулагчдын итгэлийг даах чадвартай, алдагдлаа нөхөж чаддаг, түүнээсээ давсан цэвэр ашигтай ажиллаж, зах зээл дэх байр сууриа бэхжүүлэн, цаашид улам хөгжиж хэрэгтэй юм. Нөгөөтэйгүүр бид бондын зах зээлээ хөгжүүлж чадсан гаднын орны туршлагаа суралцаж, зөв бодлого, зөв замаар алхам алхмаар урагшлах л хэрэгтэй юм. Гэхдээ сүүлийн жилүүдэд монгол улсын хөрөнгийн зах зээл өмнөх үетэйгээ харьцуулахад хөгжсөөр байгаа. Бидэнд ч бас хөрөнгийн зах зээлээ бусад улс орон шиг хөгжүүлж, хөрөнгө оруулалтыг дотооддоо босгож, эдийн засгийн өсөлтөө дэмжих, компанийн бондын үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар дотоодынхоо аюулгүй байдлаа хангах боломж бүрэн байгаа юм.

Ном зүй

- <https://www.frc.mn/>
- <http://documents1.worldbank.org>
- <http://www.frc.mn/a/3140>
- <http://www.tdbcapiatal.mn/page/ipo-fpo-statistic#1>
- <http://bloombergqtv.mn>
- Санхүүгийн салбарын тойм-2017
- Монголын хөрөнгийн зах зээлийг 2020 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр, 2017он, 299-р тогтоол
- Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын төлөв байдал, Н. Энхбаатар, 2016он
- Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан санхүүгийн тайлан, 2020 он
- Малайзын хөрөнгийн зах зээлийн мастер төлөвлөгөө-1, 2000 он

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР ОНОГДУУЛАХАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Г.Хулан
ДХИС-ийн магистрант

Товч агуулга. Энэхүү судалгаагаар Монгол Улсын шууд бус татварын нийтлэг хувилбар болох нэмэгдсэн өртгийн албан татвар болон худалдааны татварын хувь хэмжээ, эрх зүйн зохицуулалт, эдгээр татваруудын хоорондын ялгаа, давуу болон сул тал; нэмэгдсэн өртгийн албан татвар түүний буцаан олголтын талаар; нэмэгдсэн өртгийн албан татварын падааны арга, түүний давуу болон сул тал, хуурамч падааны талаарх ойлголт, үр дагавар, түүнээс сэргийлэх арга зам, НӨАТ-ын падаан ашиглан хий бичилт хийж, татвараас зайлсхийх гэмт хэргийн зохицуулалт зэргийг олон улсын туршлага, чиг хандлагад тулгуурлан харьцуулан судлахыг зорилоо.

Ихэнх улс орны татварын бодлогын шинэчлэлийн зарчим нь албан татварын хувь хэмжээг зохистой түвшинд тогтоон эдийн засгаа хамгаалах зорилгоор зарим төрлийн татвар, төлбөрийн хувь хэмжээг өөрчлөх, шинээр зарим төрлийн татварыг бий болгох, татварын суурийг өргөтгөснөөр татвар төлөгчдийн ачааллыг бууруулах зэрэг цогц арга хэмжээ авахад чиглэгддэг. Монгол улсын хувьд ч мөн сүүлийн жилүүдэд татварын эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд татварын хуулийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, бизнес эрхлэгчдэд татварын таатай орчинг бий болгох үүднээс татварын хуулиудыг шинэчлэн баталж татвар төлөгчдийн татварын ачааллыг багасгах тал дээр анхаарал хандуулж байна. Ялангуяа нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг өөрчлөх, тогтоосон босгыг өндөрсгөх, буцаалтын хувийг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үүднээс хуулийн төсөл хэд хэдэн удаа хэлэлцэгдэж УИХ-ын 2015 оны 7-р сарын 9-ний өдрийн хурлаар дэмжигдэн батлагдаж 2016 оны 1-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж байгаа билээ.

Нэмэгдсэн өртгийн албан татвар нь аливаа улс орны хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагуудыг үнэн зөв санхүүгийн тайлан мэдээлэл бэлтгэдэг болгох, татварын хөндлөнгийн мэдээллийг цуглуулах найдвартай хэрэгсэл, эх үүсвэр болох ингэснээр далд эдийн засгийг багасгах, төсвийн орлогыг бүрдүүлэх, хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагыг санхүүгийн цэгцтэй тогтолцоонд оруулах ач холбогдол бүхий татвар юм.

Түлхүүр үг: Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), шууд бус татвар, худалдаа, падаан, эдийн засаг, ажил үйлчилгээ, худалдан авалт, борлуулалт.

Судалгааны хэсэг

Олон улсын түвшинд: Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас үзэхэд шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ-ыг нэвтрүүлж байна. Энэхүү татварыг нэвтрүүлсэн туршлагаас харахад улс орон бүр өөрийн онцлогт тохируулан тодорхой босготой, босгогүй нэг хувь хэмжээтэй байхаас гадна буцаалт хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг өөрийн орны онцлогт тохируулан шийдвэрлэдэг байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нь дэлхий даяар түргэн хугацаанд нэвтэрсэн бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 140 гаруй оронд хэрэгжиж байна. Дэлхийн улс орнуудын НӨАТ-ын дундаж хувь хэмжээг үзэхэд Азийн орнуудад бага буюу 12,3 хувьтай, Европын улсуудад харьцангуй өндөр буюу 20 хувьтай байна.

НӨАТ болон худалдааны татвар хоорондын ялгаатай ойлголт ба зохицуулалт

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн хүрээнд 1993 оноос Худалдааны татварыг нэмэгдүүлж, 1998 оноос НӨАТ болгон өөрчилсөн түүхтэй бөгөөд 2016 оны 01 сарын 01-нээс шинэчилсэн НӨАТ-ын хуулийг хэрэгжүүлж эхэлсэн. НӨАТ нь эрхзүйн орчны хувьд Монгол улсад хамгийн "тогтворгүй" татварын нэг ба хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш өнөөг хүртэл 40 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ хуулийн дагуу арилжаа хийж байгаа бүх мэдээлэл нь Татварын алба, Сангийн яаман дээр төвлөрөн хэрэглэгч бүр НӨАТ-ын бүртгэлийн системд баримтаа шивж 20%-ийн буцаалт авах, сугалаанд оролцох, аж ахуй нэгжийн хувьд борлуулалтын орлогоо үнэн зөвөөр тайлагнах боломжийг бүрдүүлсэн. Хуулийн өөрчлөлт нь орлого, зардалтай холбоотой маргааныг багасгах, татвараас зайлсхийх, зугтах асуудлыг бууруулах, бүртгэлийг сайжруулах давуу талуудыг бий болгосон.

Олон Улсын Валютын Сан (IMF)-аас гаргасан мэдээллээр, дэлхийн 140 гаруй улс НӨАТ-ыг төсвийн орлого бүрдүүлэх томоохон арга хэрэгсэл хэмээн үзэж, татварын системдээ нэвтрүүлж байгаа нь шууд бус татвар чухал төрөл болох нь харагдаж байна.

Онолын хувьд авч үзвэл, НӨАТ бол шууд бус татварын арга хэрэгсэл юм. Шууд татвар нь хүн ам, үйлдвэрийн газар, байгууллагын мөнгөн орлогод оногдуулдаг, ямар нэгэн борлуулалт, ажил үйлчилгээгээр дамжуулахгүйгээр авч байгаа татвар бол шууд бус татвар нь үнийн нэмэгдлийн хэлбэрээр илэрхийлэгдэж, хэрэглэгчдийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үед ногдуулж, борлуулагчаар дамжин хэрэглэгчдийн өмнөөс төсөвт төлөгддөг татвар юм.

Нэмэгдсэн өртгийн албан татвар /НӨАТ/


Бараа, үйлчилгээний хэрэглээнд ногдуулах татварыг НӨАТ гэх бөгөөд бараанд ногдох НӨАТ-ыг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрд ногдуулж, төлж байдаг. Үүнд: түүхий эд, материал худалдан авах, түүнийг боловсруулах, бэлэн бүтээгдэхүүнийг бөөний үнээр нийлүүлэх, жижиглэнгийн худалдаа эрхлэх үйл ажиллагаа зэргийг дурдаж болно. Харин үйлчилгээнд ногдуулах НӨАТ-ыг уг үйлчилгээ эцсийн хэрэглэгчид хүрэх үед ногдуулдаг.

Өөрөөр хэлбэл НӨАТ-ын гол онцлог нь татварын дарамтыг хэрэглэгчид үүрэх бөгөөд үйлдвэрлэгчдийн төлсөн татварыг хасалт хийж буцаан олгодог онцлогтой.

Түүнчлэн НӨАТ ногдох борлуулалтын хэмжээг тодорхойлоход гарах хүндрэлээс шалтгаалан банк, даатгал, үнэт цаас, санхүүгийн салбарын үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлдөг.

Нөгөө талаар НӨАТ-аас чөлөөлөгдөж байгаа этгээд нь эцсийн хэрэглэгч гэж тооцогддог. Жишээ нь банкны үйлчилгээ НӨАТ-аас чөлөөлөгддөг. Энэ нь банк өөрийн үйлчилгээний орлогодоо НӨАТ ногдуулахгүй гэсэн утгатай боловч нөгөө талаас хэрэглэгчийн хувьд бүхий л худалдан авалтдаа (дулаан цахилгаан, холбоо, интернет, ажлын байрны түрээс, тоног төхөөрөмж, програм хамгамж гэх мэт) үйлчилгээнд НӨАТ төлдөг. Иймд татвараас чөлөөлөгдөж байгаа хувь хүмүүс, хуулийн этгээдүүд, жижиг бизнес эрхлэгчид нь хэрэглэгчийн хувьд НӨАТ-ын бааз суурийг багасгадаггүй онцлогтой.

Монгол Улсын хуулиар НӨАТ ногдуулах аргачлалыг дараах жишээгээр ойлгож болох юм.



НӨАТ-ын хувь хэмжээ:

НӨАТ-ын хувь хэмжээг улс бүр өөрийн онцлогт тохируулан тогтоох бөгөөд ихэвчлэн татварын хувь хэмжээ нь 10-25 хувийн хооронд хэлбэлзэж байна. НӨАТ-ыг 10-с доогуур ногдуулах нь ховор байдаг. НӨАТ-н хувь хэмжээ дунджаар Европын холбооны улсуудад 19.5 хувь, ЭЗХАХБ-н гишүүн орнуудад 17.7 хувь, Латин Америкийн улс орнуудад 14.2 хувь, мөн Азийн орнуудын хувьд дунджаар 10.8 хувь байх бөгөөд Сингапур 7 хувь, Япон 5 хувь зэрэг цөөн орон доогуур хувь хэмжээтэй байдаг.

Харин худалдааны албан татварыг хэрэглэдэг улс орнуудын хувьд 3-8.25 хувь хэмжээ хэлбэлздэг байна.

Худалдааны татвар:

Худалдааны татвар буюу \sales tax\ нь НӨАТ-ын тогтолцоотой ойролцоо бөгөөд зөвхөн татвар ногдуулах үйлдвэрлэл үйлчилгээний түвшингөөр ялгагддаг. Үйлдвэрлэлийн

худалдааны татвар, бөөний худалдааны татвар, импортын худалдааны татвар гэх зэрэг олон хувилбартай.

Эдгээр хувилбаруудаас түгээмэл ашиглагддаг нь жижиглэнгийн худалдааны татвар юм. Энэ татварыг зөвхөн эцсийн хэрэглээнд ногдуулдаг бөгөөд бизнесийн хэрэглээнд ногдуулдаггүй. Мөн буцаан олголт хийдэггүй давуу талтай гэж тооцогддог боловч татвараас зугтах боломж илүү өндөр байдаг. Манай улсын хувьд 1998 оноос өмнө худалдааны татвартай байсан бөгөөд 1998 оны 01 сарын 06-нд НӨАТ-ын хутай хууль батлагдаж, мөн оны 07 сарын 01-ний өдрөөс хууль хүчин төгөлдөр мөрдөгдсөн.

НӨАТ болон худалдааны татварын ялгаатай ойлголт:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын давуу тал нь:
 - Төсвийн орлогын найдвартай эх үүсвэр болдог.
 - Татвар хураахад хялбар учир татварын тогтолцоог гажуудуулах нь бага.
 - Татварын хяналт шалгалт хийх нөхцөлийг бүрдүүлдэг.
 - Олон улсын нийтлэг стандарт загвартай тул Олон улсын жишигт нийцсэн татварын тогтолцоог бүрдүүлэхэд хялбар зэрэг давуу талууд олгодог.
 - Дутагдалтай тал:
 - Татварын шударга байх, төлөгдөхүйц байх зарчмуудтай зөрчилдөх \хэрэглээгээр дамжин ногдуулдаг учир татвар төлөгчийн төлбөрийн чадвартай уялдаж чаддаггүйгээс нийгмийн орлого багатай, ядуу хэсэгт татварын дарамтыг үүсгэн, шударга бус тогтолцоог бүрдүүлдэг.
 - Худалдааны татварын давуу болон сул тал:
 - Худалдааны татварын хувь удирдлага, зохион байгуулалтын хувьд НӨАТ-аас энгийн зохион байгуулалттай байдаг давуу талтай боловч татварын ачааллаын тэгш бус хуваарилалттай байна.
 - Худалдааны татварын үед нийлүүлэлтий сүлжээний эхний шатанд төлсөн татвар хоёр дахь шатны нийлүүлэгчийн борлуулалтын үнэнд шингэсэн байдаг учраас татварыг давхардуулан оногдуулдаг.
 - Худалдааны татвар нь компаниудыг үйлдвэрлэлийн орц, түүхий эдийг импортоор авах замаар дотоодын худалдан авагч татвар төлөхөөс зайлсхийх хандлагыг бий болгодог. Ийнхүү импортын бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэгч компаниудын эдийн засгийг доройтуулах хандлагыг бий болгодог.
- Энэхүү хоёр татварын давуу тал нь хадгаламж болон хөрөнгө оруулалтад хамаарахдаггүй явдал юм. Орчин үед улс орнууд, тэр байтугай хөгжилтэй гэж тооцогддог орнуудад шууд татвараас татгалзах хандлагатай болж, шууд бус татвар, тэр дундаа НӨАТ-ыг сонгох болсон байна.

Монгол Улсын НӨАТ-ын орлого цуглуулах чадвар болон НӨАТ-ын өнөө үеийн чиг хандлага

НӨАТ-ын хуулийн бүтэц, хэрэгжилтийн түвшинг НӨАТ-ын орлого цуглуулах чадвар, хэрэглээнд татвар ногдуулах чадвар гэсэн хоёр үзүүлэлтээр хэмждэг. Эдгээр үзүүлэлтүүд нь дэлхийн улс орнуудад түгээмэл хэрэглэгддэг стандарт хэмжүүрүүд юм.

1. Орлого цуглуулах чадвар=(НӨАТ-ын орлогын ДНБ-д эзлэх хувь / НӨАТ-ын үндсэн хувь хэмжээ)*100
2. Хэрэглээнд татвар ногдуулах чадвар=(НӨАТ-ын орлогын хэрэглээнд эзлэх хувь / НӨАТ-ын үндсэн хувь хэмжээ)*100

Дээрх хэмжигдэхүүнийг НӨАТ нэвтрүүлсэн орнуудын бүсчиллээр харьцуулан үзвэл Монгол Улс дараах түвшинд байна.


Хүснэгт 1. НӨАТ-ын орлого хуримтлуулах чадвар, харьцуулсан үзүүлэлтүүд

	Сахарын Африк	Америк	Европын холбоо	Төв, Дорнод Европ	Ази Номхон далай	Монгол Улс
Орлого цуглуулах чадвар	27	37	38	36	35	48

Хэрэглээнд татвар ногдуулах чадвар	38	57	64	62	58	68
---	----	----	----	----	----	----


Эдгээр үзүүлэлтүүд нь Шинэ Зеланд улсад 65 ба 103 хувьтай байж хамгийн шилдэг бүтэцтэй НӨАТ-тай улс гэж тооцогддог байхад Монгол Улсын хувьд 48 ба 68 гэсэн маш сайн үзүүлэлт гарч байна.

График 1. НӨАТ төлөгчийн тоо, жилээр



Дээрх графикаас харахад Монгол Улсын хувьд нийт НӨАТ төлөгчийн тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна. Татвар төлөгчдийн дүнд эзлэх НӨАТ төлөгчийн тоо сүүлийн 8 жилд тогтмол 20-24%- ийг эзэлж байна.

График 2. НӨАТ-ын төлөлт, жилээр



Дээрх графикаас харахад Монгол Улсын НӨАТ-ын орлого нь сүүлийн жилүүдэд жил ирэх тусам өсч байгаа бөгөөд орлого буурсан жилүүдэд уул уурхайн бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлсөн болон эдийн засгийн хямрал нүүрлэсэн үед татварын орлогын хэмжээ буурсан үзүүлэлттэй гарч байжээ.

НӨАТ-ын хуурамч падаан, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн зохицуулалт

НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх зорилгоор татвараас зайлсхийх явдлыг багасгах, далд эдийн засгийг хумих, татварын бааз суурийг нэмэгдүүлэх болон төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс НӨАТ-ын буцаан олголтыг улс орнууд хэрэглэж ирсэн.

НӨАТ-ыг тооцох хэлбэр, падааны аргын давуу болон сул тал

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь өөрийн худалдан авсан эд бараа, түүхий эд, материал, үйлчилгээндээ тодорхой хэмжээний нэмэлт өртөг шингээж шинэ бараа, үйлчилгээ бий болгох буюу шинэ хэлбэрт оруулан борлуулдаг. Иймд бараа үйлчилгээний борлуулалтаас түүнийг бий болгохтой холбоотой гарсан худалдан авалт болох түүхий эд материал, тээврийн зардал, зар

суртчилгааны зардлыг хасахад нэмэгдсэн өртөг \ажиллагсдад олгосон цалин хөлс болон ашиг\ үлдэнэ. Эндээс үзэхэд:

Нэмэгдсэн өртөг = Цалин хөлс + Ашиг = Борлуулалт - Худалдан авалт

НӨАТ-ыг үйлдвэрлэл үйлчилгээний бүх түвшинд зэрэг нэвтрүүлэхгүй бол татвараас зугтах боломж үүсгэхээс гадна татвар төлөгчдийн дунд тэгш бус байдал үүсэх хөнөөлтэй байдаг.

НӨАТ анх нэвтрүүлж буй орнууд шат шатаар ээлж дараалалтай нэвтрүүлсэн туршлагууд байдагч НӨАТ нэвтрүүлсэн орнуудыг авч үзэхэд өнөөгийн байдлаар ихэнх нь жижиглэнгийн худалдааг хамруулсан төгс суурь бүхий НӨАТ-тай байна.

Падааны аргад үндэслэсэн НӨАТ нь: Нийт татварын тогтолцоонд хяналтын үүрэг гүйцэтгэдэг давуу талтай бөгөөд хамгийн шилдэг “мөнгөний машин” гэж нэрлэгдэх болжээ. Тиймээс НӨАТ-ыг дэхийн улс орнууд түгээмэл нэвтрүүлсээр байгаа юм.

НӨАТ-ын падаан нь татварын механизмыг бүрэн ажиллуулах үндсэн хэрэгсэл нь болдог. Энэ нь татвар төлөгчийн хувьд бараа ажил, үйлчилгээг НӨАТ-тай борлуулсан, худалдан авсан баримт болж тайлан гаргахад гол үүрэгтэй байхад татварын албаны хувьд татварын шалгалт хийх, илүү төлөлтийг буцаан олгох, цаашилбал аливаа маргааныг шийдвэрлэхэд нотлох баримт болж өгдөг.

➤ НӨАТ-ын падаан нь:

-Борлуулагчийн нэр хаяг,

-НӨАТ төлөгчийн дугаар

-НӨАТ-ын падааны дугаар

-Падаан олгосон огноо

-Бараа ажил үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, үнэ

-НӨАТ-н хувь хэмжээ

-Ногдуулсан НӨАТ

-НӨАТ-тай бүгд үнэ

-Худалдан авагчийн нэр, татвар төлөгчийн дугаарыг үзүүлсэн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт юм.

Гадаадын ихэнх улс орнуудад НӨАТ-ын падааныг 2 хувь үйлдэж борлуулагч, худалдан авагч талуудад нэг нэг хувь үлдээдэг. Монгол Улсын хувьд 2012 оны 05 сарын 01-ны өдрөөс эхлэн НӨАТ-ын падааныг 2 хувь үйлдэж, худалдагч болон худалдан авагч талууд нэг, нэг хувийг авч, НӨАТ-н тайланд цахим хэлбэрээр хүргүүлдэг болсон. Энэ тохиолдолд татварын албанаас НӨАТ төлөгч талын хуулийн этгээдийн регистрийн дугаараар тулган, хяналт шалгалтыг хийж байна. Энэ нь нэг талаасаа татварын албаны хяналт шалгалтыг сайжруулах, НӨАТ-ын хуурамч падааныг ашиглах арга замыг зааж байгаа хэдий ч өнөөгийн манай улсын хувьд цахим хэлбэрээр тайланг өгөх, авах нь бүрэн төгс болоогүйгээс хуурамч падааныг ашиглах явдал байсаар байна.

Улс орнуудын туршлагаас үзэхэд гаалийн бүрдүүлэлтийн баримт, татварын албанд бүртгэлтэй кассын машины талон, цахилгаан дулаан, харилцаа холбоо, усан хангамж зэрэг нийтлэг үйлчилгээ үзүүлдэг компаниудын зөвшөөрөгдсөн нэхэмжлэл, баримтыг НӨАТ-ын падаантай адилтган үздэг байна.

Ийнхүү падаан нь зөвхөн НӨАТ-ын биш харин нийт татварын ногдуулалт, няглан бодох бүртгэл хөтлөлтөд чухал нөлөөтэй хэрэгслийн хувьд түүнийг хуурамчаар үйлдэх, тоо цифрийг нь засаж будлиануулах явдал цөөнгүй гардаг байна. Иймээс ч НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэд хяналт тавья гэвэл падааныг хянах нь чухал.

НӨАТ-ын хуурамч падааны тухай ойлголт, эрүүгийн эрх зүйн ойлголт болох нь:

Монгол улсын нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.3-т нэгдсэн дугаар бүхий нэмэгдсэн өртгийн албан татварын падаан гэж борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, тэдгээрийн нэгжийн болон нийт үнэ, түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын хэмжээг тусгасан, татварын албанаас олгосон нэгдсэн дугаар бүхий нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичиг гэж тодорхойлсон байна. Падаан нь НӨАТ төлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн төсөвт төлөх болон бэлтгэн нийлүүлэгчид төлсөн НӨАТ-ын хасалтыг тодорхойлж, тайлан гаргах үндэслэл болно.

Манай улсын татварын тогтолцоонд НӨАТ-ын хуурамч падаан ашигласан тохиолдолд хуулиар нарийвчлан зохицуулаагүй бөгөөд НӨАТ, ААНОАТ хуулиудаар торгууль, алданги

төлүүлэх хариуцлага хүлээлгэхээс гадна нь энэхүү үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйл "Татвар төлөхөөс зайлсхийх"-ээр зүйлчилдэг байна.

- НӨАТ-аас зайлсхийх дараах аргуудыг ангилан үзвэл:
- Хуурамч падаан ашиглах
- Борлуулалтаа дутуу тусгах
- НӨАТ төлөгчөөр бүртгүүлэхгүй байх
- Татвар ногдуулах үнэлгээг өөрчлөх
- Хугацаанд нь татвар төлөхгүй байх
- Хасалтыг зохиомлоор нэмэгдүүлэх
- Хууль тогтоомжийг хортойгоор ашиглах зэргийг хамруулна.
- Хүлээлгэх хариуцлагыг хувьд:

Татварын болон бусад хууль тогтоомжийн тогтолцооноос шалтгаалан татвар төлөгчдөд хүлээлгэх хариуцлагын хэлбэр нь олон янз байдаг. Тэдгээрийг ерөнхийд нь захиргааны болон эрүүгийн гэж ангилж болох ба мөнгөн торгуулиас эхлэн баривчлан хорих хүртэл шийтгэл оногдуулдаг байна.

- НӨАТ-ын хувьд хууль зөрчсөн дараах тохиолдлуудад хуулийн хариуцлага ногдуулахаар зааасан байдаг.
- Хууль тогтоомжийн дагуу НӨАТ төлөгчөөр бүртгүүлэхгүй байх
- НӨАТ падаан олгоогүй болон олгохоос татгалзсан
- Зохих шаардлагын дагуу бүртгэл хөтлөөгүй байх
- Эрх бүхий байгууллагад шаардлагатай мэдээлэл өгөхөөс татгалзах
- Тайланг хугацаанд нь ирүүлэхгүй байх
- Татварыг хугацаанд төлөөгүй байх
- Хуурамч падаан үйлдэх, авах, засварлах
- Тайланг санаатайгаар будлиантуулах, тооцооллыг буруу үйлдэх
- НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй этгээд НӨАТ нэхэмжлэх
- Хуурамч баримт бүрдүүлэн буцаан олголт авах, илүү төлөлтөө бусад татварын өрөнд суутгуулах гэх мэт хариуцлагуудыг ногдуулдаг байна.


Дэлхийн жишигт татвар төлөхөөс зайлсхийх нь татварын эрх зүйн зөрчлийн хамгийн дэлгэрсэн төрөл мөн. Тэдгээр улс орнуудын хууль хэрэглэх практикаас үзэхэд татвар төлөхөөс зайлсхийх болон татвараас бултах гэсэн хоёр ойлголтыг ангилан авч үздэг байна.

НӨАТ-ын буцаан олголтын талаарх гадаадын зарим орны туршлага

НӨАТ-ын талаарх дэлхийн чиг хандлага:

НӨАТ нь орчин үед ашиглагдаж байгаа "эцсийн хэрэглээнд ногддог" хэрэглээний татварын 2 төрлийн нэг юм. Энэ татвар нь дэлхийн бусад улс орнуудад түгээмэл байсан үйлдвэрлэгчдийн худалдааны татвар (жишээ нь: Канад Улс), бөөний худалдааны татвар (Австрали, Шинэ Зеланд), худалдан авалтын татвар (Нидерланд), үйлдвэрлэлийн түвшний НӨАТ (БНХАУ) зэрэг шууд бус татварын 4 хувилбарыг орлон гарч ирсэн. Шууд бус татваруудын боловсронгуй бус, үр ашиггүй байдал нь НӨАТ-ыг дэлхийн даяар түргэн хугацаанд нэвтэрэхэд хүргэсэн. Ялангуяа, энэ үед татварын шинэчлэлүүд ихэвчлэн бизнес эрхлэлт, бизнесийн шийдвэр гаргахад сөрөг нөлөө үзүүлдэг гүйлгээний татваруудыг өөрчилж, хүчингүй болгоход чиглэгдэж байсан. Ийнхүү нээлттэй эдийн засаг бүхий дэлхийн улс орнууд бизнесийн ашиг болон эцсийн хэрэглэгчдэд буюу хувь хүмүүсийн хэрэглээнд шууд бус татвар ногдуулдаг тогтолцоо руу тасралтгүй шилжсээр байна.

График 3. НӨАТ-ын хувь хэмжээ (бүс нутгаар)



НӨАТ-ын хувь хэмжээний хувьд Азийн орнуудад дунджаар 12,3 хувь, Америк, Номхон далайн орнуудад дунджаар 13 хувь, Африкийн орнуудад 15 хувьтай байна. Харин Европын улсуудад дунджаар 20 хувьтай байгаа нь дэлхийн бусад оронтой харьцуулахад 5 хувиар өндөр байгаа нь дээрх графикаас харагдаж байна. Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас харахад шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ нь татварын орлогын 25 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нь шууд бус татварын тогтолцоо нь илт давуу байр суурь эзэлж байна.

Орчин үеийн эдийн засагч, эрдэмтэд нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг хүн төрөлхтний түүхэнд хамгийн өргөн тархсан төсвийн орлого бүрдүүлэх шилдэг татвар гэж үздэг байна. Дэлхийн хоёрдугаар дайнаас хойш нийтдээ 140 гаруй улс уг татварыг нэвтрүүлсэн байна. НӨАТ нь ихэнх улсад амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд төсвийн орлогын 18-40 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тодорхой шалтгаанаар цөөн тооны улс орнуудад энэ татвар амжилт олоогүй туршлага байдаг. Тухайлбал, Гана Улс татварын босгыг хэт бага тогтоосноос татвар төлөгчдийг хянах, татварын орлогыг бүрдүүлэх ажиллагааны зардал татварын орлогоосоо давж байсан нь тухайн үед НӨАТ-ын татварыг зогсооход хүрч байсан байна. Харин Япон Улсад анх “хэрэглээний татвар” нэртэйгээр тогтоосон НӨАТ нь иргэдийн амьдралд хэт дарамт учруулснаар тус татварыг хүчингүй болгосон бөгөөд 1989 онд 3 хувьтайгаар дахин тогтоож, улмаар 1997 онд 5 хувьд хүргэж амжилттайгаар нэвтрүүлсэн байна. Европын Холбооны хувьд НӨАТ нь Засгийн газрын орлогын (төсвийн) гол эх сурвалжуудын нэг юм. 2000 оноос хойш НӨАТ-ын орлого нь ДНБ-ний 0.6 хувиар өсч, улмаар төсвийн орлогын чухал эх үүсвэрүүдийн нэг болсон. Өөрөөр хэлбэл, НӨАТ-ыг амжилттай хэрэгжүүлж буй 140 гаруй улсын туршлагаас нэгтгэн үзэхэд НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй гол үр нөлөө нь төсвийн орлогыг бүрдүүлэгч гол эх үүсвэрийн нэг болж буй нийтлэг үр дүн харагдаж байна. Гэвч НӨАТ-ын орлоготой холбоотойгоор тулгарч буй гол асуудлуудын нэг нь татвараас зайлсхийх явдал болоод байна. Иймд татвараас нуусан мөнгөн хөрөнгийн эргэлт буюу далд эдийн засгийг ил болгох нь НӨАТ-ын орлогын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх чухал ач холбогдолтой юм. Татвараас зайлсхийх хоёр төрлийн арга зам байх бөгөөд энэ нь:

1.Хууль тогтоомжийн хүрээнд татвараас зайлсхийх, эсхүл татварыг хүчингүй болгох (цуцлах) – эдийн засгийн үр ашгийг хүртэхийн тулд хуулийн цоорхойг ашиглан татвараас зайлсхийх;

2.Хууль бусаар татвараас зайлсхийх – хууль зөрчин татвараас зугтах замаар эдийн засгийн үр ашгийг өөртөө авах гэсэн хоёр төрлийн арга зам байна. Иймд НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх зорилгоос үүдэн татвараас зайлсхийх явдлыг багасгах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс татварын урамшууллын нэг төрөл болох НӨАТ-ын буцаан олголтыг улс орнууд хэрэглэж ирсэн.

Дүгнэлт

Цөөн улс орныг эс тооцвол НӨАТ-ын систем нь стандарт тогтолцоотой бөгөөд хөрш орнууд болон эдийн засгийн төстэй бүтэцтэй зарим орны хувьд манай орны нөхцөлд тохирохуйц нэг талаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх, нөгөө талаас татвар төлөгчдөд учирч буй дарамтыг бууруулах сонирхолтой туршлагууд ажиглагдаж байна.

НӨАТ-ын Эдийн засагт үзүүлж буй үр нөлөө Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас харахад шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ нь татварын орлогын 25 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нь шууд бус татварын тогтолцоонд илт давуу байр суурь эзэлж

байгааг харуулж байна. Судалгаанаас үзэхэд, НӨАТ-ын буцаан олголт эдийн засагт эерэг үр нөлөөг үзүүлж байгаа бөгөөд Үүнд:

Иргэдийн оролцоог идэвхжүүлэх замаар НӨАТ төлөгчдийг татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх чухал үр нөлөөтэй мөн татвараас зайлсхийх замаар нуугдан үлддэг байсан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх, иж бүрэн бүртгэлийн тогтолцоог бий болгох замаар далд эдийн засгийг хумих, татварын бааз суурийг тэлэх, татвар төлөгчийн худалдааны эргэлт болон хариуцлагыг сайжруулах, албан бус секторт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлж, татварын тохирох хувь хэмжээ тогтоон бодлогын шийдвэр гаргах боломж бүрдэх зэрэг эерэг үр нөлөөнүүдийг үзүүлж байна.

Ном зүй

- Б.Гантуяа “НӨАТ-ын тогтолцоог боловсронгуй болгох асуудал” 2006 он
- Г.Гантулга Ч.Өнөржаргал “НӨАТ-ын хуулийн хэрэгжилтэнд тулгамдаж байгаа зарим асуудлууд”, 2010 он
- “Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар” Ханнс Зайделийн сан, 2010 он
- “НӨАТ-ын буцаан олголт, гадаадын зарим орны туршлага” Судалгаа, шинжилгээний хэлтэс, 2013 он
- НӨАТ тухай хууль, 2016 он
- Монгол Улсын Статистикийн эмхэтгэл
- Татварын ерөнхий газрын мэдээллийн эмхэтгэл, www.mta.mn
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем , www.legalinfo.mn

ХИЛ ДАМНАСАН ЦАХИМ ХУДАЛДААНЫ БОДЛОГО, АНХААРАХ АСУУДАЛ

Ц.Сонор

ДХИС, ХААИС-ийн эдийн засгийн аюулгүй байдал
судлалын магистрант

Цахим худалдаа⁶⁷ нь онлайн үйлчилгээ эсвэл интернетээр дамжуулан бүтээгдэхүүнийг цахим хэлбэрээр худалдаж авах, борлуулах үйл ажиллагаа юм. Энэ нэр томъёог Калифорнийн мужийн ассемблейн нийтийн аж ахуй, худалдааны хорооны үндсэн зөвлөх, доктор Роберт Жейкобсон Калифорнийн Цахим худалдааны тухай хуулийн гарчиг, текстэнд Хорооны дарга, талийгаач Гвен Мур (DLA.) удирдан боловсруулсан. 1984 онд батлагдсан. Цахим худалдаа нь гар утасны худалдаа, цахим сангийн шилжүүлэг, хангамжийн сүлжээний удирдлага, интернет маркетинг, онлайн гүйлгээ боловсруулах, цахим мэдээлэл солилцох (EDI), бараа материалын менежментийн систем, мэдээлэл цуглуулах автоматжуулсан систем зэрэг технологид тулгуурладаг. Цахим худалдаа нь эргээд хагас дамжуулагч үйлдвэрлэлийн технологийн дэвшилд хөтлөгдсөн бөгөөд электроникийн салбарын хамгийн том салбар юм.

Орчин үеийн цахим худалдаа нь World Wide Web-ийг гүйлгээний амьдралын мөчлөгийн дор хаяж нэг хэсэгт ашигладаг боловч имэйл гэх мэт бусад технологийг ашиглаж болно. Ердийн цахим худалдааны гүйлгээнд онлайн ном худалдан авах (Amazon гэх мэт) болон хөгжмийн худалдан авалт (iTunes Store гэх мэт дижитал түгээлтийн хэлбэрээр хөгжим татаж авах), бага хэмжээгээр захиалгаар / хувийн болгосон онлайн архины дэлгүүрийн бараа материалын үйлчилгээ орно. Цахим худалдааны гурван чиглэл байдаг: онлайн худалдаа, цахим зах зээл, онлайн дуудлага худалдаа. Цахим худалдаа нь цахим бизнесээр дэмжигддэг.

Цахим (интернет) худалдааны бизнесүүдэд дараахь зүйлийг хамааруулж ойлгоно:

- Жижиглэнгийн худалдааны онлайн дэлгүүрүүд нь хэрэглэгчдэд шууд вэбсайт, мобайл аппликейшн, шууд чат, чат-бот, дуут туслахуудаар дамжуулан харилцан ярианы худалдаа эрхэлдэг.
- Гуравдагч этгээдийн бизнесээс хэрэглэгчид (B2C) эсвэл хэрэглэгчидээс хэрэглэгчид (C2C)-ийн борлуулалтыг боловсруулдаг онлайн зах зээлээр хангах, үүнд оролцох.
- Вэб холбоо, нийгмийн сүлжээгээр дамжуулан хүн ам зүйн мэдээллийг цуглуулах, ашиглах
- Бизнесээс бизнесийн (B2B) цахим мэдээллийн солилцоо
- Валютын солилцоо, арилжааны зорилгоор онлайн санхүүгийн биржүүд

ELECTRONIC COMMERCE; ELECTRONIC TRADE	ЦАХИМ ХУДАЛДАА
Online-initiation; crossborder transaction/ shipment; and destined to consumers (commercial and noncommercial). Often referred to simply as e-commerce, the term is used to describe business that is conducted over the Internet using any of the applications that rely on the Internet, such as e-mail, instant messaging, shopping carts, Web services, UDDI, FTP, and EDI, among others. Electronic commerce can be between two businesses transmitting funds, goods, services and/or data or between a business and a customer. (Trade Facilitation Terms: An English - Russian - Chinese Glossary, UNECE, 2019)	Онлайн сэдэл (эхлэл); хил дамнасан хэлцэл/ачилт (тээвэрлэлт); тэгээд (худалдаа эрхэлдэг болон худалдаа эрхэлдэггүй) хэрэглэгч нарт хүргэх (нийлүүлэлт). Ихэвчлэн цахим худалдаа гэдэг. Энэ томъёог Интернетээр хийгддэг бизнесийг тодорхойлох зорилгоор ашигладаг. Интернет гэдэгт цахим шуудан, яаралтай зурвас, худалдааны саргс, вэб үйлчилгээ, UDDI (Universal Description, Discovery, and Integration – Түгээмэл тодорхойлолт, нээлт, интеграци), FTP (File Transfer Protocol - Файл дамжуулах протокол), EDI (Electronic data interchange -мэдээллийг цахимаар харилцан дамжуулах) г.м. зүйлс хамаарна. Цахим худалдааг хөрөнгө, бараа, үйлчилгээ болон/эсхүл мэдээлэл дамжуулж буй хоёр компанийн хооронд, эсхүл аль нэг

⁶⁷ (<https://en.wikipedia.org/>)


	кормпани, хэрэглэгчийн хооронд явуулж болно. (Худалдааг хөнгөвчлөх нэр томъёоны англи, орос, хятад глоссари, НҮБ-ын Европын эдийн засгийн комисс, 2019 он)
TRADE FLOW	ХУДАЛДААНЫ УРСГАЛ
Purchase and sale of goods and services between countries or regions (exports and imports). Used to measure the balance of trade.	Улс орон, эсхүл бүс нутгийн хооронд бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон худалдах (экспорт ба импорт). Худалдааны тэнцлийг хэмжихэд ашигладаг.
Mode 1: Cross-border Trade in Service (Supply of Services)	Хэлбэр 1: Хил дамнасан үйлчилгээний худалдаа (Үйлчилгээний нийлүүлэлт):
Definition: services supplied from the territory of one WTO Member into the territory of any other Member Example: A user in country A receives services from abroad through its telecommunications or postal infrastructure.	Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын нутаг дэвсгэрээс нөгөө нэг гишүүн улсын нутаг дэвсгэрт нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: “А” улс дахь хэрэглэгч А цахилгаан холбооны хэрэгсэл буюу шуудангийн үйлчилгээ ашиглан гадаадаас үйлчилгээ авах, тухайлбал, зөвлөгөө авах, зах зээлийн судалгаа авах, телевизээр эмчилгээний зөвлөгөө авах, зайн сургалтад хамрагдах, уран барилгын схем зураг авах;
Mode 2: Consumption abroad	Хэлбэр 2: Хилийн чанад дахь үйлчилгээ:
Definition: services supplied in the territory of one WTO Member to the service consumer of any other Member Example: Nationals of country A have moved abroad as tourists, students, or patients to consume the respective services.	Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын нутаг дэвсгэрт нөгөө нэг гишүүн улсын хэрэглэгч нарт нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: “А” улсын иргэд аялахаар, суралцахаар, эсхүл эмчлүүлэхээр гадаад явах; 238 АНГЛИ МОНГОЛ
Mode 3: Commercial presence	Хэлбэр 3: Арилжааны төлөөлөл:
Definition: services supplied by a service supplier of one WTO Member, through commercial presence, in the territory of any other Member Example: The service is provided within country A by a locally-established affiliate, subsidiary, or representative office of a foreign-owned and — controlled company (bank, hotel group, construction company, etc.).	Тодорхойлолт: ДХБ-ын нэг гишүүн улсын үйлчилгээ үзүүлэгч нөгөө гишүүн улсын нутаг дэвсгэрт арилжааны төлөөллөөрөө дамжуулан нийлүүлж буй үйлчилгээ. Жишээ: Гадаадад байгаа этгээдийн эзэмшил (өмчлөл)-д буюу хяналтанд байгаа гадаад дахь компани (банк, зочид буудлын сүлжээ, барилгын компани, г.м.)- ийн “А” улсад байгуулсан салбар байгууллага буюу төлөөлөгчийн газраас “А” улсад нийлүүлж буй үйлчилгээ;

Дэлхийн гадаад худалдааны чиглэл

Орон зайг багасгагч технологиуд (Distance-shrinking technologies), даяаршилд нөлөөлж буй нэг гол хүчин зүйл бол техник, технологийн дэвшил юм. DST нь хүмүүсийг илүү хялбар аргаар холбогдох, дэлхийн өнцөг булан бүрт түргэн шуурхай зорчих, нэгэн зэрэг мэдээллийг хүлээн авах боломжийг олгож байна.


Технологийн дэвшил нь улс төр, эдийн засаг, соёлын салбар дах даяаршлын хурдасгуур болж байна.

Цахим худалдаа (бизнес) тэр дундаа онлайн худалдаа нь улс орны хөгжилд шинэ боломж, шинэ нөхцөл байдлыг бий болгож байна. Өнөөдөр хил хязгааргүй интернэт орчинд дэлхийн 7 тэрбум хүнээс 3,4 тэрбум гаруй нь холбогдож, улмаар улс орнуудын эдийн засаг платформ эдийн засаг хэлбэрт шилжиж байна.



Дээрх графикаас харахад дэлхийн нийт худалдааны 1221.29 биллеон доллар, борлуулалын 17 хувь, худалдан авагчийн 40.4 хувийг цахим худалдаа нь дангаараа эзэлдэг болсон.

Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт, Экспорт, импорт, тэнцэл, жилээр



Хэмжих нэгж: сая ам.доллар

Дээрх графикаас харахад монгол улсын нийт худалдаанаас цахим худалдааны мэдээллийг ялган харах боломжгүй, хүндрэл үүсч байгаа нь харагдаж байна.

Цахим худалдаа нь даяаршлын далайцтай жишээ болж, түргэцтэй хөгжиж байна. Хил дамнасан цахим худалдаан дахь биет барааны худалдааны өсөлт нь өсөлт хөгжлийн шинэ хөдөлгөөр гарган ирж, худалдааны шинэ хэлбэрүүдийг дэлгэрүүлж, хэрэглээний шинэ чиг хандлагыг удирдан жолоодож, шинэ ажлын байр бий болгох замаар дэлхий эдийн засагт асар их боломжийг бий болгож байна. Ийм урьд өмнө нь байгаагүй өсөлт нь бизнес эрхлэгчид

(бизнесийнхэн, компаниуд) болон хэрэглэгчид бараа бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, худалдах болон худалдан авах арга замыг шинэчлэн өөрчилж байгаа хувьсгал болж, барааг урьдчилан ачуулах, хүргэх, төлбөрийг урьдчилан хийх өргөн сонголтыг бий болгож байна. Мөн энэ цахим худалдааны өсөлт нь микро (бичил), жижиг, дунд үйлдвэрийн газрууд (МЖДҮ) гадаадын зах зээлд өргөн хүрээтэйгээр нэвтрэн гарах саад бэрхшээлийг багасгаж, мөн зардлыг бууруулж, энэ утгаараа тэдэнд дэлхийн эдийн засгийг нээж өгч байна. Үүний зэрэгцээ, хил дамнасан цахим худалдаа нь, ялангуяа бизнес эрхлэгчдээс хэрэглэгчид (B2C) болон хэрэглэгчээс-хэрэглэгчид (C2C) чиглэсэн хэлцлүүд нь засгийн газруудын өмнө олон шинэ сорилтуудыг бий болгож, бас олон шинэ боломжуудыг олгож байна. Энэхүү хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй худалдааны орчин нь гаалийн байгууллага зэрэг оролцогч бүх талаас урьд өмнө байгаагүй өсөлтийг зохицуулах, олон улсын стандарт болон заавар боловсруулж гаргах, мөн үүнтэй холбоотой хилийн эрсдэлүүдэд анхаарал хандуулахад чиглэсэн шийдлүүдийг бүрэн утгаар нь, мөн сайтар тунгаан бодож гаргах шаардлага үүссээр байгаа.

Тал бүрийн оролцогчийн оролцоотойгоор цахим худалдааны асуудлыг хамтран өргөн хүрээтэй судалгаа, зөвлөгөөн дээр суурилан, цахим худалдааны гол хөшүүргүүдийг эрх хайх, бизнесийн одоо байгаа загваруудыг судлах, одоогийн болон ирээдүйн чиг хандлагыг харж үзэх, худалдааг хөнгөвчлөх болон хяналт тавих гол зарчмуудыг тогтоох, шилдэг туршлагуудаас цуглуулах, уян хатан шийдлүүд боловсруулах ажлуудыг хийж ирсэн. Хил дамнасан цахим худалдааг хөнгөвчлөх зорилготой дэлхийн багц стандарт, холбогдох заавар болон зөвлөмжийг цахим худалдаанд оролцогч талууд, хэрэглэгчид, гаалийн байгууллага болон төрийн холбогдох бусад агентлагийг үл ялгаварлан бүгдийнх нь хэрэгцээ шаардлагад нийцсэн байдлаар зохицуулалтыг сайржуулсаар байх шаардлага өдөр бүр бий болж байгаа билээ.


Хил дамнасан цахим худалдааг үр өгөөжтэй бөгөөд үр ашигтай хэлбэрээр удирдан зохицуулах түлхүүр нь эрсдэлийг эрт тооцох боломжтой байх, мөн хууль ёсны хэлцлүүдийн бүрдүүлэлтийг автомат орчинд, хөндлөнгийн оролцоо (хяналт шалгалт) хамгийн бага хэмжээнд байхаар хийж гүйцэтгэхийн тулд үнэн зөв мэдээллийг төгс байдлаар, шууд эх сурвалжаас нь цагт нь авч ашиглах явдал юм.

Цахим худалдааны хэмжээ өргөжин хөгжиж, хэрэглэгч нар түргэн шуурхай бүрдүүлэлт, хүргэлтийг хүсэн хүлээж байгаа нь бас гаалийн байгууллага болон төрийн холбогдох бусад албадад татвар хураан авах болон хяналт шалгалт хийх шинэ загварууд хэрэгтэй болж байгааг илтгэн харуулж байгаа хэрэг болно. Хил дамнасан цахим худалдаа олон улсыг хамарсан шинж чанартай болж байгаа нь цогц бөгөөд уялдсан ажиллагааг шаардаж байна. Нэг талаас засгийн газрууд (төр), нөгөө талаас цахим худалдаанд оролцогч талууд хүмүүсийн болон эдийн засгийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ дэлхийн эдийн засагт хувь нэмэр болох прагматик (бодитой, амьдралд ойрхон), шударга бөгөөд шинэлэг шийдлүүд боловсруулан гаргаж, хэвшүүрэх шаардлагатай.

Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн байдал

Манай улсын ихэнхи ААН, төрийн байгууллагууд интернэт сүлжээгээр дамжин онлайн-аар бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд яаж хүргэх гэдэг рүү тэмүүлж байгаа. Гэхдээ бидэнд туршлага байхгүйгээс алдаа оноотой байгаа ч сүүлийн 2 жилд ойлголт нь нэг шат ахисан гэж үздэг. Энэ салбар цааш хөгжихөд бид том системээр нь харах хэрэгтэй. Бид АНУ, барууны орнуудыг жишиг болгохоос илүүтэйгээр Хятад, Орос хоёр хөршөө харах

хэрэгтэй



Дээрх графикт дэлхийн 151 ороноос (дэлхийн худалдаанд голлох үүрэг гүйцэтгэдэг) Хятад улс 2024 он гэхэд цахим худалдааны борлуулалтаа 80%-д хүртэл өсгөх зорилго тавьсан нь харагдаж байна.

Цахим худалдаа нь үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, банк, онлайн төлбөр, логистик, даатгал зэрэг бүх салбарыг хамарч эдийн засгийг хүчирхэг болоход нөлөөлдөг. Урд хөршид үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд том бизнесүүд дэлхийн зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэх гол суваг нь “Alibaba” боллоо. Энэ тухай ярьвал платформ эдийн засгийн тухай ярих болно. Төр ч бай, хувийн хэвшил ч бай бүгд л онлайн болох нь эцсийн зогсоол байх болно.

Жишээ: Хятад улсад интернэт худалдаа хөгжихөд барууны загвар ажиллахгүйг баталсан жишээ бол “eBay” байна. Тухайн үед “eBay” барууны арга барилаар Хятадын зах зээлд ажлаад улмаар амжилтгүй, ашиггүй ажиллах болсон. Харин “Alibaba” эсрэгээр нь “eBay” дээр хийгдсэн маркетинг, борлуулалтын идэвхижүүлэлтийг яг эсрэг нь хийснээр зах зээлээ тэлсэн түүхтэй.

Монгол улсын цахим худалдааны орчинг судалж үзвэл доорхи графикуудаас тодорхой барамжаалал авч болж байна.



- Цахим худалдааны Платформ-д нэгдэх боломж хэнд байдаг бэ?
Импорт эрхлэгчид ААН, хувь хүн (Бөөний)
Retail буюу гаднаас бараа оруулан өөрсдийн дэлгүүр, лангуугаар борлуулагч ААН,
хувь хүн
Хувь хүмүүс (Facebook –ээр борлуулагчид)
Үндэсний үйлдвэрлэгчид
- Одоогийн бараа эргэлтийн хэмжээ:
 - Бэлэн барааны интернет зах зээлийн одоогийн нийт бараа эргэлтийн хэмжээ сарын 300~500 сая төгрөг
 - Энэ тоо ойрын 3 жилд 100 дахин өсөх боломжтой

Цахим худалдааны эрх зүйн зохицуулалт

Цахим худалдаанд техник, эдийн засгийн, нийгэм ба соёлын олон талын асуудал холбогдоно. Эдгээр асуудлыг тусгаж бүхэлд нь авч үзэх, эрхзүйгээр зохицуулах шаардлага гардаг. Тухайлбал, цахим хэлбэрээр хийгдсэн арилжаа хүчинтэй байх асуудал, түүнээс урган гарах хууль зүйн үр дагавар эрхзүйн бусад асуудал мэдээллийн хамгаалах, татвар төлөх, гаалийн татвар ногдуулан барагдуулах, аюулгүй байдлыг хангах, оюуны өмчийн эрхийн хамгаалах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, маргаан шийдвэрлэхтэй холбоотой асуудлууд болон интернет үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын хариуцлага, хууль бус үйлдэл болон гэмт хэрэг, интернетийн засаглал, цахим арилжаа явуулах төлбөр тооцооны тогтолцоо зэрэгтэй холбоотой асуудлууд багтана.

Дэлхийн гаалийн байгууллага (2018 оны 6 дугаар сар) Хил дамнасан цахим худалдааны багц стандартыг баталсан бөгөөд энэхүү багц стандарт нь гаалийн байгууллага болон төрийн холбогдох бусад агентлаг, үйлдвэр аж ахуйн салбар, эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн мэргэжилтнүүдийн хамтын туршлага болон мэдлэгт тулгуурласан ба хилийн хяналтын үйл ажиллагааг стандартчилах, уялдуулахад хувь нэмрээ оруулах бүх оролцоог багтаахыг эрмэлзсэн байдаг.

Цахим худалдааны олон улсын эрх зүйн зохицуулалт, стандарт:

- Дэлхийн худалдааг аюулгүй байлгах болон хөнгөвчлөх Аюулгүй байдлын багц стандарт
- Хил дамнасан цахим худалдааны багц стандарт
- Бараа худалдах, худалдан авах олон улсын гэрээний тухай Венийн конвенц
- Иргэний болон арилжааны асуудлаарх шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх тухай Брюсселийн конвенц
- Иргэний болон арилжааны хэргийн асуудлаар гадаадын шүүхийн шийдвэр, маргаан шийдвэрлэх шүүхийн харьяаллын тухай Гаагийн конвенц
- Маргаан шийдвэрлэх шүүхийг сонгох зөвшилцлийн тухай Гаагийн конвенц
- Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай конвенц

Монгол Улс дахь цахим худалдааны эрх зүйн зохицуулалтын байдал:

- Иргэний хууль
- Харилцаа холбооны тухай хууль
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
- Цахим гарын үсгийн тухай хууль

Дүгнэлт

ХИЛ ХЯЗГААРГҮЙ ЗАХ ЗЭЭЛ буюу Цахим худалдаа нь улс орнуудад экспортод чиглэсэн худалдааг өсгөж Дэлхийн зах зээлд хүргэх гол суваг болсоор байна.

Иймд Монгол улс ч бас хилийн менежментийг улам боловсронгуй болгох, мөн худалдааг хөнгөвчлөх ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, шаардлагатай арга хэмжээг авч, урт хугацааны гадаад худалдааны тогтвортой бодлогоор хууль ёсны цахим худалдааны системээр улсын бренд бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд экспортлох хэрэгтэй гэж үзэж байна.

Хэрхэн шийдэх вэ?

- Хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх шаардлага, нөхцлийг илрүүлэх
- Эдийн засгийн хямралын үед экспортод баримжаалсан худалдаа, үйлчилгээг интернэт худалдааны платформ ашиглан хил хязгааргүй зах зээлд гарах боломжийг олох
- Дотоодын хэрэглэгчдийн онлайн зан төлөв ямар түвшинд байгаа, хэрхэн өөрчлөгдөж байгаа, цаашид хэрхэн хувьсах хандлагыг мэдэх
- Интернэт худалдааны НЭГДСЭН (нэг багц) тасралтгүй систем хэрхэн бүрэлддэг, бидний оролцоо юу байх талаар цогц ойлголттой болж, шинэ боломжуудыг олж харах, түүнийг бизнесүүддээ ашиглах
- НЭГДСЭН тасралтгүй системийг бүрдүүлж буй салбар бүрийн төлөөллүүд өөр хоорондоо харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах.

Цахим худалдаанд оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад анхаарах зарим асуудал:

- Оюуны өмчийн асуудал
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал
- Татварын асуудал
- Өгөгдөл, мэдээллийн хамгаалалт

Ийнхүү НЭГДСЭН тасралтгүй систем ашигласан экспорт хийснээр улсын ДНБ эрс өсөх боломжтой гэж дүгнэж байна.

Ном зүй

- <https://www.statista.com/>
- Хууль зүйн үндэсний хүрээлэн <http://nli.gov.mn>
- Монгол банк <https://www.mongolbank.mn/>
- Гаалийн ерөнхий газар <https://www.customs.gov.mn/>
- ДХБ-ын 2018 оны 06-р сард баталсан Хил дамнасан цахим худалдааны багц стандарт

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ҮЕИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

*Н.Амартүвшин
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

Товч агуулга. Энэхүү өгүүлэлд газар хөдлөлтийн ойлголт, түүний хор уршиг, газар хөдлөлтийн аюул тохиолдсон үед цагдаагийн байгууллагаас төрийн бусад байгууллагатай хамтран ажиллахад тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замын талаар дурдсан.

Түлхүүр үг: Газар хөдлөлт, Магнитуд, Газар хөдлөлтийн эрсдэл, эмзэг байдал, чадавхи, газар хөдлөлтийн балл.

Үндсэн хэсэг. Өнөө үед дэлхий дээр тохиолдож буй аюулт үзэгдэл, гамшгийн тоо харьцангуй нэмэгдэж, түүнээс учрах хор уршигийн үр дагавар улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд энэхүү аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах асуудлыг улс орон бүр өөр, өөрийн эдийн засаг, нийгэм, байгаль, цаг уурын одоогийн байдал, цаашдын хандлага, үндэсний аюулгүй байдал, хөгжлийн бодлого, стратегийн бодлоготой хамааруулан авч үзэх цаг болсон байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Монгол Улсад байгалийн аюулт үзэгдэл жилийн аль ч улиралд цөөнгүй тохиолдож нийгэм, эдийн засаг, аж ахуйн нэгж, ард иргэдийн өмчид ихээхэн хохирол учруулж, хэвийн үйл ажиллагаанд нь сөрөг нөлөө үзүүлсээр байна.⁶⁸

Байгалийн гамшгийн аюул, үйлдвэрлэл, техник, технологийн шинжтэй осол, сүйрэл сүүлийн жилүүдэд дэлхийн болон бүс нутагт харьцангуй нэмэгдэж, энэ утгаараа дэлхийн хүн амын тодорхой хэсэг гамшиг, ослын гашуун зовлонд байнга нэрвэгдсээр байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлд “Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан байдаг. Иргэдээ эрүүл аюулгүй орчинд аж төрүүлэх нь төрийн байгууллагаас ихээхэн хамааралта болж байна.

Монгол улсын Үндсэн хуульд Улсын их хурлын онцгой бүрэн эрхийг зааж өгсний дотор онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно⁶⁹ гэж заасан байдаг. Үүнд:

- Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;
- Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон¹.

Гамшиг гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг⁷⁰ ойлгоно. Гамшиг нь байгалийн давагдашгүй хүчин зүйл буюу аюулт үзэгдэл, хүнээс шалтгаалсан хэлбэрээр тохиолддог.

⁶⁸ Г.Даваадорж, С.Цогтбаатар. аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. УБ. 2009. 5 дахь тал

⁶⁹ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

⁷⁰ Төрийн мэдээлэл. 2017. №7. Гамшигтай тэмцэх тухай хуулийн 4.1.1.

Эдгээр гамшгуудын нэг болох газар хөдлөлт нь маш богино хугацаанд асар их хохиролыг учруулж байдаг аюулт үзэгдэл юм. Өөрөөр хэлбэл байгаль орчинд ихээхэн хохирол учруулдаг онцлогтой үзэгдэл юм. Байгаль хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд “байгаль орчин” гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээт хүрээлэл хамаарна” хэмээн тодорхойлсон байна.

Геологийн гаралтай аюулт үзэгдлийн дотроос газар хөдлөлт нь урьдчилан мэдэх боломжгүйгээр гэнэт тохиолдож, ихээхэн хохирол учруулдаг байгалийн хамгийн аюултай үзэгдэл юм. Монгол Улс Төв Азийн газар хөдлөлтийн хамгийн идэвхитэй бүсэд оршдог.⁷¹

Газар хөдлөлтийн улмаас хүн амд учрах хохирлыг тооцохдоо оршин суугчдын тоо, барилгын эвдэрч, нурах магадлалд үндэслэн, оршин суугчдын нэрвэгдэх магадлалаар тодорхойлно.⁷²

Газар хөдлөлт нь магнитудаар тодорхойлогдоно. Магнитуд нь газар хөдлөлтийн цар хүрээг илэрхийлэх газар хөдлөлтийн чичирхийллийн голомтын энергийн хэмжээг заах тоон хэмжигдэхүүн юм. Магнитуд нэгээр нэмэгдэхэд ялгаа нь 30 дахин, магнитуд хоёроор нэмэгдэхэд ялгаа нь 1000 дахин их байна.

Газар хөдлөлтийн улмаас үүсэх хохирлын хэмжээ, түүний тархах цар хүрээ нь монгол орны хувьд “магнитуд 7”-ийн үед нэг аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд, “магнитуд 8”-ын үед хэд хэдэн аймгийн газар нутгийг хамарч хохирол үүсгэх магадлалтай гэж тооцогддог.

Газар хөдлөлт гэдэг нь дэлхийн цардас хэмээх чулуулаг давхаргаас тогтох хавтангуудын шилжих хөдөлгөөний дүнд үүсэн бий болсон хэлбэлзэл хол зайд дамжин шилжин ирсний үр дүнд үүсдэг газар доорхи түлхэлт буюу дэлхийн гадаргуугын хэлбэлзэл юм”⁷³ хэмээн тодорхойлсон байна.

Газар хөдлөлтэй холбоотой эрх зүйн харилцаанд дараах нэр томъёонууд хэрэглэгддэг байна. Тухайлбал:

Газар хөдлөлтийн аюул гэж газар хөдлөлтийн улмаас хөрсөн дээр үүсэх чичирхийллийг хэлнэ. Газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас үүсэх хөрсний шингэрэлт, хөрсний гулсалт, хадны нуранги үүсэх, хөрс хагарах зэрэг тектоник үзэгдэл, газар хөдлөлтийн улмаас үүсэх гал түймэр болон бусад дагалдах аюул хамаарна.

Газар хөдлөлтийн эрсдэл Газар хөдлөлтийн аюулын улмаас тодорхой газар, цаг хугацаанд таамаглаж буй үр дагавар (хүний амь нас, барилга байгууламж, дэд бүтэц (биет эвдрэл))-д үүсэх магадлалын шинж чанар, эсвэл эдгээр эвдрэл хохирлын улмаас үүсэх нийгэм, эдийн засагт учирсан хор уршгийг хэлнэ.

Эмзэг байдал. Газар хөдлөлтийн аюул, ялангуяа чичирхийлэлд тэсвэрлэх чадвар сул, муу байдлаар илэрхийлэгдэнэ. Уг зааварт барилга байгууламж, дэд бүтцэд газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас үүсэх хохирлын хэр хэмжээг тодорхойлсон ойлголт юм.

Чадавх. Газар хөдлөлтийн аюул, түүнээс учрах ялангуяа чичирхийллийг тэсвэрлэх чадвар сайн байдлаар илэрхийлэгдэнэ. Чадавх нь агуулгаараа эмзэг байдлын эсрэг ойлголт.

Газар хөдлөлтийн балл. Газар хөдлөлтийн чичирхийллийн нөлөөллийн хэмжээг илэрхийлэх тоон үзүүлэлт бөгөөд дэлхийн улс орнуудад хэд хэдэн төрлийн хэмжигдэхүүн хэрэглэгдэж байна. Монгол Улсад хэрэглэгдэж байгаа МСК-64 газар хөдлөлтийн баллын шаталбарыг доорх хүснэгтэд харуулав. МСК шаталбар нь чичирхийллийн биет хэмжээ (хөрсний гадаргууны хурдатгал)-тэй адил байдаг.

Барилгын эвдэрч, нурах магадлал. Уг зааварт газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас барилга, байгууламжийн эвдэрч нурах магадлалыг тоон утгаар илэрхийлсэн хувь,

⁷¹ Г.Даваадорж, С.Цогтбаатар. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. УБ. 2009. 5 дахь тал

⁷² Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл. УБ.2020. 9 дэх тал

⁷³ П.Баттогтох, Б.Баяржаргал. Гамшиг ослоос хамгаалах тухай гарын авлага. УБ. 2006. 13 дахь тал

хэмжээг хэлнэ. Эвдэрч нурах магадлал 10% гэдэг нь үнэлгээ хийж барилгатай адил бүтээцтэй 10 барилга байвал 1 нь эвдэрч, нурна гэсэн утгатай юм. Барилгын эвдэрч, нурах магадлал нь үнэлгээ хийж барилгатай адил бүтээцтэй нийт барилгын хэдэн хувь нь эвдэрч нурах эсэхийг заах бөгөөд барилга тус бүрийн эвдрэлийн түвшинг заахгүй.

Зам, инженерийн шугам сүлжээний эвдрэх магадлал. Газар хөдлөлтийн чичирхийллийн улмаас зам, инженерийн шугам сүлжээний эвдрэх магадлалыг илэрхийлэх бөгөөд уг зааварт замын нэвтрэх боломжгүй болох цэгийн тоо/км, цэвэр бохир усны шугам хоолой, дулааны шугам хоолой, цахилгаан дамжуулах шугамын хувьд эвдрэл үүсэх цэгийн тоо/км, цахилгааны шонгийн хувьд нурах шонгийн хувь хэмжээг заана.

Газар хөдлөлт болсон онцгой нөхцөл байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллаж болох вэ? Аливаа онцгой нөхцөл байдлын үед төрийн байгууллагуудын хамтын харилцан ажиллагааг цаг хугацаагаар нь:

- Урьдчилан сэргийлэх хамтын харилцан ажиллагаа
- Онцгой нөхцөл байдлын үеийн хамтын харилцан ажиллагаа
- Онцгой нөхцөл байдлын дараах үеийн хамтын харилцан ажиллагаа гэж хэсэгчилсэн байдлаар сэн хэлбэртэй байж болно.

Эдгээр хамтын харилцан ажиллагааны хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх хамтын харилцан ажиллагаа чухал юм. Жишээ нь: Японд тохиолдсон газар хөдлөлтийн дараа зохиогдсон сургалтанд ажилласан Монголын ОБАЭБ-ын ажилчид Японы дурын нэг цэцэрлэгийг сонгон ороход тэнд суралцаж байсан цэцэрлэгийн хүүхдүүдийн энгэрт шүгэл зүүлттэй байсан. Тухайн цэцэрлэгийн сонгосон ангийн гэрлийг унтрааж харанхуй орчин үүсгэхэд ангиар нэг шүгэлний дуу тас хийснийг сургалтанд хамрагдсан алба хаагчид гайхан ярьж байв.⁷⁴

Сонирхуулахад цэцэрлэгийн хүүхдүүдийн нэг нь ч зүүлттэй шүглийг авч хаях нь байтугай шүглээр тоглох ч үгүй байсан гэдэг. Иймд урьдчилан сэргийлэх хамтын харилцан ажиллагааны хувьд тодорхой хэдэн байгууллага биш нийгмийн бүхий л салбар идэвхитэй оролцох нь чухал юм.

Зөвхөн ХХ зуунд газар хөдлөлтийн гамшгаас хэдэн арван сая хүн амь насаа алдаж, олон тэрбумаар хэмжигдэх эдийн засгийн хохирол учирч байсан ба нийт болсон байгалийн гамшигт үзэгдлүүлдтэй харьцуулахад 50.9 хувийг эзэлсэн тоо баримт байдаг.⁷⁵

Газар хөдлөх үзэгдэл нь олон хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн асар их хохирол сүйрэл дагуулж байдгийг бид түүхэн гашуун баримтуудаас мэднэ.

Ган, зуд, хар салхи, усны үер, гал түймэр гэх мэт байгалийн бүхий л гамшигт үзэгдэлтэй харьцуулахад маш богино хугацаанд асар их хохирол учруулдаг үзэгдэл бол хүчтэй газар хөдлөлт юм. Хүчтэй газар хөдлөлт нь жилийн аль ч улиралд, өдөр шөнө ялгалгүй гэнэт тохиолдож, эгшин зуурын хугацаанд нийгэмд асар их хохирол, гамшиг учруулдаг.

Хүн төрөлхтөн ХХ зуунд хүчтэй газар хөдлөлтөөс амссан гамшигийг байгалийн бусад үзэгдлээс үүссэн гамшгийн хэмжээтэй харьцуулахад талаас их буюу 50,9% эзэлсэн тоо баримт байдаг. Өнгөрсөн зуунд дэлхийн хэмжээнд болж, хамгийн их хохирол учруулсан 30 орчим газар хөдлөлтөөр ойролцоогоор 1,5 сая хүний амь нас үрэгдсэн ба олон тэрбумаар хэмжигдэх эдийн засгийн хохирол гарч байсан тухай судалгаа байдаг.

Газар хөдлөлтөөр газрын гадаргуу чичирч, заримдаа эвдрэлд орно. Газар хөдлөлтөөр хөрсний гулсалт үүсэж, галт уул идэвхижиж болно. Томоохон газар хөдлөлт далайд тохиолдвол *цунами* үүснэ.

⁷⁴ Онцгой нөхцөлийн үеийн төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2015. 38 дахь тал

⁷⁵ П.Дамдин. "Гамшгийн эрсдлийг бууруулах менежмент". УБ. 2005. 61 дэх тал

Ерөнхий тохиолдолд *газар хөдлөлт* гэдэг ойлголтод байгалийн болон хүний нөлөөгөөр үүсэх бүх төрлийн чичирхийлэлийг багтааж байна. Газар хөдлөлт нь царцдаст үүсэх хагарал, ихээхэн хэмжээний хийн ихэвчлэн (газрын гүн дэх метан) шилжилт, галт уулын үйл ажиллагааны идэвхижилт, хөрсний гулсалт, минаны тэсрэлт, цөмийн бөмбөгийн туршилт зэргээр үүсдэг байна.

Газар хөдлөлтийн голомт үргэлж газрын гүнд байдаг. Түүнд хамгийн ойрхон байрлах газрын гадаргуу хэсэг нь эпицентр болдог.⁷⁶

Өнөөдрийн байдлаар манай улсад харьцангуй бага хохирол учруулах хэмжээний газар хөдлөлт болж байгаа хэдий ч давтамж нь ойртож, балл нь улам нэмэгдэх хандлагатай байна.

Газар хөдлөлтөөр газрын гадаргуу чичирч, заримдаа эвдрэлд орно. Мөн хөрсний гулсалт үүсэж, галт уул идэвхжиж болно. Далайд үүсвэл цунами үүснэ. Ерөнхийдөө газар хөдлөлт гэдэг ойлголтонд байгалийн болон хүний нөлөөгөөр үүсэх бүх төрлийн чичирхийлэлийг багтааж байна.

Газрын гадарга дээрхи болох доорхи долгионоос үүссэн газрын чичиргээ нь дараах үзэгдлийг дагуулна. Үүнд:

- Хөрсний эвдрэл
- Давтан хөдлөлт
- Цунами
- Чичирхийлэлт
- Хөрс усжих
- Хөрсний гулсалт, нуралт⁷⁷

Газар хөдлөлт болсны дараа бий болох түгээмэл дараах сөрөг нөлөөллүүд бий болдог байна. Тухайлбал:

Бие хохирол- байшин барилга нурж, гал түймэр гарах, зам хагарч цууран ангал цав гарах, цахилгааны холбооны шугам унаж эвдрэн холбоо тасрах, далан нурах гэх мэт дэд бүтэц дахин ашиглах боломжгүй болон сүйрч, томоохон гол мөрөн үерлэх, хөрсний гулсалт, эвдрэл бий болон хохирол учрах.

Хүний амь нас- газар хөдлөлтийн улмаас хүн ам ихээр нягтран суурьшсан нутаг дэвсгэрт байшин барилга ихээр нурж, хүмүүс олноороо дарагдан амь насаа алдах

Эрүүл мэндийн асуудал- хамгийн их тулгардаг асуудал бол гэмтэл бэртэл авах явдал юм. Газар хөдлөлт хүн ам ихээр суурьшсан нутаг дэвсгэрт болбол түргэн тусламжийн асуудал хурцаар тавигдах бөгөөд үерийн улмаас ундны цэвэр ус бохирдох, ариун цэвэр алдагдах, түүнчлэн цэвэр усны хомсдол бий болох, халдварт өвчин тархах.

Газар хөдлөлт болж онцгой нөхцөл байдал үүссэн үед түүнд ажиллах төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудыг тодорхой болгож, чиг үүрэг, оролоог нь зохицуулсан хууль, журам, хамтран ажиллах төлөвлөгөө, эрх зүйн актуудыг гаргах нь зүйтэй юм.

Газар хөдлөлтийн бүлгүүд галын аюулгүй, бэлэн байдлыг сайн дурын болон оногдсон үүргийн хэмжээнд хянах, галын хор, хэрэгслийг засах, дахин цэнэглэх, олон нийтийн хамгаалалтын төхөөрөмжийн тохижуулалт, ажиллагааг хянах зэрэг олон чухал үүргийг гүйцэтгэж чадна.⁷⁸

Цагдаагийн байгууллагаас онцгой байдлын албатай хамтран газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Тухайлбал:

⁷⁶ Г.Даваадорж, С.Цогтбаатар. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. УБ. 2009. 5 дахь тал

⁷⁷ О.Үржин. Ш. Болдбаатар. Гамшгийн менежмент. Дэд дэвтэр. УБ. 2004. 22 дох тал

⁷⁸ О.Үржин. Ш. Болдбаатар. Гамшиг ба бусад асуудлууд. Гутгаар дэвтэр. УБ. 2004. 58 дахь тал

1. Тухайн хот, суурингийн нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн геологи, геофизикийн судалгаа, дүгнэлт хийлгэсний үндсэн дээр газар хөдлөлтийн бичил мужлалыг тодорхойлуулах;
2. Газар хөдлөлтийн улмаас үүсч болзошгүй хохиролыг үнэлэх, холбогдох гарын авлагыг ашиглах;
3. Газар хөдлөлтийн аюулын тухай зарлан мэдээлэх дохио, журам тогтоох;
4. Хүн ам, мал сүрэг, үнэт материалыг аварч хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан байх;
5. Газар хөдлөлтийн агшинд ард иргэдийн ажиллах журмыг тогтоож, түүний дагуу сургууль, дадлага зохион байгуулж байх;
6. Газар хөдлөлтийн хяналтын станц, лабораторын шинжилгээ хийж, үр дүнг нь орон нутгийн засаг захиргаанд мэдээлж байх;
7. Хүн амыг түр байрлуулах байр, сууцны нөөцийг бэлтгэх;
8. Газар хөдлөлтийн хөнөөлийн голомтоос хүн амыг нүүлгэн шилжүүлэх бүх төрлийн хяналтын бэлтгэлтэй байх;
9. Нэрвэгдсэн хүн амд шаардагдах хүнс, хувцас, эмийн нөөц бэлтгэх хэмжээнд байлгах;
10. Хоёрдогч хөнөөл үүсгэх бодис, материалыг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах, багасгах;
11. Хот суурин, барилга байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх явцад газар хөдлөлтийг тэсвэрлэх техникийн нөхцлийг хангасан норм, стандартын хэмжээнд нь хяналт зохион байгуулах;
12. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах (техник, материал, усан сан, усны нөөц гэх мэт) бэлтгэлийг хангах;
13. Газар хөдлөлтийн голомтод аврах ажлыг гүйцэтгэх хүч хэрэгслийг зохион байгуулж сургаж бэлтгэсэн байх;⁷⁹

Өнөөдөр газар хөдлөлтийн аюул учирсан тохиолдолд авах арга хэмжээний чиглэлээр цагдаагийн байгууллага болон бусад байгууллагатай хэрхэн хамтран ажиллах чиглэлээр дадлага, сургалт явагдахгүй байгаа нь гарч болох эрсдэл, учирч болох хохирлыг улам нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Газар хөдлөлтийн хор аюул тохиолдсон үед хэрэгжүүлэх арга хэмжээнд дараах хүчин зүйлүүд нөлөөлдөг байна. Гамшиг тохиолдсон үед хэрэгжүүлэхэд нөлөөлөх нийтлэг хүчин зүйл:

- Бэлэн байдлын төлөвлөгөөний бодит байдал;
- Гамшгийн цар хэмжээ, аюулын түвшин;
- Эрт зарлан мэдээлэл явуулах боломж;
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бэлтгэгдсэн байдал;
- Тасралтгүй найдвартай ажиллагаа явуулах чадвар;
- Хор уршгийг арилгах арга хэмжээг зөв тодорхойлох;

Тэгвэл газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед хэрэгжүүлэх голлох арга хэмжээнүүдийг дурдваас:

- Гамшгийн голомтыг хязгаарлах, таслан зогсоох;
- Үүссэн хүнд нөхцөл байдлыг арилгах;
- Амьдралын чухал хэрэгцээг хангах системийг сэргээх;
- Цаашид үргэлжлэх аюул хохирлыг багасгах;
- Сэргээн босгох арга хэмжээний үндсийг тавих;

Нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

⁷⁹ П.Дамдин. "Гамшгийн эрсдлийг бууруулах менежмент". УБ. 2005. 61 дэх тал

- Аврах ажлыг зохион байгуулах;
- Нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, эмчлэх;
- Түр орогнох орон байраар хангах;
- Ундны ус, хоол хүнсээр хангах;
- Холбоо, эрчим хүчээр хангах;
- Эрүүл мэнд, ариун цэврийн хяналт тогтоох;
- Нийгмийн дэг журам сахиулах, аюулгүй байдлыг хангах;
- Голомтонд байгаа хүмүүсийг амьдрах нөхцлөөр хангах;
- Зам гарц гаргах, нүүлгэн шилжүүлэх;
- Нэрвэгдсэн хүн амд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх;
- Олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийг хүргэх, хуваарилах;

Цагдаагийн алба хаагчдаас газар хөдлөлтийн аюул учирсан тохиолдолд аюулын голомтын бүсэд дээрхи ажил, арга хэмжээг бие даан авч хэрэгжүүлэх, бэртэж гэмтсэн иргэдэд тусламж үзүүлэх, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох, эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, төрийн бусад байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах арга зүйн чиглэлийн мэдлэг, ур чадвар ямар түвшинд байгаа нь анхаарал татсан асуудал болоод байна.

Иймээс төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх үүднээс доорхи асуудлыг дэвшүүлж байна.

- Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааг онцгой нөхцөл үүссэн үед өөрсдийн ажлын онцлог, чиг үүрэгт нь уялдуулсан эрх зүйн баримт бичиг гаргах.

Монгол Улсад газар хөдлөлт болж онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн байгууллагуудын хамтын ажиллагааны талаар нарийвчлан зохицуулж өгсөн хууль, эрх зүйн акт, баримт бичгүүд хангалтгүй байгаа тул тийм нөхцөл үүссэн үед зөвхөн тухайн үүссэн нөхцөлд давамгайлах үүрэгтэй *хуулиар харъяалуулсан чиг үүрэг бүхий ажилтнууд* оролцох субъектүүд бие дааж үйл ажиллагаа явуулах хандлагатай байдаг.

Жишээ нь: Цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн хэв журам хамгаалах, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага гамшиг, онцгой байдал, гал түймэр гэх мэт асуудлаар, Хил хамгаалах байгууллага хилийн дэглэм, хилийн аюулгүй байдалтай холбогдсон асуудлаар гэх зэрэг бусад төрийн байгууллага тус тусийн чиг үүргийн дагуу онцгой нөхцөл байдлын үед ажилладаг.

Газар хөдлөлт болсон тохиолдолд олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа ямар байх нь анхаарал татаж байна. Шаардлагатай түвшинд ажиллаж чадах уу гэдэг асуудал туйлын чухал. Энэ талаар харьцангуй бодитой дүгнэхийн тулд онц байдал зарлахаас өмнө ба хойш гэж зааглаж үзвэл зүйтэй санагдана.

Газар хөдлөлт болж, улсын хэмжээнд онц байдал зарлахаас өмнө Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд, Засгийн газрын гишүүд, цагдаа тагнуулын байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа шуурхай байж чадах нь учир дутагдалтай. Ерөнхийдөө, цочирдсон, балмагдсан, эргэлзэж тээнэгэлзсэн, дээрээс үүрэг даалгавар хүлээзнэсэн, бие биерүүгээ утасдаж мэдээлэл солилцсон байдалтай тийм л дүр зураг төсөөлөгдөж байна.

Хаана, юу болж байсан бэ гэдгийг зураглах гээд оролдвол, цагдаа нар халуун цэг дээр ажиллаад байдаг, Зэвсэгт хүчин, хилийн цэргийн хувьд, онц байдал зарлахаас өмнө дэг журам сахиулахад оролцох хуулийн заалтгүй, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гурван гишүүн гурван өөр газарт байвал хэрхэн асуудлыг шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа нь тулгамдсан асуудал юм.

Тэгвэл эдгээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын өөрсдийн чиг үүрэгтэй нь уялдуулсан байдлаар эрх зүйн акт гаргах

боломжтой юм. Жишээ нь газар хөдлөлтийн улмаас үүсэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үед тэнд байгаа объект, авто машины галын аюулгүй байдлыг Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, жагсаал цуглааныг албадан тараах үед олон хүнд нөлөөлөх болон, нэг хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний улмаас гэмтэж бэртсэн этгээд, болон алба хаагчдын гэмтэл бэртэлд эмнэлэгийн байгууллага эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх, бусад байгууллага объектод гал гарсан тохиолдолд галын онцгой байдлын гал унтраах авто машин болон усан хөөргийг цэнэглэх боломжийг бүрдүүлж өгөх \гудамж, талбай болон байгууллагын гадна усны хоолой байрлуулах\ зэрэг байдлаар зохицуулсан эрх зүйн баримт бичиг гаргах боломжтой юм.

- Удирдлага зохион байгуулалтын тал дээр анхаарч үзэх. Монгол улс “Мэдээлэл шуурхай удирдлагын төвтэй” болоод даруй 4 жилийг үджээ. Гэтэл гамшиг, ослийн дуудлага мэдээлэл, гэмт хэрэг, захиргааны зөрчлийн талаарх мэдээлэл, эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбогдсон мэдээлэлд байгууллага бүр өөр өөрсдийн чиглэлээр мэдээллийг хүлээн авч удирдлагаар хангадаг байх жишээтэй.

Тэгвэл өнөөдөр дэлхий нийтээр олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажил үүрэгтэй холбогдсон мэдээллийг зөвхөн ганц утсаар өгдөг. Ийм улс орнуудаас дурьдвал Америкийн нэгдсэн улс бүх дуудлагаа ганц 911 гэсэн дугаарт залгаж өгдөг. Үүнийг манайд хэрэгжүүлэх бүрэн боломжтой. Өөрөөр хэлбэл байгууллага бүр өөрсдийн ажил үүрэгтэйгээ холбогдсон мэдээлдэлд өөрсдийн нөөц бололцоогоор оролцдог биш ганцхан утсаар дуудлага мэдээллийг иргэд, аж ахуй нэгжээс өгөхөд “Мэдээлэл шуурхай удирдлагын газраас” зохицуулалтуудыг хийж байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах шуурхай байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ, ТУЛГАМДАЖ БУЙ ЗАРИМ АСУУДАЛ

*Б.Зоригт
ДХИС-ийн магистрант, цагдаагийн ахмад*

Товч агуулга. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын явц, үр дүн, тулгарч буй хүндрэл, түүнийг шийдвэрлэх арга зам болон Завхан аймгийн цагдаагийн газраас урьдчилсан сэргийлэх чиглэлээр нэвтрүүлсэн туршлагын талаар товч тусгасан болно.

Түлхүүр үг. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, хамтын ажиллагаа, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ, мэдээлэл

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) нь Монгол Улсад 1992 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд түүнээс хойш тус бүр таван жилийн хугацаатай дөрвөн байгаль хамгаалах стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлээд байна. 2017-2021 оны хооронд хэрэгжүүлсэн байна.

2017-2021 оны хооронд хэрэгжүүлэх таван жилийн стратеги төлөвлөгөөнд нэн ховор, ховор амьтан, ургамал болон цэнгэг усны экосистем, ойн нөөцийн хамгааллыг олон талын оролцоонд тулгуурлан өргөн хүрээтэй зохион байгуулан ажиллахаар тусгасан байдаг.

Мөн тус стратеги төлөвлөгөөнд Монгол орны амьтан, ургамлыг устгах аюулд хүргэж буй гол 7 хүчин зүйлсэд хариуцлагагүй уул уурхай, оновчгүй дэд бүтцийн хөгжил, хууль бус агнуур, амьтан, ургамлын эд эрхтэн, бүтээгдэхүүнийг хууль бусаар худалдаалах, уур амьсгалын өөрчлөлт, бэлчээрийн доройтол, хариуцлагагүй газар тариалан орж байгааг тогтоосноос гадна эдгээр хүчин зүйлс дээр ядуурал болон ажилгүйдлийн асуудал нэмэгдэж, улмаар байгалийн нөөцийг зохисгүй ашиглах явдал газар авсаар байгаа нь байгаль орчин доройтох нэмэлт нөхцөл болж байна хэмээн тодорхойлжээ.⁸⁰

Монгол Улс өргөн уудам нутагтай, хүн ам тархан суурьшсан байдлыг овжин ашиглах гэсэн оролдлогууд өдрөөс өдөрт нэмэгдэх болсон. Өөрөөр хэлбэл, хүний үйлдлээс хамаарсан байгаль орчны эсрэггэмт хэргүүд ихсэж байна. Тэдний энэ үйлдэл зөвхөн байгаль орчинд сөрөг нөлөөтэй гэхээсээ илүүтэй уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байгаа юм.⁸¹

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргүүд нь үндэсний аюулгүй байдалд бодит аюул учруулж байдаг, нийгэмд аюултай, өргөн тархсан хууль бус үйлдлүүдийн нийлбэр юм.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх криминологи прогноз буюу урьдчилан харалтыг тодорхойлох нь арга зүйн хувьд боломжтой боловч одоогоор урьдчилан харалтыг огт тодорхойлохгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа ганц нэг байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг биш бөгөөд дангаараа тэмцээд үр дүн багатай болохыг дэлхийн олон улс орнуудын явуулж ирсэн үйл ажиллагааны туршлагуудаас харж болохоор байна.

Хуул сахиулах байгууллагууд шаардлагатай хүч хэрэгслээр бүрэн хангагдаагүй байдаг учир хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгтэй байгаль хамгаалах болон мэргэжлийн хяналт, шалгалтын бусад байгууллагуудтай тогтмол хамтран ажиллах шаардлага үүсэж байдаг.

Төрийн байгууллагуудад хуулиар хүлээлгэсэн маш олон чиг үүрэг байдаг бөгөөд ялангуяа хүрээлэн буй орчны гэмт хэрэгтэй тэмцэх нийтлэг үүрэг хууль, хяналт шалгалтын

⁸⁰ Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд. Сургалтын гарын авлага. УБ.2019. 11 дэх тал

⁸¹ <http://www.arslan.mn/58026/sitem>

олон байгууллагууд иргэд, олон нийтийн дэмжлэг туслалцаан дээр тулгуурлан хамтран ажиллахыг хууль тогтоомжид тусгасан байдаг.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хууль сахиулах, хэрэгжүүлэх, хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа гэмт хэрэг гарахад нөлөөлж байгаа шалтгаан, нөхцлийг арилгахад чиглэгдсэн урт хугацааны системтэй, нөр их ажил бөгөөд бүх нийтийн идэвхийг өрнүүлсний үндсэн дээр зохион байгуулагдах цогц арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл, хамтын ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, дэг журмыг сахиулж, хуулийн хэрэгжилтийг хангах зорилгод нэгтгэгдэн, байгууллагууд хоорондоо харилцан зөвшил⁸²цсөний үндсэн дээр эрх тэгш, өөрсдийн хэм хэмжээний хүрээнд салбарынхаа онцлогт тохируулж, үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах ажиллагаа гэж ойлгож болно.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх зайлшгүй нэг хүчин зүйл нь хамтын ажиллагаа бөгөөд байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулах явдал хамгаас чухал юм.

Зохицуулалт нь аливаа ажил үйлдлийн хооронд зүй зохист харьцаа, хамаарал тогтоох, уялдуулах, нийцүүлэх гэсэн гол утгыг илэрхийлдэг байна. Тодруулбал, олон төрийн чиг үүрэгтэй байгууллага, ажилтны үйл ажиллагааг уялдуулан холбож, харилцан бие биений ажиллагаанд зохистой харьцаа тогтооход зохицуулалтын зорилго оршдог.

Олон төрлийн байгууллага өөрсдийн өмнөх нийтлэг зорилтыг хүч хамсан шийдвэрлэхийн тулд тус тусын гүйцэтгэх үүрэг, гаргах хүч хөрөнгө, уг ажлыг эхлэх дуусгах хугацаа, хэрэгжүүлэх, дүгнэх арга, хэлбэр зэрэг олон талын асуудлыг урьдчилан тохиолцох буюу товлон тогтоож, түүний дагуу практик үйлдлүүдийг хооронд нь хэлхэж, холбож өгөх, ингэснээрээ тухайн ажил үүргийг хийдүүлэх, давхардуулж зэрэгцүүлэх явдлаас сэргийлж, объект (жишээ нь, дотоод шатны байгууллагууд)-ыг хүндрүүлэхгүй байх, улмаар цаг, хүч, хөрөнгийн хэмнэлт гаргахад зохицуулалтын ач холбогдол илэрдэг⁸³

Сүүлийн үед хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлын чанар дээшилж, тэдний хамтын хүчин чармайлтаар хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн гэмт хэргийн гарал буурч, иргэдийн эрх зүйн боловсрол, хүмүүжлийн болон урьдчилан сэргийлэх ажлын систем тогтож, нэгдмэл үйл ажиллагаа явуулах туршлага зохих хэмжээгээр хуримтлагджээ.

Улсын хэмжээнд энэ оны эхний 11 сард хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 1707 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгасан нь урьд оны мөн үеэс бүртгэгдсэн гомдол 946 буюу 1.2 дахин өссөн байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг энэ оны эхний 11 сард нийт 611 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 127 хэрэг буюу 26.2 хувиар өссөн үзүүлэлттэй, улсын хэмжээнд бүртгэгдсэн 22506 хэргийн 2.7 хувийг эзэлж хэргийн илрүүлэлт 53.1 хувьтай байна.


Бүртгэгдсэн 611 хэргийн 559 буюу 91.5 хувь нь орон нутагт, 52 буюу 8.5 хувь нь нийслэлд бүртгэгдсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад орон нутагт бүртгэгдсэн хэрэг 112 буюу 25.1 хувиар, нийслэлд бүртгэгдсэн хэрэг 15 буюу 40.5 хувиар тус тус өссөн.

Гэмт хэргийн ангиллаар хэргийн өсөлт, бууралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэрэг 465 байснаас 587 болж 122 хэргээр буюу 26.2 хувиар, хүнд гэмт хэрэг 19 байснаас 24 болж 5 хэргээр буюу 26.3 хувиар буурсан байна.

График №1

⁸² Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд. Сургалтын гарын авлага. УБ.2019. 127 дахь тал

⁸³ Б.Чимэд. Хууль хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалт, түүний үндсэн хэлбэр //Социалист хууль ёс. 1979. №3. 28 дахь тал



Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бүртгэгдсэн зүйлээр нь авч үзвэл, 250 буюу 40.9 хувийг хууль бусаар мод бэлтгэх, 229 буюу 37.5 хувийг хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, 81 буюу 13.3 хувийг хууль бусаар ан агнах, 29 буюу 4.7 хувийг байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх, 17 буюу 2.8 хувийг химийн хорт аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах, 3 буюу 0.5 хувийг байгаль орчныг бохирдуулах, 2 буюу 0.3 хувийг ой хээрийн түймэр тавих гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал”-ийн 1.8.6.8 дахь хэсэгт цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчлийг шалгах эрхтэй талаар заасан бөгөөд энэ оны эхний 11 сард Зөрчлийн тухай хуулийн 7.15.8 дахь хэсгээр улсын хэмжээнд 128 зөрчил бүртгэгдсэн байна.⁸⁴

Дээрхи статистик тоо мэдээнээс үзвэл 2020 онд хөнгөн гэмт хэрэг 26.2 хувиар өссөн бол хүнд гэмт хэрэг 26.3 хувиар буурсан байна. Гэмт хэргүүдийн дийлэнхи хэсэг буюу 78.4 хувийг хууль бусаар мод бэлтгэх, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргүүд анхаарал татаж байна.

Экологийн цагдаагийн албанаас 2020 онд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр Байгаль орчин, аялал жуулчлалын, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн яам, Нийслэлийн байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Туул голын сав газрын захиргаатай 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө, Монголын байгаль орчны иргэний зөвлөл, Лондонгийн амьтан судлалын нийгэмлэгийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Монголын бичил уурхайн нэгдсэн “Дээвэр” холбоотой хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан, хэрэгжилтийг ханган ажиллажээ.

Иргэн бүрт байгаль дэлхийгээ шүтэн хамгаалж, байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн үндэсний өв уламжлалаа шинжлэх ухаан, инновац, технологийн ололтод тулгуурлан, тогтвортой хөгжлийн төлөөх үзэл баримтлалаар баяжуулан бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх шинэ үеийн нэгдмэл үзэл, төлөвшил, байгаль хамгаалах зөв дадал хандлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх “Байгаль эн тэргүүнд” төслийг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Дээрх төслийн хүрээнд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, аж, ахуйн нэгж байгууллагуудтай хамтран 8 нөлөөллийн аян, арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулсныг тоймлон авч үзвэл:

⁸⁴ Экологийн цагдаагийн албаны 2020 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

- “Ногоон дуу хоолой” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд 8007 иргэн, хуулийн этгээдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө өгч, ажилласан;

- “Загас хамгаалал-2020” нэгдсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулсан

- Иргэд, олон нийтэд хог хаягдлын талаар мэдээлэл өгөх, хөрс, усны бохирдлын эх үүсвэрийг бууруулах чиглэлээр энэ оны 06 дугаар сард “Хогоор бүү хорло” нөлөөллийн аяныг зохион байгуулж, аяны хүрээнд энгийн, аюултай, барилгын болон уул уурхайн хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах уралдаан 3, аж ахуйн нэгж байгууллагын сайн туршлагыг сурталчлах зорилтод арга хэмжээг тус тус зохион байгуулж, химийн хортой бодис агуулдаг ахуйн хэрэглээний хог хаягдал хүлээн авах 43 цэгүүдийг байгуулсан

- Аялал жуулчлалаас үүдэлтэй хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр энэ оны 07 дугаар сард “Ирлээ, Явлаа, Цэвэр” нөлөөллийн аяныг зохион байгуулж, аяны хүрээнд орон нутагт амрагч, аялагч нарт хариуцлагатай аяллын 10 дүрмийг сурталчлах ажлыг 12 удаа зохион байгуулж, автомашины наалт, тараах материал тус бүр 60.0, хогийн уут, тор 120.0, халаасны тамхины хогийн сав 15.0 ширхгийг тус тус тарааж, зөөврийн 40 ширхэг хогийн савыг шалган нэвтрүүлэх товчоодод байршуулсан.

- Байгаль орчныг хамгаалах тухай багц хуулийн хэрэгжилтийг хангах, байгалийн нөөц баялаг, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, эзэмшихтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх зорилгоор “Цэнхэр алт усаа хайрлая”, “Ой модоо хайрлая” нөлөөллийн аяныг энэ оны 09-10 саруудад тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд “Эх дэлхийдээ хүчилтөрөгч бэлэглэе” уриа дор “Ой модоо хайрлая” өдөрлөгийг зохион байгуулж Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Реалтор төгөл болон Баянзүрх хайрхны ар хормойд 1800 бүйлс, шинэс модыг тарьж, хуурай газрын экосистем, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан.

- Ойн нөөцийн хомсдол, усны бохирдлын эх үүсвэр түүний учир шалтгааныг иргэд олон нийтэд таниулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, буруу дадал хандлагыг өөрчлөх, зөв соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Norphei Art Gallery”, “Улаанбаатар” аялагч клуб, “I berry brand”-тэй хамтран “Ус ба мод” харьцуулсан фото зургийн үзэсгэлэн, нийслэлийн авто угаалгын газруудтай хамтран “Усаа хэмнэж, саарал ус ашиглах”, мөн “Эх дэлхийн цэнгэг усаа гамная” арга хэмжээнүүдийг зохион байгуулсан;

- Монгол оронд ховордож буй зэрлэг амьтдын төрөл, зүйлийг иргэд, олон нийтэд таниулах, хайрлан хамгаалах, байгаль орчинд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгох, байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актуудыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “Амьтдаа хайрлая”, агаар орчны бохирдлыг бууруулах, түүний хор аюулыг багасгах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Агаар орчны бохирдлын бууруулъя” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулан ажиллажээ.

Дээрх нөлөөллийн аян, арга хэмжээний хүрээнд иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр Байгаль, зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг “Хүрээлэн” төслийн багтай хамтран “Шонхор эко” нэвтрүүлгийн 2, Эко телевизтэй хамтран “Эко сэргийлэгч” нэвтрүүлгийн 10 дугаарыг тус тус бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэж, телевиз, радиогийн эфирээр 209 удаа /627 минут/, өдөр тутмын сонин, сайтад 262 удаагийн ярилцлага, мэдээ нийтлүүлж, үүрэн телефоны хэрэглэгчдэд давхардсан тоогоор 32 сая зорилтод мессеж илгээсэн байна.⁸⁵

Экологийн цагдаагийн албанаас зохион байгуулсан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалтын хэлбэрийг авч үзвэл:

⁸⁵ Экологийн цагдаагийн албаны 2021 оны эхний 8 сарын үйл ажиллагааны нэгдсэн тайлангаас хэсэгчилэн авав.

- хүрээлэн байгаа орчны эсрэг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалтыг явуулж, иргэд, олон нийтэд зөвлөлгөө өгөх;
- аж ахуйн нэгж байгууллагатай хамтран хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр уралдаан зохион байгуулах;
- хүрээлэн байгаа орчны эсрэг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил гаргахад ашигласан техник хэрэгсэл, эд зүйлийг хураан авч улсын орлого болгох;
- хүрээлэн байгаа орчны эсрэг тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх;
- хууль тогтоомж, дүрэм, журам сурталчлах ажлыг зохион байгуулах, автомашины наалт, тараах материал, хогийн уут, тор, халаасны тамхины хогийн сав тараах, байршуулах;
- төрийн байгууллагуудтай хамтран машин, морьт болон завьт, явган эргүүл ажиллуулах;
- олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нөлөөллийн аян, арга хэмжээ зохион байгуулж сурталчилах;
- алба хаагчид өөрсдөө манлайлан оролцож, тодорхой ажил хийх;
- үйл ажиллагаа сурталчлах, урьдчилан сэргийлэх чиглэлээр фото үзэсгэлэн гаргах;
- уул уурхайн болон хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл шаардлага өгч, түүнийхээ биелэлтийг хянан шалгах;
- телевиз, FM радио болон фэсбүүк цахим сайтуудаар дамжуулан иргэдэд зөвлөлгөө өгөх, үйл ажиллагаагаа олон нийтэд тайлбарлан таниулах зэрэг хэлбэрээр явагдаж ирсэн байна.

2021 оны эхний 8-н сард 362 бүртгэгдсэн Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зүйлээр нь авч үзвэл:

- Хууль бусаар мод бэлтгэх 180 буюу 49.7%-ийг
- Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох 40 буюу 11%-ийг
- Хууль бусаар ан агнах 13 буюу 3.6%-ийг
- Хууль бусаар байгалийн ургамлыг бэлтгэх 9 буюу 2.5%-ийг
- Бусад төрлийн гэмт хэрэг 3 буюу 0.9 %-ийг эзлэж байна.⁸⁶

Эндээс үзвэл хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг дийлэнхи хувийг эзэлж байгаад бид анхаарлаа хандуулж иргэдийн мэдээлэл өгөх ухамсарыг төлөвшүүлэх чиглэлээр илүү ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харж болохоор байна.

Экологийн цагдаагийн албанаас хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон ажил, арга хэмжээ явуулж байгаа боловч энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил хүссэн хэмжээнд хүртэл буурахгүй байгаа нь урьдчилан сэргийлэх ажлынхаа арга барилыг сайжруулах шаардлага байна гэж үзэхэд хүргэж байна.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гарч болох нөхцөл байдлуудыг арилгахад чиглэсэн арга хэмжээг иж бүрэн, цогцоор нь зохион байгуулж байх нь хамгийн чухал, нэн тодорхой ажил юм.⁸⁷

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын шинжлэх ухааны үндэстэй явуулах үндсэн нөхцөл, арга зүй бол судалгаа юм. Энэ төрлийн гэмт хэргийг урьдчилан судлахдаа тэдгээрийг задлан шинжилж, урьдчилан сэргийлэх чиглүүдээ гаргана.

⁸⁶ <https://www.facebook.com/CrimePreventionMongolia/> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

⁸⁷ Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд. Сургалтын гарын авлага. УБ.2019. 124 дэх тал

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн задлан шинжилгээгээр дор дурдсан үзүүлэлтийг тогтоох хэрэгтэй. Тухайлбал:

1. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн гаралтын байдал, түүний хөдөлгөөн, бүтэц, өөрчлөлт, шалтгаан, ялангуяа аюултай буюу түгээмэл дэлгэрсэн гэмт хэргийн байдал, хөдөлгөөн;

2. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлийн тархалтыг нутаг дэвсгэр, хүн амын суурьшил, үйлдвэржилт зэрэг хүчин зүйлийг үндэслэнхийсэн харьцуулалт;

3. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн хор аюулын шинж, хор хөнөөл;

4. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт үйлдэл бүрийн зоорилго, сэдэлийг тодорхойлсон үнэлэлт зэрэг болно.

Экологийн цагдаагийн алба нь хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлмээр байна. Үүнд:

- Гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудыг оролцуулсан хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаар нэгдсэн мэдээллийн сантай болж, мэдээллийн шуурхай байдлыг хангах;
- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гадаад орнуудад хэрэгжүүлсэн үр дүнтэй туршлагаудыг судалж, нэвтрүүлэх ажлыг бодлогын түвшинд хэрэгжүүлэх;
- Экологийн цагдаагийн албаны дор хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглагдах зарим төрлийн шинжилгээ хийх лабораторийг байгуулах зэрэг болно.

Төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллахаас гадна, цагдаагийн байгууллага дотроо албадын хамтын ажиллагааг зохион байгуулах нь нэгдмэл байдлыг хангах, хүч бололцоогоо зөв хуваарилах, мэдээллийг шуурхай дамжуулах, гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох зэрэг олон талын ач холбогдолтой.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн байгууллагууд хоорондын хамтын ажиллагаанаас гадна, иргэдийн оролцоог хангах, түүнийг нэмэгдүүлэх нь өнөө үеийн чухал шаардлагын нэг болоод байна.

Иргэдийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн ажилд татан оролцуулах нь хамтын ажиллагааны хамгийн идэвхитэй хэлбэр юм.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаанд иргэний оролцооны анхдагч элемент нь тэднийг мэдээллээр хангах явдал юм. Иргэд аливаа асуудлаар мэдээлэлтэй болсон тохиолдолд оролцох боломж нээгдэж, оролцооны үндэс суурь тавигдана.

Мэдээллийг олон нийтэд ил байлгах үүргийг хуулиар даалгасан боловч хэн, ямар мэдээллийг хэзээ, ямар арга замаар нийтэд хүргэх талаар тодорхой механизмыг заалгах “нийтэд мэдээлнэ”, “нийтэд ил байлгана”, “мэдээллээр хангах” гэх мэт тунхагийн шинжтэй, хариуцах эзэнгүй орхигдуулснаас гадна, нийтэд мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэхийг тусгалгүй орхижээ.⁸⁸

Завхан аймгийн цагдаагийн газраас хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, энэ төрлийн мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор “Байгалиа хамгаалъя” аяныг “Таны дуу хоолой байгалийг хамгаалж чадна” уриан дор зохион байгуулсан, мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сум хариуцсан хэсгийн төлөөлөгч, цагдаа нар, багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж тухайн суманд амьдардаг айл өрхүүдээр биечлэн явж ой хээрийн, түймэр гаргахгүй байх талаарх

⁸⁸ Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд. Сургалтын гарын авлага. УБ.2019. 133 дахь тал

“Баталгаа” гаргуулан өрхийн тэргүүнээр гарын үсэг зуруулан хамтран ажилласан⁸⁹ нь бусад нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагуудын нэвтрүүлбэл зохих туршлага гэж үзэж байна.

Дүгнэлт

Байгаль орчныг хамгаалах тур дундаа ургамал, амьтныг хууль бус ан агнуур, худалдааг бууруулах, таслан зогсооход мэргэжлийн хүмүүсийн хичээл зүтгэлээс гадна олон нийтийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах шаардлагатай болсон байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сурталчилгаа явуулж байгаа нь тодорхой үр дүнд хүрч байгаа боловч хөдөө орон нутагт мэдээллийн хүртээмж хэр байгаа талаар тодорхой хийсэн судалгаа болон үр дүнг тооцон судалгаа өнөөг хүртэл хийгдээгүй байгаа нь асуудал болжээ.

Санал. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөдөө, орон нутагт Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээ, мэдээллийг хүртээмж ямар түвшинд байгаа талаар бичил судалгаа хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх.
2. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн дэмжлэг туслалцааны ач холбогдлыг сурталчилах ажлыг хөдөө, орон нутагт биет байдлаар зохион байгуулж, өрх бүрт хүрч ажиллан мэдээллэх үүргийн баталгаа авч ажиллах;
3. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн талаархи мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлээгүй иргэн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид тусгаж өгөх

Ном зүй

1. Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх: хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд анхаарах асуудлууд. Сургалтын гарын авлага. УБ.2019
2. Б.Чимэд. Хууль хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааны зохицуулалт, түүний үндсэн хэлбэр //Социалист хууль ёс. 1979. №3
3. <http://www.arslan.mn/58026/sitem>
4. <https://www.facebook.com/CrimePreventionMongolia>
5. <https://montsame.mn/mn/read/225491>.
6. Экологийн цагдаагийн албаны 2020 он болон 2021 оны эхний 8 сарын тайлан.

⁸⁹ <https://montsame.mn/mn/read/225491>.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МОНГОЛ ОРНЫ ОЙ, ОЙГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

А.Баасанцэрэн
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Монгол орны ойн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, ойг хамгаалах талаарх эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн хөгжлийг судалж, дүгнэлт боловсруулсан.

Түлхүүр үг: Байгаль орчин, ой мод, газар нутаг, ойн түймэр, ховор ургамал.

Өнөөгийн нөхцөл байдал

Хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлтөд хүний үйл ажиллагаа ихээхэн нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн экологийн систем эрчимтэй өөрчлөгдөж, хүн амын амь нас, эрүүл мэндэд бодит аюул занал учирч байна. Дэлхийн 87 сая км.кв ойн талбайгаас сүүлийн 12 жилд 1.5 сая нь устжээ. Энэ байдлыг өөрчлөгдөхгүй бол 700 жилийн дараа дэлхий нэг ч модгүй болох аж. Хүн төрөлхтөн ой модоо устгасаар байгаа цагт түүнээс үүдэх хор уршгийг нь амссаар байх билээ.

Өнөөдөр манай улсад Ойн тухай хуулиар орон нутгийн бүтцийг бий болгосон. Өөрөөр хэлбэл орон нутагт үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд удирдах ойн ангиудыг бий болгосон. Нөгөө талаараа хувийн хэвшлийн байгууллагууд яамнаас эрх аваад төсвийн хөрөнгөөр ойг хамгаалах, ойг цэвэрлэх, ойжуулах эрх бүхий мэргэжлийн байгууллагууд бий болсон. Мөн сүүлийн 10 жилд нөхөрлөлүүдийг олноор байгуулсан. Өөрөөр хэлбэл, малчид малаа, ойгоо хамгаалж ашиг хүртэх эрх зүйн орчин бүрдсэн. Энэ бол маш том менежмент. Нийт ойн 3%-ийг нөхөрлөлүүд хамгаалж байгаа бөгөөд цаашид энэ тоог 20% хүртэл нэмэгдүүлэх зорилготой байна. Энэ утгаараа манай улсын Байгаль орчны яам НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран төслийн бичиг баримтад гарын үсэг зурсан бөгөөд олон улсын байгууллагын санхүүжилтээр 100 нөхөрлөлийг дэмжих 3.5 сая долларын төсөл хэрэгжинэ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн талбай нь 1.566.114 км², үүнээс ойн сангийн талбай 14.2 сая га бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 11.2%-ийг эзэлж байна.

Монгол орны ойг нөхцөлт байдлаар хоёр хэсэгт хувааж болно. Хойд хэсэг нь Оросын Холбооны Улсын хилээс (Сибирь, Алтайн хязгаар, Тува, Эрхүү муж, Буриад, Байгалийн хязгаар) хиллэдэг 11.1 сая га талбайд ихэвчлэн шилмүүст мод (нарс, гацуур, хуш, шинэс, гацуур), навчит мод (хус, улиас), бут сөөг нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 7.6% -ийг эзэлдэг. Монгол орны өмнөд хэсэгт заган (3.1 сая га, газар нутгийн 3.6%), ихэнх хэсэгт бут сөөг ургадаг. Тиймээс НҮБ-ын Хөдөө аж ахуйн байгууллагаас 2011 онд Монгол Улс хамгийн бага ойтой улсаар хүлээн зөвшөөрсөн.

Цаашид арилжааны зорилгоор ой модыг хууль бусаар огтолж ихэвчлэн Улаанбаатар хоттой ойр оршдог Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгаас хамгийн үнэ цэнэтэй зүйл болох нарс, гацуур, хуш модыг хууль бусаар огтолж байна. Орчин үеийн "модны хулгайчид" мэргэжлийн түвшинд ажилладаг туулах чадвар сайтай машин ашигладаг, сүлжээ сайтай утсан холбоо байна.

Үндсэндээ тэд мод огтлох ажлыг зохион байгуулах, зарах, ашиг хуваарилах чиглэлээр ажилладаг. Үнэндээ бүх хууль зөрчигчид хууль сахиулагчид, төрийн албан хаагчидтай авлигын холбоотой байдаг. Тиймээс, байгалийн баялгийг хууль бусаар ашиглахыг гэмт хэргийн бизнесийн нэг хэлбэр болсон тул цаашид үр дүнтэй тэмцэхийн тулд судлах шаардлагатай тулгарч байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол Улсад 4000 га ой устгагдсан бөгөөд алдагдал 1.16 их наяд төгрөг болжээ. Байгаль орчны, түүний дотор ойн тухай хууль тогтоомж зөрчихтэй холбоотой гэмт хэрэг жил бүр мэдэгдэхүйц нэмэгдэж байгаа нь байдлыг улам хүндрүүлж байна. Гэмт хэргийн бүтцэд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг давамгайлж байна. Мөн ойг хууль бусаар ашиглахтай холбоотой захиргааны зөрчлийг жилд 4 мянга гаруй бүртгэдэг.

Иймд одоогийн байгаль орчин, ойн тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд төрөөс зохих хариу арга хэмжээ авах шаардлагатай байна. Мөн авч үзэж буй сэдвийн хамаарал нь ой, ургамлыг устгах нь нийгмийн аюул нэмэгдсэнтэй холбоотой сүүлийн жилүүдэд онцгой анхаарал татсан гэмт хэргүүдийн нэг болох нь тодорхойлогдоно. Эдгээр гэмт хэргийн аюулыг нэг буюу өөр төрлийн хохирлын үүднээс биш харин нийгэм-эдийн засгийн үнэ цэнэ бүхий байр суурийн дагуу нарийн төвөгтэй үзүүлэлт гэж тодорхойлсон байх ёстой.

Ойг хамгаалах талаарх Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал

Олон зууны турш нүүдэлчин ахуйгаар амьдарч ирсэн Монголын ард түмний амьдрал хүрээлэн буй орчноос шууд хамааралтай байсан. Байгаль нь хүмүүсийн амьдралд идэвхтэй нөлөөлдөг тул газар нутаг, ой мод, усаа хайрлан хамгаалах, байгалиа шүтэх ёс заншлыг зөвхөн шашны зан үйл төдийгүй төр, ард түмэний ёс уламжлал юм.

Эртний Монголын Хүннү улс МЭӨ 3 дугаар зуунд нийгмийн харилцааг зохицуулсан хууль дүрмийг тогтоожээ. Улс гэдэг бол эх орон газар нутаг гэсэн ойлголт юм.⁹⁰

Байгаль орчныг хамгаалах монгол уламжлал өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн бөгөөд уламжлалт соёлын хэм хэмжээтэй шууд холбоотой. 800 жилийн өмнө Чингис хаан дэлхийд анх удаа Бурхан Халдун уулыг дархалсан. Богд хаан 300 жилийн өмнө Богдхан уулыг дархан цаазат уул болгож Отгонтэнгэр уул, Алтан овоо зэрэг уулсыг төрийн тахилгат болгосон нь одоо болтол хадгалагдаж ирсэн байна.⁹¹

Чингис хааны 1206 онд анхны бичигдмэл болох Их засаг хуульд нийгмийн болон иргэний харьцаа, гэмт хэрэгтэй тэмцэх хэм хэмжээ, байгаль орчныг хамгаалахтай холбоотой асуудлуудыг зохицуулсан байдаг. Тэд соёл, эдийн засаг, шашны үзэл бодлыг (бөө мөргөл дээр үндэслэсэн) тодорхойлсон. Их засаг хуульд газар, хөрс, цэвэр ус, модыг ашиглах, гал түймрээс хамгаалах зэргийг хуулчилж хатуу шийтгэл оногдуулахыг тогтоожээ.⁹²

Юан гүрний хууль (1260) нь нийгэм, улс төр, эдийн засгийн амьдралыг авч үзсэн бөгөөд уламжлал, зан заншилд үндэслэсэн хууль эрх зүйн заалтууд, үүнд хүрээлэн буй орчныг хамгаалах заалтуудыг багтаасан болно.⁹³

1507 оны Алтан хаан (Алтан хаан) хууль нь XVI зуунд батлагдсан томоохон хуулиудын нэг бөгөөд 12 хэсэг, 117 зүйлээс бүрддэг. Жишээлбэл, 95 дугаар зүйлд их хэмжээний мод бэлтгэсэн, хулгай хийсэн тохиолдолд 2 есөн торгууль ногдуулна гэж заасан байдаг.

1640 онд Халх ойрадын ноёдын хурлаар баталсан Монгол-Ойрадуудын хууль нь 186 зүйлээс бүрдэж, ойн түймэр тавьсан тохиолдолд 5 тэмээгээр торгох, мод огтлох, гэмтээсэн

⁹⁰ Э.Авирмэд. Д.Дашцэдэн. С. Совд. Монгол хууль. УБ., 1997. 5 дахь тал

⁹¹ О.Амархүү. Монголчуудын байгалийн орчныг хамгаалах ёс заншил, хууль зүй. УБ., 2000. 11 дэх тал

⁹² Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Төр эрх зүйн түүхэн хөгжил. УБ., 1997. 71 дэх тал

⁹³ О.Амархүү. Монголын экологи. УБ 2004. 68 дахь тал

тохиолдолд шийтгэл оноов зэрэг байгаль орчныг хамгаалах гурван төрлийн гэмт хэрэгт шийтгэл оногдуулж байжээ. Үүнд:

- Тогтоосон хэм хэмжээг зөрчиж газар ашигласан;
- Ойн түймэр;
- Хууль бусаар ан агнах, ховор ургамлыг устгах, мод огтлох.

Нүүдэлчин монголчуудын хувьд ой, бэлчээрийг хамгаалах, зүй зохистой ашиглах асуудал эртний түүхтэй. Ой, бэлчээр шатаж, олон тооны модыг хууль бусаар огтолж, гэмтээсэн, ялангуяа эдгээр хэргүүд өөр хүний амь нас хохирсон, гэмтсэн бол маш хатуу шийтгэдэг.⁹⁴

1709 оны Халхын хуульд байгаль орчны тулгамдсан асуудал, хууль дээдлэх ёсыг хангах, уламжлал ёсыг сахих, ан амьтан, усаа хамгаалах, ойн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой газар хуваарилсан. Тухайлбал, модыг хууль бусаар огтолсон хүнд оногдуулах шийтгэлийн тухай 126, Сэлэнгэ, Орхоны дархан цаазат газарт ан агнах, амьтан агнахыг хориглох тухай 127 дугаар зүйл, ой хээрийн гал түймэртэй тэмцэх тухай 176-179 дүгээр зүйлд зэрэглэлээс нь хамааруулан ял шийтгэл оноохоор заасан.

1915 оны Богд хаант Монгол Улсын цаазын бичигт хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг илүү өргөн хүрээнд зохицуулж, байгалийн нөөц, түүний дотор ашигт малтмал (алт, мөнгө, хар тугалга, байгалийн ашигт малтмал), тухайлбал, элсийг хамгаалах, ашиглах төрийн харьяаллыг тогтоожээ. Газар ашиглах, нөөцийн тусгай хамгаалалтын талаар дурдсан.⁹⁵

1924 оны БНМАУ-ын анхны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд газар, уурхай, ой, усны нөөцийг зөвхөн төрийн өмчлөлөөр тогтоожээ. Улсын анхдугаар хуралдаанаар дотоодын ойн нөөцийг хамгаалах шийдвэр гаргасан. 1925 онд батлагдсан анхны "Ойн дүрэм" нь ойг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

1926 оны Шүүх цаазын бичигт (анхны Эрүүгийн хууль). 15 дугаар бүлэгт 103 дугаар зүйлд байгалийн нөөцийг ашиглах журам зөрчсөн бол 3 сар хүртэл хугацаагаар баривчлах, 110 дугаар зүйлд ногоон мод огтолсон бол 6 сар баривчлах буюу 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.⁹⁶

Ойн тухай хуулийг 1931 онд баталж, 1933, 1934 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, 1940 онд шинэчлэн найруулжээ. Энэ хугацаанд модон эдлэлийн үйлдвэр бий болж, бүтээгдэхүүнийг нь барилгын ажилд өргөн ашиглаж, БНМАУ-ын Хөдөө аж ахуйн яамны бүтэц өөрчлөгдөж Ойн газрыг байгуулсан. Байгалийн нөөцийг хамгаалах чиглэлээр нийслэлийн ой, ан амьтны газраас ойн ангиудыг зохион байгуулав. 1933 оноос хойш тусгай зөвшөөрөлтэйгээр мод огтлох ажлыг зөвхөн 11 дүгээр сарын 1-ээс 4 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хийж болно.

БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуульд байгаль орчны эсрэг гэмт хэргийг тусад нь бүлэг болгон тус тусад нь тусгаарласан. Тодруулбал, 190 дүгээр зүйлийн шийтгэлд ойг галдан шатаасан тохиолдолд 2 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэхээр заасан байв.

БНМАУ-ын 1961 оны Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлд хууль бусаар мод тайрсан, сүйтгэсэн, гэмтээсэн гэм хорлосон гэсэн үндэслэлээр 1 жил хорих ял шийтгэнэ; 190 дүгээр зүйлд ой шатаасан бол 100-600 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах.

1974 онд баталсан БНМАУ-ын Ойн тухай хуулиар байгалийн баялгийг ашиглах, хадгалах, ашигласны татвар, төлбөр хураах асуудлыг зохицуулсан. Монгол Улсын Сайд нарын Зөвлөлийн 1974 оны 556 дугаар тогтоолоор ойг зөв ашиглах зөвшөөрлийг шинээр олгох зөвшөөрлийг батлав. Энэ нь ойг хамгаалах, нөхөн сэргээхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн.

⁹⁴ О.Амархүү. Монголчуудын байгалийн орчныг хамгаалах ёс заншил, хууль зүй. УБ., 2000. 41 дэх тал

⁹⁵ О.Амархүү. Монголчуудын байгалийн орчныг хамгаалах ёс заншил, хууль зүй УБ., 2000. 49 дэх тал

⁹⁶ Д.Адъяабазар. 1921 оноос хойш эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. УБ., 1998. 22 дахь тал

1986 оны Эрүүгийн хуульд 7 дугаар бүлэгт хүрээлэн буй орчин, түүний дотор ус, газар, газрын хэвлий, агаарын орон зайг гэмт халдлагаас хамгаалах, Эрүүгийн хуулийн шинэ төрлийн хамгаалалт нэмэгдэж байна.⁹⁷

Одоогийн байдлаар ойг хамгаалах эрх зүйн үндсийг 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хууль, 2012 оны Ойн тухай хуулиар тус тус бүрдүүлсэн.

Монгол Улсын 2002 оны Эрүүгийн хуулийн 211 дүгээр зүйлд Ойн хууль тогтоомж зөрчих нь зохих лицензгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар зөвшөөрөлгүй мод огтлох, худалдан авах, худалдах, ачих, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулахад хязгаарлалт, тусгай бүс, хэрэв ийм үйлдэл нь ихээхэн хор хохирол учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

2015 оны Эрүүгийн хуульд байгаль орчныг хамгаалах, тэр тусмаа ой хамгаалах талаар нэлээд дэлгэрэнгүй тусгаж өгсөн. Энэ хуулийн 24.6, 24.7, 24.8 дугаар зүйлд Хууль бусаар мод бэлтгэх, Ой, хээрийн түймэр тавих, Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэргийг тусгайлан зааж өгсөн.

Дүгнэлт

Ойг хамгаалах асуудал нь эдийн засаг, Монгол Улсын хөгжилд чухал ач холбогдолтой болохыг харуулж, Монгол Улсын ойн санг эрүүгийн эрх зүйн хамгааллын тулгамдсан асуудал болохыг нотолж байна.

Ном зүй

- Э.Авирмэд, Д.Дашцэдэн, С. Совд. Монгол хууль. УБ., 1997
- О.Амархүү. Монголчуудын байгалийн орчныг хамгаалах ёс заншил, хууль зүй. УБ., 2000
- Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Төр, эрх зүйн түүхэн хөгжил. УБ., 1997
- О.Амархүү. Монголын экологи. УБ., 2004
- О.Амархүү. Монголчуудын байгалийн орчныг хамгаалах ёс заншил, хууль зүй. УБ., 2000
- Д.Адъяабазар. 1921 оноос хойш эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. УБ., 1998

⁹⁷ Д.Адъяабазар. 1921 оноос хойш эрүүгийн хууль тогтоомжын хөгжил. УБ., 1998. 184 дэх тал

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЭРҮҮГИЙН ПРОЦЕСС ДАХЬ МӨРДӨН БАЙЦААЛТ: АНХААРАХ АСУУДАЛ

Н.Манлайбаатар

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Мөрдөн байцаалт нь шүүхийн өмнөх бие даасан үе шат болохын хувьд түүний зорилго, агуулга, мөн чанарыг таних нь эрх зүйн философийн хувьд нэлээд анхаарал хандуулах ёстой судлагдахуун. Бид мөрдөн байцаалтыг тогтсон уламжлалт хандлага хийгээд батлагдснаас хойшхи хугацаанд⁹⁹ түүний хувьсан өөрчлөгдөх, шинэчлэлийн агуулгаар баяжих, хүний эрх суурьтай хөгжих, дэлхий нийтийн эрх зүйн соёл, чиг хандлага, Монгол Улсын Олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, дэлхийн хөгжингүй орнуудын ололтыг нутагшуулах зэргээр ерөнхий нийтлэг зүй тогтолын дагуу боловсронгуй болж ирсэн. Гэвч хууль зүйн техникийн хувьд нэр томьёо, хэллэг, хэвшсэн үгсийнхээ агуулгыг судлах нь нэлээд учир холбогдолтой болох нь сүүлийн жилүүдэд анхаарал татаж буй.

Түлхүүр үг: Эрүүгийн процесс, мөрдөн байцаалт, мөрдөн мөшгөх, байцаалт

Монгол Улсын Эрүүгийн процессын эрх зүйн үе шат болох мөрдөн байцаалт нь эрх зүйн онол, философийн агуулга хийгээд соёл иргэншлийн түүхийн олон талт сэжим, шүтэлцээнд тайлбарлагдах, ойлгогдох нь зүйн ёсны боловч Монгол Улсын Үндсэн хууль⁹⁸ батлагдснаас хойшхи хугацаанд⁹⁹ түүний хувьсан өөрчлөгдөх, шинэчлэлийн агуулгаар баяжих, хүний эрх суурьтай хөгжих, дэлхий нийтийн эрх зүйн соёл, чиг хандлага, Монгол Улсын Олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, дэлхийн хөгжингүй орнуудын ололтыг нутагшуулах зэргээр ерөнхий нийтлэг зүй тогтолын дагуу боловсронгуй болж ирсэн. Гэвч хууль зүйн техникийн хувьд нэр томьёо, хэллэг, хэвшсэн үгсийнхээ агуулгыг судлах нь нэлээд учир холбогдолтой болох нь сүүлийн жилүүдэд анхаарал татаж буй.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹⁰⁰-д заасан үндэслэл, журмын дагуу ердийн болон тусгай /мөрдөн шалгах нууц/ ажиллагааны хүрээнд түүнчлэн Гүйцэтгэх ажлын тухай хууль¹⁰¹-д заасан үндэслэл, журмын дагуу нотолгоо цуглуулах, гэмт хэрэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулна. Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын баримт бичиг юм. Тийм ч учраас гэмт хэрэгтэй тэмцэх ялангуяа төрийн эрх бүхий байгууллагууд хуульд заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, хуулиар харьяалуулсан гэмт хэргийг мөрдөх, мөшгөх ажиллагааг явуулж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь эрүүгийн процессын эрх зүйн бие даасан үе шат болохын хувьд, өөрийн зорилго, агуулга, мөн чанартай. Өөрөөр хэлбэл шүүн таслах ажиллагаа

⁹⁸ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. УБ., 1992 он. №1.

⁹⁹ Эрх зүйн шинэчлэлтийн сүүлийн 30 орчим жилийн хугацаанд нэлээд хэдэн онол, философи, зарчим, үзэл баримтлал зэргээр зайлшгүй авч үзэж, тодорхой ахиц гарсан нь зүй хэрэг хэмээн үздэг.

¹⁰⁰ <https://legalinfo.mn/law/details/12694?lawid=12694> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль үзнэ үү. ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.36-д дахь заалтанд: “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг;

¹⁰¹ <https://legalinfo.mn/law/details/229?lawid=229> үзнэ үү. ГАТХ-ийн 2 дугаар зүйлд: “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ” гэж тодорхойлсон.

гагцхүү хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтын хүрээнд явагдаж, яллах, цагаатгах шийдвэрийн аль нэгийг гаргадаг. Энэ нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хэргийн бодит байдлыг тогтооход чиглэсэн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнгээс хамаарна. Тэгэхлээр, мөрдөн байцаалт нь шүүх эрх мэдлийн тогтолцооны нийгэмд шударга ёсыг тогтоох, эрх зүйт төрийн мөн чанар, агуулгын шууд илрэл нь юм.

Хэдийгээр гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо нь Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтны хуулиар хүлээсэн үүрэг боловч, төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэж¹⁰² байдгийг анхаарах нь зүйтэй. Мөрдөн байцаалтын ажиллагаа нь бусад салбар эрх зүйн мэдлэгийн тогтолцоотой хамааралтай болохыг энд цухас тэмдэглэлээ.

Бид агуулгаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13-т "...Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн ...мөрдөн мөшгих¹⁰³, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно¹⁰⁴...", мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-т "...мөрдөн байцаах¹⁰⁵,... ажиллагаанд хяналт тавина¹⁰⁶..." гэсэн эх сурвалжийг тус тус үндэслэл болговол аливаа хэргийг мөрөөр нь нотлох, гэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу, прокурорын хяналтанд мөрдөн байцаалтыг /эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа/ явуулах эрх зүйн үндэс бүрдсэн байдгаас авч үзнэ.

Мөрдөн байцаалт /*англи*: preliminary investigation, pretrial investigation, *орос*: предварительное следствие, *герман*: vorläufige Untersuchung¹⁰⁷/ нь эрүүгийн процессын эрх зүйн шүүхийн өмнөх үе шат болохын хувьд түүний агуулга, мөн чанар, зорилт нь өөрийн гэсэн онцлогтой. Тэрхүү онцлог нь дараах агуулгаар тайлбарлагдаж ирснийг хууль зүйн эрдэмтэд тэмдэглэснийг авч үзье.

Академич С.Нарангэрэлийн тэмдэглэснээр "...гэмт хэрэг үйлдсэн үйл явдал, түүнийг үйлдсэн гэм буруутай этгээд байгаа эсэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын шинж чанар ба хэмжээ, хэрэгт ач холбогдол бүхий бусад нөхцөл байдлыг тогтоохын тулд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ба шинжлэх талаарх хэрэг бүртгэх ба мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаанаас бүрддэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат¹⁰⁸...", Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ж.Авхиа агсны тэмдэглэснээр "...Урьдчилсан мөрдөн байцаалтын зорилт нь эрүүгийн хэрэгт шаардлагатай бүх нотлох баримтуудыг бүрэн гүйцэд цуглуулж шалгах, хэрэгт ач холбогдол бүхий яллах, цагаатгах, хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх, бүх нөхцөл байдлуудыг тогтоох, түүнчлэн уг гэмт хэрэг

¹⁰² Улсын Их Хурлаас 2019 оны дугаар 06 сарын 06-ны өдөр баталсан, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-иар ийнхүү тодорхойлжээ.

¹⁰³ <https://mongoltoli.mn/dictionary/detail/58641> цахим их тайлбар тольд болон бусад тайлбар тольд Үндсэн хуульд хэрэглэсэн "мөшгих" гэдэг үгийг "МӨШГӨХ" гэж бичдэг. Гэвч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл. Хүний халдашгүй байх эрхийг хангах. 1. ...заасан үндэслэл, журмаас гадуур хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, өмчлөх эрхэд нь халдах, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, гэм буруутайд тооцох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно... гэж Үндсэн хуулийн бичвэрийг давтсан нь хууль зүйн техникийн хувьд зөрчилгүй, хоёрдмол утга гаргахгүй байх учир холбогдолтой хамраана.

¹⁰⁴ Монгол Улсын Үндсэн хууль. Хууль Зүйн Үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр. УБ., 2014 он. 19 дэх тал.

¹⁰⁵ "Байцаах" гэдэг үгийг Монгол Улсын Үндсэн хуульд нэг удаа хэрэглэсэн.

¹⁰⁶ Монгол Улсын Үндсэн хууль. Дурьдсан бүтээл. УБ., 2014 он. 59 дэх тал.

¹⁰⁷ Ж.Амарсанаа. Англи-Орос-Герман-Монгол Олон улсын эрх зүйн толь. УБ., 2004 он. 400-401 дэх тал.

¹⁰⁸ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн англи, орос, латин эх толь бичиг. Нэмэж засварласан дөрөв дэх хэвлэлт. УБ., 2015 он. 457 дахь тал.

гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгаануудыг илрүүлэхэд оршино¹⁰⁹...”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Ж.Бямбаа нарын үзэж байгаагаар “...мөрдөн байцаалт... хэрэг бүртгэлтийн нэгэн адил гэмт хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн шалган нотлож, гэмт этгээдийн гэм буруу, учирсан хохирлын шинж байдал, хэр хэмжээ болон гэмт хэрэгт ач холбогдолтой бусад байдлын талаархи баримт, сэлт мэдээллийг цуглуулж үнэлэлт дүгнэлт өгөх, шийдвэр гаргах ажиллагааг хэрэгжүүлдэг¹¹⁰...”, мөн “...мөрдөн байцаалтын шатанд мөрдөн шалгах хэлбэрийн бүхий л ажиллагаа явагдах ба уг процессыг мөрдөгч бүрэн хариуцаж хэрэгжүүлнэ...¹¹¹”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Б.Бат-Эрдэнэ агсны үзсэнээр “...мөрдөн байцаалт нь урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагааны үндсэн хэлбэр¹¹²...”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэгийн үзэж байгаагаар “...мөрдөн байцаалт бол эрүүгийн процессын эрх зүйн үе шат болохын хувьд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх өөрийн зорилт, агуулга, мөн чанар, хууль зүйн учир холбогдлыг үүсгэдэг, хуульч ажиллагаа бөгөөд хүний эрх хэмээх үнэт зүйлийг ямагт анхаарч байх ёстой¹¹³...”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Д.Зүмбэрэллхамын тэмдэглэснээр “...эрүүгийн процессын аль ч үе шатанд анхаарах зүйл бол гэм буруугүйн презумпцийн зарчмыг анхаарч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд ялах, цагаатгах талыг тэнцүү баримтлах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийг илрүүлэхэд анхаарлаа хандуулж, сэжиглэж байгаа бол ямар ч үнээр хамаагүй түүнийгээ батлах өрөөсгөл хандах явдал байж таарахгүй¹¹⁴...” гэх зэргээр тэмдэглэсэн байна. Нийтлэг, ерөнхий агуулгын хувьд өөр хоорондоо харилцан давцах дээрх тайлбар, үзэл санаа нь уг үсгийн хувьд тохирохгүй, бага боловч ондоошиж байгаагийн шалтгаан нь хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт, тус тусын концепци, туршлагаас хамаарах үндэслэл бүхий байж болно. Мөн эрүүгийн процессын эрх зүй судалч, эрдэмтэд мөрдөн байцаалтын талаар тэмдэглэсэн байдгийг дурьдах нь зүйтэй.

Бид дээрх тайлбар, үзэл санаанаас, өргөн утгаараа “мөрдөн байцаалт нь хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн бол сэргээн эдлүүлэх, хамгаалахад чиглэсэн үе шат”, явцуу утгаараа “нотлох баримтын эх сурвалжийг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэхэд чиглэсэн үе шат” гэсэн хууль зүйн утгыг тодотгож болох юм. Нөгөөтэйгүүр, “эцсийн эцэст хүрэх бодит байдал, физик үзэгдэл (байгалийн философи), ёс зүй (ёс суртахууны философи), юмс үзэгдлийн үлэмж ерөнхий шалтгаан, зарчим болоод тэдгээрээс гарч ирсэн хүний хүртэхүй, бодол санаа зэрэгтэй холбоо бүхий мэдлэг, оюун ухааныг эрэн хайж улмаар түүнээс чангуух зүйлийг эрмэлзэх явдлыг философи гэнэ¹¹⁵” гэсэн тодорхойлолтоос бид мөрдөн байцаалтын агуулга, мөн чанарт “мөрдөн мөшгөх” гэсэн хандлагаар хандах ёстой хэмээн үзэж, хөгжүүлэхийг зорих шаардлагатай. Энэ талаар хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан нарын тэмдэглэснээр “Мөрдөн мөшгөх” гэсэн субстанцын учрыг ойлгож мэдэх, онол, арга зүйн үндсийг баттай

¹⁰⁹ Ж.Авхиа нар. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Их, дээд сургуулийн сурах бичиг. УБ., 1987 он. 89-91 дэх талд үзнэ үү.

¹¹⁰ Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008 он. 65 дахь тал.

¹¹¹ Ж.Бямбаа нар. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018 он. 215 дахь тал.

¹¹² Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. /2.Тусгай анги/ УБ., 1999 он. 25 дахь тал.

¹¹³ Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэг багштай харилцан ярилцаж, тэмдэглэж авсан гар бичмэл.

¹¹⁴ Д.Зүмбэрэллхам. Гэм буруугүйн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2001 он. 120-125 дахь талд үзнэ үү.

¹¹⁵ Мэл Томпсон. Философи. Өөрөө сурах бичиг. Хоёр дахь удаагийн хэвлэл. УБ., 2003 он. 15 дахь тал. Оксфордын тольд тодорхойлсон тодорхойлолтыг уг бүтээлээс ишлэн авлаа.

тогтоох нь процессын шинжлэх ухааны бие даасан цоо шинэ чиглэлд зүй ёсоор тооцогдох болов¹¹⁶” гэсэнтэй санал нэг байгаа билээ.

Эрх зүйн шинэчлэлийн үр нөлөөгөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөрдөн байцаалтын ажиллагаа нь мөрдөн шалгах нууц ажиллагаатай хослон хэрэгжих нөхцөл бололцоо “мөрдөн мөшгөх” утга агуулгаар яв цав илрэн гарсан гэдгийг бид анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл мөрдөгч нуугдмал болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх дээ мөрдөн шалгах ердийн болон бусад /тусгай ажиллагаа гэж болно/ ажиллагааны комбинацийг нэгтгэн хэрэглэх, тактикийн үр нөлөөтэй байдлаар хэрэгжүүлэх нь эрх зүйн соёл хандлага зөв төлөвших, хууль хэрэгжүүлэхэд хүний эрхийг хангах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх явдлаас сэргийлэх, улмаар мөрдөх албаны мөрдөгчид багаар ажиллах, хэргийн илрүүлэлтэд ахиц гарах гэх мэтийн эерэг талууд бүрэлдэх боломжтой гэж үзэж байна.

Мөрдөн байцаалтын агуулгыг бид эрдэмтдийн үзэл санаагаар баяжуулан судлахын зэрэгцээ хэл шинжлэлийн хийгээд гарал үүслийн судалгаагаар дотоод агуулгад нь нарийн шинжилгээ, тайлбар хийх боломжтойг ч анхаарах хэрэгтэй. “Мөрдөн байцаалт” гэж уг гарвалаараа Монгол хэлэнд аливаа зөрчил, хэргийг мөрдөн шалгах үйл явц¹¹⁷-ийг илэрхийлсэн ерөнхий түгээмэл утгатай. Гэвч бид мөрний тухай сургаалийг энд авч үзэхгүйгээр утгын гүнд нэвтрэхгүй. “Мөрдөх” гэдэг үгийн язгуур “мөр” хэмээх үг нь “ором, ул, зам, аливаа хэргийн гэрч баримт, шугам, зураас¹¹⁸” гэсэн утга илэрхийлнэ. Үүнээс улбаалан “мөрдөх” гэсэн үйл үгийн утга нь “юмны зам мөрөөр орон явах, мөрийн мөшгөн хянаж шалгах, гэмт хэрэг эдүүлсэн явдлыг илрүүлэн гаргах¹¹⁹” гэсэн утга илэрхийлнэ. Харин “байцаалт” гэсэн үгтэй “мөрдөх” хэмээх үг хоршиход криминалистик¹²⁰-ийн агуулгаас хууль зүйн агуулгад шилжинэ. Өөрөөр хэлбэл бид өмнө хөндсөн тэрхүү агуулгаар тайлбарлагдана.

Мөрдөн байцаах гэсэн утгаас “мөрдөн мөшгөх” шилжилт хийхэд тийм ч амаргүй байгааг бид тал бүрээс нь судлан үзэх шаардлага бийг анхаарч байгаа. Сэтгэлгээ өөрчлөгдөхгүй байгаагийн гол илэрхийлэл болох хэллэг, нэр, томьёо, философи, онол, арга зүйд цаашид хандах нь зүйтэй. Үүний өмнөтгөл болгож миний бие уг өгүүллийн хүрээнд асуудлын ердөө өнгөн хэсгийг хөндөх замаар эрдэмтэн, судлаачид, хуульч, мөрдөгчид, судлаач хэн бүхэнд нээж буй хэрэг билээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн байцаалтын ажиллагааны үе шат болохыг тэмдэглэж, улмаар агуулгын хувьд дахин судлаж, үзэх нь тогтолцоог шинэчлэх, өөрчлөх нөхцөл гэж үзэж байна.

¹¹⁶ Ж.Бямбаа нар. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018 он. 206 дахь тал.

¹¹⁷ <https://mongoltoli.mn/dictionary/detail/10845> цахим их тайлбар толь үзнэ үү.

¹¹⁸ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он. 345 дахь тал., <https://mongoltoli.mn/dictionary/detail/58164> цахим их тайлбар тольд уг холбоосоор илүү өргөн агуулгаар тайлбарласныг, шилжсэн утгыг үзнэ үү.

¹¹⁹ Я.Цэвэл. Дурьдсан бүтээл. УБ., 1966 он. 345 дахь тал., <https://mongoltoli.mn/dictionary/detail/58315> цахим их тайлбар тольд холбоосоор хандаж, үндсэн ба шилжсэн утгын хамт үзнэ үү.

¹²⁰ Мөн хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор Б.Лхагвасүрэнгийн “Мөр” хэмээх сонсогч, оюутан, суралцагчид болон мөрдөгчид зориулсан 2015 оны гарын авлагад Мөрний тухай криминалистикийн сургаал хэсэгт багтаан мөр судлалын талаар авч үзсэн. Энд мөрдөн байцаалтын хууль зүйн агуулгыг үл хөндөж, мөрний сургаал, үндсэн ангилал, шинж, мөртэй ажиллах арга зүй, мөр үүсэх зүй тогтол, хэргийн газрын үзлэг, мөр судлалын шинжилгээний талаар авч үзсэн нь өнөөдөр ч эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын гол хэрэглэгдэхүүн байсаар байна.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛД

А.Амарсайхан
Судлаач

Товч агуулга. Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний чанар, үр нөлөөг тодорхойлох, тулгамдаж буй асуудал, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, учир шалтгааныг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг дүгнэхийн зэрэгцээ цаашид боловсронгуй болгох чиглэлээр дүгнэлт, саналаа илэрхийлэв.

Түлхүүр үг. Зөрчил, Зөрчлийн тухай хууль.

Үндсэн хэсэг. Гэмт хэрэг, зөрчлийг ялгаж заагласан үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь хоорондоо уялдаагүйгээс нэг бол эрүүгийн хариуцлага хэмээн ял шийтгэх нэг бол захиргааны хариуцлага хэмээн батлагдсан хууль болгонд торгох шийтгэл тусгаж ирснийг хууль зүйн нэгдсэн бодлогоор цэгцэлж Зөрчлийн тухай хуулийг хууль тогтоогчоос батлан гаргажээ. Түүнчлэн урьд нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хуульд заасан захиргааны зарим зөрчил нь ижил, төстэй байсан бөгөөд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх бэрхшээлийг шийдвэрлэсэн.

Зөрчлийн тухай хуульд бусад хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдлийг зөрчилд тооцон төрөлжүүлж нэгтгэхдээ зарим зөрчлийн шинжүүдийг нэгтгэн нэг зүйл, хэсэгт томъёолсон нь хууль хэрэгжүүлэгч субъектүүдийн зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг тогтооход хүндрэл үүсгэсэн. Эрүүгийн хуульд заасан зарим төрлийн гэмт хэргийн шинжтэй давхардуулсан, зарим зөрчлийг тусгаагүй орхигдуулсан нь тухайн үйлдлийг гэмт хэрэг, зөрчлийн аль нь болохыг шийдвэрлэх боломжгүй байдлыг бий болгож, хууль ёсны зарчмыг гажуудуулах явдал оршсоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т¹²¹ “... Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэж заасан нь зөрчил болон гэмт хэргийн улмаас хүний эрх бусад үнэт зүйлст учруулж болох хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлсэн, мөн хүнийг хилс хэрэгт хэлмэгдүүлэхгүй байхад чиглэгдсэн суурь хамгаалалт юм.

Зөрчлийн тухай хууль¹²²-д цаг үеийн шаардлагын дагуу хуульд нэмэлт өөрчлөлтийн талаар олон зохицуулалтууд тусгагдсан байх хэдий ч тухайн хуулийг уншин судлах, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад асууж тодруулах, анхаарах буюу нэг мөр ойлголтод хүрэх, тодотгон боловсронгуй болгох зарим асуудлаар өөрийн үзэл бодлыг товч илэрхийлж байгаа зөрчил гарсаар байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу “2017 онд 4337, 2018 онд 10981, 2019 онд 15296 хүнийг баривчилсан байна. Тухайлбал, 2020 оны 11 дүгээр сарын байдлаар Гэр бүлийн

¹²¹ Төрийн мэдээлэл УБ., 1992 он №1

¹²² Төрийн мэдээлэл УБ., 2017 он №24

хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил гаргасан 7571 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2034 буюу 36.9 хувиар тус тус өссөн байна.”¹²³

2019 онд харьяаллын дагуу шийдвэрлэсэн хэрэгт нийт шийтгэл оногдуулсан 17829 хүнээс 1596 хүн буюу 8.9 хувьд торгох, 16235 хүн буюу 91 хувьд баривчлах шийтгэл тус тус оногдуулжээ. Шүүхээс оногдуулсан 10 шийтгэл тутмын 9 нь баривчлах шийтгэл байна.Түүнчлэн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээллээр хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 3 жилийн дунджаар 81 хувь байгаа боловч, мөнгөн дүнгийн биелэлт 45 хувь байна¹²⁴.

Хууль хэрэгжих явцад уялдаа холбоог сайжруулах, зарим зүйлсийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг хууль эрх зүйн хувьд тулгарч болох асуудлууд тулгараад явж байна. Үүнийг шат шатны хууль хяналтын байгууллагууд дүгнээд явж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хууль нь 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 28 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Хүн, хуулийн этгээд бүрд хууль тэгш, шударгаар үйлчлэх, хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцүүлэн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан нь зөрчил үйлдсэн хүнийг шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй байх талаар тодорхой тусгасан. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан нь шударга ёсыг бэхжүүлэх, хуулийн зорилтыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зорилго бүхий Зөрчлийн тухай хууль нь 2017 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөгдөж эхэлсэн, өнөөдрийн байдлаар 18 бүлэг, 236 зүйлтэй ерөнхий болон тусгай гэсэн 2 ангид хуваагдан хүчин төгөлдөр үйлчилж байна.

Зөрчлийн хуульд хэд хэдэн салбарын хуулиуд дахь зөрчлүүдийг нэгтгэсэн нь хуулийг хэрэглэгчдийн хувьд ч салбарын хуулиудыг хайж олох, мэдэх, судлахад төөрөгдөх, будилах, алдаа, зөрчил гаргах боломжтой. Тухайлбал,

Хүүхдийн эрхийг зөрчих зөрчил. Холбогдох салбар хуулиар нь нарийвчлан зохицуулж болох зөрчлүүдийг холимог байдлаар нэг дор бөөгнөрүүлэн заасан нь ойлгомжгүй, хэрэглэхэд төвөгтэй байдал үүсгэхээр байна.

Хүн, хуулийн этгээд энэ төрлийн багц зөрчлийг үйлдэхгүй байх буюу эрх үүргийн хэмжээ хязгаараа мэдэхэд эсхүл үйлдэгдсэн зөрчлийг шалгах, шийдвэрлэхэд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Дархлаажуулалтын тухай хууль, Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай хууль, бусад холбогдох хэм хэмжээний актуудыг хайж олж, судлан мэдсэн байх зайлшгүй шаардлагатайгаас гадна Эрүүгийнхээс бусад холбогдох салбарын хууль тогтоомж зөрчсөн тухайд Зөрчлийн тухай хууль дахь холбогдох заалтуудыг олж тогтоон "зөрчлүүд давхцсан эсэх, давхцаагүй нарийвчилсан зохицуулалт нь аль болох" зэрэг цогц олон асуудлыг иж бүрэн, нарийвчилсан байдлаар мэдэх, шалгах, тогтоох ёстой болно.

Мөн Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих тухай 10.4 дүгээр зүйлд заасан зөрчил. Энэ бол олон салбар хуулиуд, захиргааны хэм хэмжээний актаар тогтоох маш өргөн хүрээг хамааруулж болох зөрчил. Энэ мэт цөөнгүй зөрчлүүд байна.

Эрх зүйн зөрчлийн объект нь: Эрх зүйн хамгаалах хэмжээний нөлөөллөөр аливаа гэмт халдлагаас хамгаалагдаж байгаа нийгмийн харилцаа юм.

¹²³ ЦЕГ мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

¹²⁴ Шүүхийн ерөнхий зөвлөл 2019 оны Шүүхийн үйл ажиллагааны тайлан

Зөрчлийн төрөл нь Зөрчлийн тухай хуулиар 902 үйлдлийг зөрчилд тооцож, тэдгээрийг 12 төрөлд ангилж, 194 зүйлд хуваасан байна. Зөрчилд өртөгдөж байгаа нийгмийн харилцааны шинж байдлаас хамааруулж ангилдаг.

Шинэчлэн найруулсан Зөрчлийн тухай хуульд цаг үеийн шаардлагын дагуу шинэ буюу шинэвтэр олон зохицуулалтууд тусгагдсан байх хэдий ч тухайн хуулийг уншин судлах, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад асууж тодруулах, анхаарах буюу нэг мөр ойлголтод хүрэх, тодотгон боловсронгуй болгох зарим асуудлаар өөрийн үзэл бодлыг товч илэрхийлж байна.

Хүн, хуулийн этгээд бүрд хууль тэгш, шударгаар үйлчлэх, хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцүүлэн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан нь зөрчил үйлдсэн хүнийг шийтгэлээс чөлөөлөх үндэслэл болохгүй байх талаар тодорхой тусгасан. Зөрчлийн тухай хуулиар хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэхээр заасан нь шударга ёсыг бэхжүүлэх, хуулийн зорилтыг хангахад чухал ач холбогдолтой юм. Гэвч Зөрчлийн тухай хуулийн зохицуулалтаар хуулийн этгээдийг ашиглан, түүгээр дамжуулан зөрчил үйлдсэн хувь хүнийг шийтгэлээс чөлөөлөх нь шударга ёсны зарчимд нийцэхгүйгээр зогсохгүй зөрчил үйлдсэн хүн хариуцлагаас зайлсхийх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталж, 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтсон.

Хуулийн нэмэлт өөрчлөлтөд уг хуулиар зохицуулах харилцаа, хамрах хүрээ, Зөрчлийн тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зохицуулалтыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

-Хуульд заасан зарим хоёрдмол утга бүхий ойлгомжгүй нэр томьёо, найруулгыг залруулсан.

Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 1.1-д уг хуулийн зорилгыг тодорхойлохдоо “хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох” гэж заасан боловч хуулийн тусгай ангийн зөрчлийг тодорхойлсон зүйлийн гарчгийг “хууль зөрчих” гэж томъёолсон нь дээр дурьдсан зорилтод заасан “захиргааны хэм хэмжээний актыг” орхигдуулсан бөгөөд зөрчилд тооцохоор заасан олон үйлдэл, эс үйлдэхгүйг хамаарахгүй байх тул “хуулийн тусгай ангид заасан “хууль зөрчих” гэж “хууль, тэдгээр хуулиар эрх олгосны дагуу гаргаж, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлд заасны дагуу хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөнийг ойлгоно.” гэх тайлбарыг нэмсэн байна.

Мөн хуулийн 1.2-т “Зөрчил, түүний шинжийг энэ хууль, бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлно.” гэж заасан нь “зөрчлийг зөвхөн энэ хуулиар тодорхойлох, харин түүний шинжийг бусад хууль, захиргааны хэм хэмжээний актаар тодорхойлох хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй байх тул зөрчил, түүнд оногдуулах шийтгэлийг зөвхөн энэ хуулиар тодорхойлдог байхаар тусгасан.

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зөрчлийн ойлгомжгүй нэр томьёо, найруулгыг засаж сайжруулсан. Жишээлбэл, хуулийн 7.2 дугаар зүйлийн гарчгийг “Нийтийн журам зөрчих” гэж тодорхойлсон хэдий ч уг зүйлд зөвхөн “орон сууцанд шөнийн цагаар бусдын амгалан тайван байдлыг алдуулах” үйлдэл 3 хамаарахаар заасан нь учир дутагдалтай юм. Учир нь “public order” буюу, үгчлэн орчуулбал “нийтийн журам”-нь зөвхөн “орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдал”-аар хязгаарлагдахгүй бөгөөд “нийтийн журам” зөрчих зөрчилд “нийгэм, түүний харилцаанд оролцогч нарын хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг” ойлгодог тул уг зүйлийг өөрчлөн найруулсан. Түүнчлэн, зөрчлийн шинж чанар, давтамж, одоо хүчин төгөлдөр хэрэгжиж буй хуулийн зөрчлийг судлан үзсэний үндсэн дээр зөрчил үйлдэгч этгээдийн санхүү, хөрөнгийн чадавх, зөрчлийн хор уршиг, зөрчлийг шалган шийдвэрлэх субъект зэрэгтэй уялдуулан зөрчилд оногдуулах торгох шийтгэлийг хэмжээг илүү уян хатан, практикт хэрэгжихүйц болгон өөрчилсөн. Тухайлбал, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчигчид

оногдуулах торгуулийн хэмжээ нь хэт өндөр байгаа тухай багагүй шүүмжлэл иргэд, олон нийтээс ирж байна. Учир нь орчин үед иргэд тээврийн хэрэгсэл эзэмших, өөрийн эзэмшлийн тээврийн хэрэгсийг ашиглан замын хөдөлгөөнд оролцох нь хэвийн үзэгдлээр зогсохгүй, амьдралынхаа хэрэгцээ шаардлагыг хангах, орлого олох, амьжиргаагаа залгуулах чухал ач холбогдолтой хэрэгсэл болсон. Ийм үед замын хөдөлгөөний нягтрал, ачаалал ихтэй, зам харилцаа төдийлөн хөгжөөгүй манай улс орны нөхцөлд жолооч зөрчил гаргах магадлал дэлхийн жишгээс өндөр бөгөөд тийнхүү зөрчил гаргасан тохиолдол бүрд нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр /240 мянган төгрөг/ эсхүл түүнийг 2-3, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэнтэй тэнцэхүйц хэмжээний төгрөгөөр торгох нь иргэдийн дундаж цалин Үндэсний статистикийн хороо¹²⁵-ны 2016 оны 9 сарын мэдээллээр 888 мянган төгрөг, үүнээс 500 – 700 мянган төгрөг буюу түүнээс бага цалинтай иргэдийн тоо 36 орчим хувь байгаатай харьцуулан авч үзэхэд иргэдийн хууль зүйн боловсрол төдийлөн өндөр бус, хуулийн сургалт, сурталчилгаа идэвхитэй хийгддэггүй нөхцөлд иргэн ажилдаа ирэх, очих үедээ 6 гаргасан зөвхөн нэг зөрчилд нэр сарын цалингаа, эсхүл түүнээс их хэмжээний торгууль төлөх нь хэт өндөр байна гэж үзлээ.

Дүгнэлт

Дээрх судалгаанааг дүгнэн үзэх Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, түүний чанар, үр нөлөөг тодорхойлох, тулгамдаж буй асуудал, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, учир шалтгааныг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлон хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг дүгнэхийн зэрэгцээ цаашид боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага оршсоор байна.

Зөрчлийн тухай хууль болон бусад хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актуудад Зөрчлийн эрх зүйд тулгамдаж буй харилцааг зохицуулж байгаа хэдий ч Зөрчлийн тухай хуульд "Захиргааны хэм хэмжээ тогтоосон акт"-ын талаар илүү хүртээмжтэйгээр хуулийг хэрэглэж байгаа субъектүүдэд хүргэх,

Ямар зөрчлүүд зохицуулагдсан эсэх нь тодорхой байх

Аливаа харилцааг аль болохуйц салбарын хуулиар төрөлжүүлэн нэгтгэн зохицуулах бус хуулиас давсан захиргааны хэм хэмжээг дур зоргоор тогтоох боломжийг хязгаарлах,

Салбар хуулийн ба захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд дахь зөрчлийг ялган зааглах, давхцуулахгүй байх үүднээс Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулахаар заасан буюу захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдэлд хамаарах тухайн актуудыг "Зөрчлийн тухай хуулийн эх сурвалж"-д хамааруулах,

Зөрчлийн бүрэлдэхүүн /объект, объектив тал, субъектив тал, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд буюу субъект/-ий талаар зөрчлийн эрх зүйг судлах явцад системтэйгээр онолын нэгдсэн нэгдмэл ойлголтыг өгөх хэрэгцээ зэргийг цаашид судлан үзэх нь зүйтэй байна.

-----oOo-----

¹²⁵ www.1212.mn

ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ОБЪЕКТЫН СУДАЛГААГ НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД АШИГЛАХ НЬ

Г.Бямбадорж
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
ахлах багш, докторант, цагдаагийн хошууч

Товч агуулга. Хэсгийн байцаагчийн объектын судалгаанд үндэслэн нөхцөл байдлыг үнэлэх, нийгмийн хэв журам хамгаалах талаар явуулж буй аливаа үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тухайлбал, эргүүл харуулын үүрэг гүйцэтгэх, эргүүл харуулын нэгдсэн байршил, чиглэлийг тодорхойлох, гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлан ирэх үеийн хамгаалалт зохион байгуулах, үндэсний их баяр наадам болон олон нийтийг хамарсан арга хэмжээний төлөвлөгөө, зураглал боловсруулах, хүн, хүч, техник хэрэгслийг тооцох, ажиллуулах зэрэг үйл ажиллагаа явуулахдаа объектын судалгаанд түшиглэн хэрхэн хэрэгжүүлэх талаар товч авч үзсэн.

Түлхүүр үг. Цагдаагийн байгууллага, хэсгийн байцаагч, объектын судалгаа, нийтийн хэв журам.

Цагдаагийн байгууллага сар, улирал, жил бүр үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ гаргаж, гэмт хэрэг, зөрчлийн төрөл, өсөлт бууралт, хэрэг, зөрчлийн ангилал, халдаж буй нийгмийн харилцаа, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаагаар сар бүр дүн шинжилгээ хийж байгаа ч энэхүү статистик мэдээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төдийлөн ашиглаж, тодорхой үр дүн гаргахгүй байна.

Бидний үзэж байгаагаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд урьдчилан дүн шинжилгээ хийж аль дүүрэг, хороонд ямар төрлийн гэмт хэрэг өсөж байна тэр дүүрэг хороонд эргүүлийн чиглэл, хүн, хүчийг түлхүү ажиллуулах, олон нийтийн цагдаагийн ажилтан нарыг үүрэг гүйцэтгүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг, газрын судалгаанд дурдагдсан газруудыг эргүүлийн чиглэлд оруулж, цагдаагийн эргүүл ажиллуулах замаар гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй газруудад үзлэг, шалгалт явуулж Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх¹²⁶ чиглэлийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Мөн үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг бага үйлдэгдэж байгаа эргүүлийн чиглэлүүдийг хасаж, шинээр гэмт хэрэг ихээр үйлдэгдэж байгаа газруудад эргүүлийн чиглэл бий болгож болно. Түүнээс гадна тухайн нутаг дэвсгэрт эргүүлийн чиглэл шинээр бий болгох, чиглэлийг хасах тохиолдолд тухайн нутаг дэвсгэр хариуцсан хэсгийн байцаагчийн саналыг харгалзан энэхүү чиглэлийг тогтоовол илүү үр дүнтэй гэж үзэж байна. Түүнчлэн, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа урамшуулалт эргүүл, олон нийтийн цагдаа нарыг цагдаагийн байгууллагын захиргааны хяналтын чиг үүргийн нэг болох хорих ял эдлээд суллагдсан хүмүүст тавих хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор эргүүлийн чиглэлүүдэд хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийн судалгаанд авагдсан этгээдүүдийн хаягийг тусган өгч, алба хаагчид хороо хэсэгт эргүүл хийхдээ, тухайн судалгаанд авагдсан, захиргааны хяналтад байгаа этгээдэд захиргааны хяналт тавих ажлыг хэрэгжүүлж тэдний зүгээс гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах боломжтой.

¹²⁶ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль

Ингэснээр нь хорих ял эдлээд суллагдсан этгээдэд тавих хяналт сайжирч, хэсгийн байцаагчийн субъектын судалгааны ач холбогдол нэмэгдэх юм.

Мөн доктор (Sc.D), профессор Ж.Долгорсүрэн Монгол Улсын цагдаагийн эрх зүй хэмээх бүтээлдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээнд хамааруулах хүмүүсийг дор дурдснаар тодорхойлсонтой санал нийлж байна. Үүнд:

- Гэмт хэрэг тухайн үед үйлдээгүй боловч тааламжгүй нөхцөлд байгаа бөгөөд бусдын нөлөөгөөр гэмт үйлдэл хийж болох;
- Нийгмийн дэг журам зөрчиж, жижиг зөрчлүүд гаргаж байгаа;
- Гэмт хэрэг үйлдэх санаа, сэдэлт бүрэлдэж, тодорхой гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж эхэлсэн;
- Гэмт хэрэг үйлдэж эхэлсэн боловч төгсгөлд хүргэж чадаагүй;
- Гэмт хэрэг үйлдсэн бөгөөд дахин үйлдэж болох хүмүүс гэх мэт.

Энэ арга нь хорих ял эдлээд суллагдсан бүх хүнд биш, Эрүүгийн хуульд заасан тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгэгдээд суллагдсан зарим хүмүүст хэрэглэгдэнэ.¹²⁷ гэжээ.

Дээрх нэг бүрчилсэн арга хэмжээнд хамааруулах субъектүүдээс үзвэл, объектын судалгааны төрөл болох гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хүмүүс, гэр бүл орчиндоо тааламжгүй байдал гаргадаг хүмүүс, гэмт хэрэгт холбогдогчдын судалгаанд авагдсан хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Түүнчлэн, үйлдэгдсэн гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцлийн талаар судалгааг ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг ихээр үйлдэгдэг цэг, газруудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор камерын хяналтын систем ашиглан гудамж талбай, үзвэр үйлчилгээний газруудыг хянах боломжтой. Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг, газруудын судалгаанд түшиглэн гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэг, газруудад хяналт шалгалт явуулж, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх боломжтой.

Цагдаагийн байгууллагаас тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд төрөл бүрийн нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж үр дүнг тооцон ажиллаж байна. Тухайлбал, 2018 онд цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын хэмжээнд 818, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсээс зохион байгуулсан 807 нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулж, 2156 удаагийн үзлэг, шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.¹²⁸ Мөн охид, эмэгтэйчүүдийг хүчээр биеийг нь үнэлүүлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах, бэлгийн мөлжлөг үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хариуцсан нутаг дэвсгэрийн зочид буудлын судалгаанд түшиглэвэл үр дүнтэй.

Монгол Улсаас БНХАУ-ын Эрээн хотод 150, Алтан-Эмээл 25, Манжуурт 30, Хөх хотод 50, Бээжин хотод 120, Чиндаод 60, Тяньжинд 30, Гуанжоуд 40, Донгуанг хотуудад 50, Макаоод 80, Сингапурт 120, Шинжин 50, Тунляод 20, Шанхай 25, Малайз 50, нийт 900 гаруй эмэгтэй биеэ үнэлж байгаа нь тогтоогдсон.¹²⁹ Энэ төрлийн судалгаанд зочид буудлын хаяг, нэр, байршил, барилга байгууламж, өрөө тасалгаа, байнгын үйлчлүүлэгч болон ажилладаг хүмүүсийн судалгаа зэргийг тусгасан байх бөгөөд уг нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээ явуулах, үзлэг, шалгалт хийхдээ дээрх судалгааг ашиглаж болно.

Энэ чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээнээс үзвэл, нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа саун, массажны 39 газрыг илрүүлж,

¹²⁷ Долгорсүрэн Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ хот 2006 он., 135 дахь тал

¹²⁸ Цагдаагийн ерөнхий газрын тайлан 2018 он

¹²⁹ Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртөж хохирсон хүмүүсийн судалгаа. УБ хот 2016., 44 дэхь тал

давхардсан тоогоор 42 удаа үзлэг, шалгалтыг зохион байгуулж, 16-17 насны 6, насанд хүрсэн 145 эмэгтэйг массаж нэрийн дор бэлгийн мөлжлөгийн зорилгоор бусдад худалдаалж байсныг илрүүлсэн, мөн энэ төрлийн гэмт хэргийг зохион байгуулж байсан 53 этгээдэд холбогдох үйлдлийг илрүүлжээ.

2018 онд Эрүүгийн цагдаагийн албаныхан бэлгийн мөлжлөгийн зорилгоор бусдыг хил давуулан худалдсан 150 хохирогч, 51 холбогдогчтой 45 хэргийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.¹³⁰

Мөн гэр бүл орчиндоо байнга тааламжгүй байдал гаргасан хүмүүсийн судалгаа буюу гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарын судалгаанд түшиглэн гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн түвшинг оновчтой тодорхойлох нь хохирогчид шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх, аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учрах аюулын эрсдлийн түвшинг бууруулахад чухал ач холбогдолтой.¹³¹

Нөгөө талаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдэд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах хорооны нутаг дэвсгэрт гэр бүлийн хүчирхийллийн мөн чанар, хор уршгийг тайлбарлан таниулсан сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах замаар Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д заасан нэг бүрчилсэн чиглэлийг хэрэгжүүлнэ.

Цагдаагийн хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч, хороо хариуцсан цагдаа нар нь субъектын судалгааг явуулахдаа гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээд хаана амьдарч байгаа, урьд өмнө нь гэмт хэрэг, зөрчил үйлдэж байсан эсэх, ял эдэлж байсан эсэх, ял тэнссэн, хорихоос өөр төрлийн ял шийтгэл эдэлж байсан эсэх, хорихоос суллагдсан зан төлөвийн хувьд тогтворгүй хүмүүсийг судлан мэдэж цаг тухайд нь бүртгэл судалгаандаа авч хүн амын талаар бүх талын мэдээлэлтэй болох нь гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой юм.

Түүнчлэн Эрүүгийн үүрэг гүйцэтгэхэд Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код (400) эргүүлийн үүрэг гүйцэтгэх журмыг баримтлах бөгөөд хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү хэв журмын судалгаанд түшиглэн эргүүлийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ. Энэ тухай уг журмын 401.3.1-д эргүүлийг нутаг дэвсгэрийн болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд хийсэн судалгааны үндсэн дээр ажиллуулна.¹³² хэмээн заасан нь нийгмийн хэв журам хамгаалах ажилд эрүү хэв журмын судалгаа ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код (500) Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах журмын 500.6.14-д Хамгаалалтын арга хэмжээ нь дараах үе шатаас бүрдэнэ:

а/бэлтгэл үе: Арга хэмжээ зохион байгуулагдах газар, цаг хугацаа, оролцогчдын тоо, хөтөлбөрийг тодруулж, түүнд нөлөөлөх хүчин зүйл, штаб болон удирдлагын бүлгийг байгуулах, зохион байгуулагч нартай хамтран арга хэмжээ явагдах газар нутагт үзлэг шалгалт хийх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, газар орныг 2-3 цэгээс үзэж танилцах, оролцогч нарын ирэх, буцах чиглэл, тээврийн хэрэгслийн зогсоол, гал унтраах болон эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх багийг байрлуулах цэг, нөхцөл байдал, өөрийн хүч, хэрэгслийн боломжийг судлах, цаг агаар зэрэг хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлно.

¹³⁰ Цагдаагийн ерөнхий газрын тайлан мэдээ 2018 он

¹³¹ Бадамханд Ю. Жөндөрт суурилсан хүчирхийлэл гарын авлага. УБ хот 2016., 75 дахь тал

¹³² Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код (400) эргүүлийн үүрэг гүйцэтгэх

Үүний дараа цагдаагийн байгууллагын дарга нь нөхцөл байдал, хүчин зүйлийг үнэлж, дүгнэн нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах хүч, хэрэгслийн тооцоо, хамгаалалтын төлөвлөгөө, зураглалыг энэ журмын 500.8 дугаар зүйлд заасны дагуу боловсруулна

б/төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе: Хамгаалалтын төлөвлөгөө, зураглалын дагуу ажиллах;
в/төгсгөлийн үе: Олон нийтийн арга хэмжээнд оролцогч нарыг зохион байгуулалттайгаар гаргах, тараах, самнах, эргүүл, харуул ажиллуулах, хамгаалалтын ажиллагааг үнэлж, дүгнэх, хүч хэрэгслийн тооцоо, тооллого хийх, байгууллагуудын оролцоог Шуурхай удирдлагын болон шуурхай штабт нэгтгэн танилцуулах ажиллагааг гүйцэтгэнэ хэмээн заажээ.

Дээрх заалтуудаас үзэхэд хамгаалалтын төлөвлөгөө зураглал хийхэд тухайн нутаг дэвсгэрийн сум баг хорооны зураглал, туслах хүчний судалгааг зэргийг ашиглаж нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Мөн баяр наадмын үеийн хамгаалалт, олон нийтийг хамарсан арга хэмжээний хамгаалалт зохион байгуулахдаа цагдаагийн байгууллагын объектын судалгааг ашиглаж хүн хүч хэрэгслээ тооцож хэн хэн, хаана ямар ямар объектыг хамгаалах цэг газрыг тогтоож өгнө.

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушалаар батлагдсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны код (501) дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал объектын харуул, хамгаалалтыг зохион байгуулах журмын 501.5.10-д Харуулын цагдаа нь дараах үүрэгтэй гүйцэтгэнэ.Үүнд:

а/объектын хамгаалалтын талаар мэдлэг чадвартай байж, хяналт тавих цэг, явах чиглэл, орчны нөхцөл байдлыг судалсан байх;

б/цагдаагийн дүрэмт хувцсыг зохих журмын дагуу, цэвэр үзэмжтэй хэрэглэн, Цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм, ажил үйлчилгээний стандартыг мөрдөж, сонор сэрэмж, сахилга, ёс зүйг сахиж, хамгаалж буй объектын аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах;

в/харуулын цагдаа нь үүрэг гүйцэтгэх үедээ Хууль зүйн сайдын тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагад ашиглах галт зэвсэг, тусгай хэрэгслийн жагсаалт”-д заасан галт зэвсэг, тусгай хэрэгслийг ашиглах;

г/онц чухал объектод нэвтрэх хүн, тээврийн хэрэгслийг тогтоосон журмын дагуу шалган нэвтрүүлэх;

д/объектын гадна, дотор талын байрлалын болон орчны нөхцөл байдалд байнга ажиглалт хийх гэх мэт.

Дээрх үүргийг гүйцэтгэхийн тулд хариуцсан нутаг дэвсгэрийн объектын судалгааг ашиглаж тухайн объектын гаднах шинж байдал, хашаа хороо, барилга байгууламж зэргийг судлан гэмт халдлага үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг газрыг тогтоон тогтоосон хугацаанд тэрхүү эмзэг, цэг газрыг шалгах, хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн уг объектод халдлага гарсан тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн объектын судалгааны бүрэлдэхүүн хэсэг болох субъектын судалгаанд авагдсан этгээдүүдийн дундаас уг халдлагыг үйлдсэн байж болох субъектүүдийг тодорхойлох, таамаглал дэвшүүлж шалгах зэргээр объектын судалгааг ашиглаж болно.

Жагсаал, цуглаан, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд цагдаагийн байгууллага Цагдаагийн албаны тухай хууль болон ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам (504) нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах журмын 504.4.1-д зааснаар Цагдаагийн байгууллага нь нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 4, 5 дугаар бүлэгт заасан үүргийг хэрэгжүүлэхийн хамт дор дурдсан ажлыг хийнэ. Үүнд:

б/галт зэвсэг, хэрэгсэл, хүчтэй үйлчлэх химийн хорт бодис, согтууруулах ундааны зүйл зардаг газруудыг хяналтад авах;

в/иргэдийн эзэмшилд байгаа галт болон хүйтэн зэвсэг, галт хэрэгсэл, аж ахуйн нэгж байгууллагад хэрэглэгдэж буй тэсэрч дэлбэрэх, хүчтэй үйлчлэх химийн хорт болон цацраг идэвхт бодис, сургалтын зоирулалттай байлдааны зэвсэг, техник хэрэгслийн ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавих;

д/тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, тэдгээрт үзлэг хийх;

ж/эргүүл, харуул ажиллуулах;

и/иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын өмч хөрөнгийг хамгаалалтад авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх гэх мэт чиг үүргийг хэрэгжүүлэхдээ объектын судалгааны галт зэвсэгтэй иргэдийн бүргэл, судалгааг ашиглан хяналт шалгалт явуулах чиглэлийг тодорхойлж, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Мөн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, эргүүл, харуул ажлуулахын тулд нөхцөл байдал хүндэрсэн хэсгүүдийг объектын судалгаанаас сонгон авч тэрхүү хэсгүүдэд алба хаагчдыг үүрэг гүйцэтгүүлнэ.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахын тулд баталгаатай болон баталгаагүй нуугдмал зам, уулзвар гарцыг сум баг хорооны зураглалд тэмдэглэсэн байдаг учир энэхүү судалгааг ашиглан тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, үзлэг шалтгалтыг явуулж болох юм.

Мөн иргэдийн өмч, хөрөнгө мөнгө ихээр төвлөрсөн газруудыг хамгаалахын тулд тухай нутаг дэвсгэрийн банк санхүүгийн байгууллага, түүх соёлын дурсгалт эд зүйлийг хадгалж хамгаалж байгаа хүн, хуулийн этгээд болон бусад газруудыг шуурхай хамгаалахын тулд тухайн нутаг дэвсгэрийн объектын судалгааг ашиглаж уг газруудад алба хаагчдыг яаралтай томилж эргүүл, харуулын үүрэг гүйцэтгүүлэх, хүч нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд объектын судалгааг ашиглаж болно.

Гадаадын зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалтын үед ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код (506) төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах журмын 506.2.2-д "төлөөлөгөө, зураглалд хамгаалалт зохион байгуулах хугацаа, газар, объектууд, хамгаалалтад оролцох хүч хэрэгслийн тоо, үндсэн болон нөөц хүчний байршил, холбооны хэрэгслийн тор, сүлжээ, дуудлага, хамгаалалтыг удирдах ажлын хэсэг, техник хэрэгсэл, алба хаагчдын үүрэг гүйцэтгэх хуваарь, эрсдэлийн үед ажиллах арга хэмжээг тодорхой тусгасан байна", 506.3.13-д "нэгдүгээр зэрэглэлийн хамгаалалтад ажиллаж байгаа алба хаагч хариуцсан цэг, хэсэг дээрээ ирээд тухайн газар, оронд үзлэг шалгалт хийн зөрчил илэрсэн тохиолдолд нэн даруй шууд харьяалан удирдах даргадаа мэдэгдэж, зөрчлийг арилгах арга хэмжээ авна" гэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд тухайн нутаг дэвсгэрийн объектын судалгааны аж ахуйн нэгж байгууллагын судалгааг ашиглаж аж ахуйн нэгж байгууллага, объект бүрт нэг цагдаагийн алба хаагчийн томилж үүрэг гүйцэтгүүлснээр хүч хэрэгслийг оновчтой хувиарлэх үндэс бүрдэнэ.

Мөн тухайн байгууллага аж ахуйн нэгжийн судалгааг ашиглан уг объектын тээвэр, тагт, шугам, хоолой, хонгил, суваг, шуудуу байгааг төвөггүй мэдэж тухайн цэг газар оронд үзлэг шалгалтыг үр дүнтэй явуулах боломж бүрдэнэ.

Ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагааг хэрэгжүүлэх үед ЦЕГ-ын даргын тушаалаар баталсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код (509) Зорчигч тээшийг тээврийн замд нь харгалзан хүргэх журмын 509.4.3-д заасан Аюултай ачаа тээшийг тээвэрлэх маршрут, хоноглох газар, тээвэрлэн хүргэх хугацаа, харилцан ажиллах цагдаагийн байгууллагыг лицензийн төв батална. Гэсэн заалтыг хэрэгжүүлэхийн тулд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт аюултай ачаа тээшийг тээвэрлэх маршрут, тээвэрлэн хүргэх хугацааг баталж, маршрут,

хугацааг батлахдаа ЦЕГ-ын Олон нийтийн аюулгүй байдлыг хангах газарт урьдчилан мэдэгдэж чиглэл авна.

Ийнхүү чиглэл авахдаа дайран өнгөрөх сум баг хорооны нутаг дэвсгэрийн эрүүгийн хэв журын нөхцөл байдал, гэмт хэрэг үйлдэгчдийн судалгаа, явах зам маршрут, сум, хорооны хорондын зай, замын цагдаагийн эргүүл шалтгалтын постуудын хоорондын зай, замын нөхцөл байдал явах зам маршрут хувцас зэргийг объектын судалгаанд үндэслэн төлөвлөн зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх төлөвлөгөө зураглалыг батлуулж мөрдөж ажиллана.

Дүгнэлт

Дээрх бүхнээс үзвэл объектын судалгаандаа анхаарал хандуулж хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийг үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаа, халдлагын зүйл, гэмт хэрэг үйлдэж болзошгүй этгээдийн байнга хэрэглэгддэг үг хэллэг биеийн онцлог содон шинж тэмдэг өмссөн хувцас зэргийг судалсны үндсэн тодорхой тохиолдлыг харьцуулж гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаанд ашиглах бүрэн боломжтой байна. Мөн бидний үзэж байгаагаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий, нэг бүрчилсэн, тусгай чиглэлүүдийг объектын судалгаанд үндэслэн төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх боломжтой гэж үзэж байна.

Нутаг дэвсгэрийн болон тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд хийсэн судалгааны үндсэн дээр эргүүл харуулын үүрэг гүйцэтгэх чиглэлийг тодорхойлох, гадаадын зочин төлөөлөгчдийн айлчлан ирэх үеийн хамгаалалт зохион байгуулах, үндэсний их баяр наадам болон олон нийтийг хамарсан арга хэмжээний төлөвлөгөө зураглал боловсруулах, хүн, хүч, техник хэрэгслийг тооцох, ажиллуулах зэрэг нийгмийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх зэрэг хуулиар хүлээсэн чиг үүрэгээ хэрэгжүүлэхдээ объектын судалгаанд түшиглэн хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн бид үзэж байна.

Санал

- Цагдаагийн байгууллагын нийгмийн хэв журам хамгаалах үйл ажиллагаанд ашиглаж болохуйц өргөн мэдээлэл агуулсан объектын судалгаа хийх загвар боловсруулж хэсгийн байцаагчийн орхигдуулсан дээр зүйлийг судлах боломж бүрдүүлэх;
- Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн үйл ажиллагаанд ашиглаж буй бүртгэл, судалгааг объектын судалгаа хийхэд ашиглах хууль эрх зүйн орчин бүрдүүлэх;
- Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын объектын судалгаанд авагдсан мэдээллийг хуваалах, шилжүүлэх, хадгалах эрх зүйн зохицуулалт бий болгох;
- Объектын судалгаа хийх чиг үүрэг бүхий цагдаагийн алба хаагчдыг объектын судалгаа хийх сургалтад үе шаттай хамруулж, объектын судалгааны аргачлал боловсруулж хэрэгжүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

**МОНГОЛ УЛСЫН ДОТООДЫН ЦЭРЭГТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ
ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЦЭРЭГЖСЭН БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИНЖИХ НЬ**

*П.Оюунболд
ДХИС-ийн магистрант, ахмад*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын Дотоодын цэргийн үйл ажиллагаатай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаадын зарим орон, тэр дундаа ОХУ-ын Үндэсний гварди, БНХАУ-ын Зэвсэгт цагдаа, БНФУ-ын Жендармын үйл ажиллагаа, түүний онцлог шинж, удирдлага, зохион байгуулалтын талаар товч авч дурдсан болно.

Түлхүүр үг: Дотоодын цэрэг, Жендарм, Зэвсэгт цагдаа, Үндэсний гварди

Үндсэн хэсэг. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулинд “Монгол Улсын зэвсэгт хүчин нь улс орныг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс цэргийн хүчээр батлан хамгаалах зорилт бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо мөн”¹³³ гэж заасан бөгөөд бусад цэрэг гэдэгт Хилийн цэрэг, Дотоодын цэрэг багтана гэж хуульчилсан.

Дотоодын цэрэг, түүний чадвар нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хамгаалахад чиглэсэн удирдлагын тогтолцоо, эрх зүйн зохицуулалт, шуурхай бэлэн байдал, мэргэшсэн алба хаагч, тэдгээрийн ур чадвар, дадал, материал-техник, тоног төхөөрөмж, зэвсэг болон тусгай хэрэгслийн хангалт, иргэдийн болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах, холбогдох нэгжид дэг журмыг тогтоохтой шууд хамааралтай.

Дэлхийн улс гүрнүүдэд одоогийн байдлаар манай улсын Дотоодын цэрэгтэй ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг нэр томъёогоор нь авч үзвэл: Итали, Аргентин, Чили зэрэг орнуудад “Карабинери”, Оросын Холбооны Улс, Беларус, Украин, Казакстан, Киргизстан, Азербайжан зэрэг орнуудад “Дотоодын цэрэг”, Франц, Турк зэрэг орнуудад “Жандармери”, Испани зэрэг орнуудад “Гуарда сивил” буюу Иргэний хамгаалалт, Нидерландын Вант улсад “Маринюсс”, Америкийн Нэгдсэн Улс, Канад зэрэг орнуудад “Үндэсний гвард”, Португал улсад “Үндэсний хамгаалалтын алба”, Бүгд Найрамдах Хятад Ард Улсад “Зэвсэгт цагдаа” гэж нэрлэдэг.

Энэхүү өгүүлэлд Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Турк улсын Дотоодын цэргийн удирдлага, бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаар авч үзье. Юуны өмнө Дотоодын цэргийн хүрээнд хамтын ажиллагаа тогтоосон олон улсын шинжтэй Төв Ази, Кавказын орнуудын Дотоодын цэрэг (Avrasya), Европ болон Газар дундын тэнгисийн орнуудын Дотоодын цэрэг (Жандармери)-ийн холбоо (FIER)-г дурдах нь зүйтэй.

Европ болон Газар дундын тэнгисийн орнуудын Дотоодын цэрэг¹³⁴ (Жандармери) (цаашид FIER гэх): Уг холбоог Европ болон Газар дундын тэнгисийн орнуудын Дотоодын цэрэг хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах зорилгоор 1993 онд байгуулсан байна.

Одоо тус холбоонд Франц, Итали, Испани, Португал, Турк, Нидерланд, Маракко, Румын улсууд гишүүнээр, Аргентин, Чили зэрэг улсууд ажиглагчаар оролцож байна. Уг холбооны зорилго нь анх Францын Жандармерийн Ерөнхий командлалаас санаачлан Европын орнуудын Дотоодын цэрэг /Жандармери/ болон цэргийн статустай хүчний байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хэмжээнд өөрсдийн байр суурийг бий болгоход оршино. Гишүүнчлэлийн нөхцөл нь:

¹³³ “Батлан хамгаалах тухай хууль” 15 дугаар зүйл

¹³⁴ Дотоодын цэрэг” сэтгүүл, №5, 2011 (6)

- Европын зөвлөлийн гишүүн, эсвэл Газар дундын тэнгис орчимд оршдог орон байх
- Цэргийн статустай хүчний байгууллага байх
- Шүүхийн хяналтын дор хуулийн дагуу гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг байх
- Нийгмийн хэв журам сахиулах үүргийг гүйцэтгэдэг байх
- Бусад захиргааны үүргийг хэрэгжүүлдэг байх зэрэг нөхцөлтэй байна.

Холбооны бүтэц нь:

- Дарга /холбооны даргыг 1 жилээр ээлжлэн сонгодог. Дарга нь байгууллагыг бүрэн төлөөлөх бөгөөд командлагч нарын хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.
- Нарийн бичгийн газар /Secretariat/ нь гишүүн орнуудын хоорондын харилцан ажиллагааг зохицуулах, командлагч нарын хурлын бэлтгэлийг хангах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, талуудын гаргасан санал хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх ажлыг хариуцна.
- Командлагч нарын зөвлөл жил бүрийн 10 дугаар сард болдог бол гишүүн орнуудын Ерөнхий командлагч нарын уулзалтаар даргалах болон нарийн бичгийн газрын үүргийг дараагийн жилд хариуцах улсад шилжүүлж өгдөг.

Холбооны комиссууд:

1. Ажиллагааны удирдлагын комисс

Энэ комисс нь дүрэм, журам заавар зэрэг эрхийн акт, мэдээлэл солилцох, терроризм болон хууль бус орогнолтой тэмцэх, олон нийттэй харилцах, хурал зөвлөгөөн зохион байгуулах

2. Хүний нөөцийн комисс

Алба хаагчдыг сургаж бэлтгэх, хурал, семинар зохион байгуулах, харилцан туршлага солилцох, мэргэжлийн сургалтуудыг явуулах

3. Шинэ технологи болон ар талын комисс

Хамгаалалтын болон тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн системүүдийг бэлтгэн нийлүүлэх, хангах, судлах, тусгай ажиллагаа, эрх зүйн чиглэлээр интернет хэрэглээний туршлага солилцох, нууцлалыг хангах, шинэ технологитой холбоотой материал хэрэгслээр дэмжлэг үзүүлэх

4. Европын ажиллагааны комисс

Европын гишүүн улс орнуудын нийтлэг эрх ашигт нийцсэн төслүүдийг сонгон шалгаруулж, Европын холбооны холбогдох байгууллагуудад өргөн барих, шийдвэрлүүлэх гэсэн үйл ажиллагааг явуулж байна.

Холбооны ажиллах зарчим

FIEP-д байнгын ажиллагаатай /орон тооны/ удирдлага байхгүй. Холбоог удирдах үүргийг гишүүн орнууд ээлжлэн гүйцэтгэдэг. 2000 оны 10 дугаар сарын 31-нд FIEP-ийн гишүүн орнуудын Дотоодын цэргийн командлагч нарын гарын үсэг зурсан тунхагт бичигт заасны дагуу Францын Жандармерийн ерөнхий командлалын дэргэд холбогч офицеруудын багийг ажиллуулж байна. Комиссын хуралдаан нь жилд 4 удаа гишүүн орнуудад ээлжлэн явагддаг.

Хуралдаанд гишүүн орнуудын Дотоодын цэргийн ахмадаас хурандаа хүртэл цолтой офицерууд оролцдог. Командлагч нарын чуулга уулзалт жилд нэг удаа болдог бөгөөд комиссын хурадаанаас оруулсан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргадаг. Шийдвэрийг англи хэл дээр боловсруулж, командлагч нар гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болдог байна.

Төв Ази, Кавказын орнуудын Дотоодын цэрэг (Avrasya)¹³⁵ холбоо:

Бүгд Найрамдах Турк улс нь Франц улсад төвтэй Европ, Газар дундын тэнгисийн орнуудын Жандармерийн холбоо /FIEP/-ны гишүүн орны хувьд тус холбооны үйл

¹³⁵ Дотоодын цэрэг” сэтгүүл, №5, 2011 (6)

ажиллагаатай ижил төстэй ажиллагааг Европ, Ази тивийн бүс нутагт хэрэгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж Еврази холбоог бий болгохоор идэвхитэй ажилладаг байна.

Азербайжан, Казакстан, Киргизстан, Монгол улсуудын хамтын ажиллагаа, түүхэн харилцааг хөгжүүлэх, олон улсын хэмжээнд бий болоод байгаа терроризм, үй олноор хөнөөх зэвсгийн тархалт, зохион байгуулалттай гэмт хэрэг, зэвсгийн болон хүний хууль бус наймаа, хар тамхи, мансууруулах бодисын худалдаа, агаарын бохирдол, дэлхийн нөөцийн эмх замбараагүй хэрэглээ зэрэгтэй тэмцэх, үүнд улс орнуудын жандарма болон дотоодын цэргийн гүйцэтгэх үүрэг чухал байгааг тэмдэглэж, цаашид эдгээр улсуудын Дотоодын цэргийн хооронд шинээр холбоо байгуулах талаар хэлэлцсэн байна. Холбоо нь Жандармери болон дотоодын цэргийн холбоо /Еврази/ нь гишүүн орнуудын дотоодын цэргийн хамтын ажиллагааг сайжруулах, бүс нутгийн шинжтэй хэлхээ холбоог бэхжүүлэх, мэдээлэл туршлага солилцох, хүнээ сургах зэрэг бусад олон төрлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх төлөвтэй байгаа тул уг холбоонд элсэж, тунхаг гэрээнд гарын үсэг зурж, үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцоор ирсэн байна.

Оросын Холбооны Улс:¹³⁶

Оросын Холбооны Улсын Дотоодын цэрэг нь Дотоод явдлын яамны бүтцэд багтдаг бөгөөд хувь хүн, нийгэм, улс орны аюулгүй байдлыг мөн хүний, иргэний эрх ашгийг хамгаалахад оршино. Үйл ажиллагааны эрх зүйн орчныг Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжууд, тушаалууд дотоодын цэргийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах үйл ажиллагааг зохицуулдаг байна.¹³⁷

Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Дотоодын цэрэгт 4 тусгайгийн хэлтэс байдаг. Үүнд: “Витязь”, шуурхай ажиллагааны “Русь” хэсэг, “Рысь”(Новосибирск хотноо байрладаг), “Росичь” (Новочеркасск хотноо байрладаг)¹³⁸. Дотоодын явдлын яамны дотоодын цэргийн биелүүлж буй бодлогууд хоорондоо уялдан холбоотой ч өөр өөрийн гэсэн онцлогтой болохоор бие даасан байдлаар нь авч үзэж болно.

Дотоодын цэргийн хамгийн чухал үүргийн нэг бол дотоодын байгууллагуудтай хамтран олон нийтийн эмх цэгц, аюулгүй байдал, онцгой байдлыг хангахад оршино. Олон нийтийн эмх цэгц, аюулгүй байдал нь улсын зүгээс хамгаалагддаг болохоор дотоодын цэрэг нь үүнд нилээдгүй үүрэг гүйцэтгэдэг байна. Одоогийн үед олон нийтийн эмх цэгц гэдэг ойлголтыг олон талаас харж болох бөгөөд Дотоодын цэрэгтэй хамааралтай ойлголт нь “цагдаагийн тухай” хуульд зааснаар олон нийтийн харилцааны тогтолцоо, энэ харилцааг олон нийт, улс орон, байгууллагуудын тайван байдлыг хангахын тулд зохицуулдаг тогтоолуудыг олон нийтийн эмх цэгц гэдэг байна. Олон нийтийн эмх цэгцийг хадгалах үйл ажиллагаа нь хэд хэдэн чиглэлээр явагддаг. Хамгийн ил тод байдаг нь гудамж талбай дахь харуул хамгаалалтынхан юм.

Энэ ажлыг Дотоодын цэргийн болон цагдаагийн алба хаагчид биелүүлдэг бөгөөд, үүнтэй холбоотой тушаал нь Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны 1997 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 379 дүгээр тушаалаар “Олон нийтийн эмх цэгц, аюулгүй байдлыг Цагдаа болон Дотоодын цэргийн хамтын хүчээр сайтар сахих”, Оросын Холбооны Улсын Засгийн газрын 1997 оны 12 дугаар сарын 31-ний тогтоолоор бусад чиглэлийн нь “Байгалийн үнэт, эд баялагтай усан газруудад Дотоодын цэрэг мөн бусад Дотоод явдлын яамны газруудтай хамтран олон нийтийн эмх замбараа сахина” гэж заасан байдаг. Олон нийтийн эмх цэгц нь эдийн засаг, улс төр, зохион байгуулалтын тал дээр зохистой арга хэмжээ авах маягаар улсын нэгдсэн бодлогоор явагддаг байна. Хамгийн гол аюулгүй байдлыг хангадаг хүчний байгууллага нь бол Дотоод явдлын яам билээ.

¹³⁶ www.mvd.ru

¹³⁷ www.mvd.ru

¹³⁸ <http://www.mongolian.ruvr.ru>”

Дотоод явдлын яам нь энэхүү үйл ажиллагаандаа тусгай хүчнийхнийг болон дотоодын цэргийг бүрэн хүчээр нь эрх мэдлийнхээ хүрээнд дайчлан ажиллуулдаг байна. Үүнд Дотоодын цэрэг нь хувь хүн, нийгэм, улс орныг элдэв янзын дотоодоос гарч буй аюулаас хамгаалах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хамгийн чухал чиглэлүүд нь терроризм, экстремизмтэй тэмцэх юм.

Дотоодын цэргийн үйл ажиллагааг Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 29-ний “Оросын Холбооны Улсын усан хилийг хамгаалахад шаардлагатай зэвсэг, байлдааны хэрэгсэл хэрэглэх журам”-аар баталсан байна. Оросын Холбооны Улсын Дотоод явдлын яамны Дотоодын цэрэг нь “Онцгой байдлын тухай” хуулиудын дагуу дараах үүргүүдийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

- Оршин суугчид болон нийтийн тээврийн хэрэгслийн хэвийн ажил, амьдралыг хангах зориулалттай объект мөн байгаль орчин, хүний эрүүл мэндэд хортой үйл ажиллагаа явуулдаг объектын хамгаалалт
- Онцгой байдал зарлагдсан нутаг дэвсгэр рүү нэвтрэх, гарах тусгай байдлыг хангах
- Хүчирхийлэл, байлдааны зэвсэг хэрэглэн тэмцэлдэж байгаа хоёр талуудыг салгах үйл ажиллагаа
- Хууль бус зэвсгийн үйл ажиллагааг таслан зогсоох
- Хүн ардын амийг аврах, онцгой байдлыг зогсооход Улсын Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажилладаг байна.

Нэгдсэн удирдлагыг бий болгохын тулд Ерөнхийлөгчийн зарлигаар онцгой байдалтай газар нутагт комендант томилогддог байна. Комендантын цаг тогтоох гэдэг тогтоосон үед Дотоодын цэргийн гүйцэтгэх үүргийн нэг. Энэ үйл ажиллагааг чиглүүлэхийн тулд тус газар нутагт яаралтай ажлын штаб байгуулдаг бөгөөд энэхүү штаб нь комендант байна. Улс даяар онцгой байдал зарлагдсан үед бүх цэргийн хүчнийхэн яаралтайгаар Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллагад шилждэг байна.

Олон нийтийн эсрэг онц ноцтой гэмт хэргүүд бол терроризм (ард түмэн, бүлэг хүмүүсийг айлгах аргаар улс орон нутгийн ажилд нөлөөлөх зорилготой) террорист халдлага (дэлбэрэлт, гал тавих, хүн ардын амь насанд хүрэх эд хөрөнгийн алдагдалд оруулах сүрдүүлэх гэх мэт үр дагавартай улс орны мөн олон улсын бодлогод нөлөөлөх зорилготой үйлдэл). Мөн Дотоодын цэрэг нь энэхүү үйл ажиллагаанд Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгчийн тушаалаар хууль журмын дагуу ажилладаг бөгөөд хууль тогтоомжуудад заагдсан байлдааны зэвсэг хэрэглэдэг байна¹³⁹.

ОХУ-ын Дотоодын цэрэг нь сөрөг тусгай ажиллагаанд оролцохдоо дараах үүргийг биелүүлдэг.

- Хувь хүний бичиг баримтыг шалгах, шаардлагатай бичиг баримт байхгүй тохиолдолд хэн гэдгийг тодорхойлохын тулд холбогдох албан байгууллагад шилжүүлэх;
- Тус газар нутгаас хүмүүсийг гаргах, мөн авто тээврийн хэрэгслийг шалгах;
- Олон нийтийн эмх замбарааг сахих, улсын хамгаалалтад байдаг нийтийн тээврийн хэрэгслийн бааз, түүх, соёл, шинжлэх ухааны объектуудыг хамгаалах;
- Утасны яриа мэдээлэл технологийн системээр дамжиж бүх мэдээллийг хянах, шуудан илгээмж бусад холбоог ашиглан террорист халдлагын талаарх мэдээлэл олох; (*хэн үйлдэх гэж байгаа зорилго, хаана болох гэж байгаа, мөн сэрэмжлүүлэх зорилгоор*)
- Авто тээврийн хэрэгслийг ашиглах (*Элчин сайдын яамны сайд нарын мөн олон улсын байгууллагуудын авто тээврийн хэрэгслүүдээс бусад*)
- онцгой байдлын үед хувь хүний машиныг ашиглах; (*яаралтай тусламжийн үед, террорист халдлагад сэжиглэгдэж буй хүмүүсийг мөрдөн хөөх бөгөөд эдгээр*

¹³⁹ www.mvd.ru

тохиолдлуудад гарсан зардлыг Оросын Холбооны Улсын Засгийн газар хариуцдаг байна).

- Дэлбэрэх бодис, хими биологийн идэвхтэй бодистой ажилладаг үйлдвэрлэлийг зогсоох;
- Хуулийн этгээд болон хувь хүмүүст үйлчилгээ үзүүлэхгүй эсвэл холбооны сүлжээг ашиглахгүй байх;
- Сөрөг тусгай ажиллагаа явагдаж байгаа нутаг дэвсгэрээс оршин суугчдыг шилжүүлэн аюулгүй газар суурьшуулах;
- Хорио цээрийн дэглэм сахиулах;
- Авто хэрэгсэл, явган зорчигчдийн хөдөлгөөнийг зогсоох;
- Саадгүй орон, байранд нэвтрэх эрх;
- Сөрөг тусгай ажиллагаа явагдаж байгаа газар нутаг руу нэвтрэх мөн гарч байгаа хүмүүс авто тээврийн хэрэгслийг бүрэн шалгах;
- Байлдааны зэвсэг, дэлбэрэх бодисыг худалдаалахыг хориглох, согтууруулах ундаа, спирт агуулсан бүтээгдэхүүн болон эмийн эргэлтийг онцгой байдлаар хянах гэсэн дээрхи үүргийг хэрэгжүүлж байжээ.

Түүнчлэн Дотоод явдлын яамны Дотоодын цэрэг нь улсын чухал объектуудын хамгаалалтад дараах үүргүүдийг гүйцэтгэдэг байна. Улсын ашиг сонирхолыг зөрчсөн, аюултай үйл ажиллагааг илрүүлэн зогсоох, Засгийн газрын 2006 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн тушаалаар хамгаалалтад байх ёстой объектуудыг тогтоосон байна. Үүнд: Үйлдвэрлэлийн газар, агуулах гэх мэт.

Мөн Онц байдлын үед Дотоодын цэрэгт даалгагдсан үүрэг¹⁴⁰ гүйцэтгэж байжээ. Үүнд:

- Хянагдах шаардлагатай хориотой бүсийг тодорхойлох
- Хаалттай бүс рүү нэвтрэх, байнгын оршин суухыг хориглох
- Хаалттай бүсийн дээгүүр онгоц гэх мэт аппаратыг нисэхийг хянаж хорих

ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин, Дотоод хэргийн яамны харьяа "Дотоодын цэрэг"-ийн суурин дээр "Үндэсний гварди" байгуулж байгааг албан ёсоор зарлаж, шинээр байгуулагдаж буй "Үндэсний гварди"-ийн харьяанд Холбооны хар тамхитай тэмцэх болон цагаачлалын алба багтаан 2016 оны дөрөвдүгээр сарын 5-нд "Оросын үндэсний гвардийн тухай" хуульд гарын үсэг зурсан байна. Үндэсний гварди нь терроризм болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, дотоод хэргийн яамтай хамтран ажиллахаас гадна хуучин ОМОН, СОБР зэрэг тусгай бүлгүүд өөрсдийн уламжлалт үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Оросын үндэсний гвардийн тухай хуулийн онцлог бүхий зохицуулалтуудыг авч үзвэл:

1.Үндэсний гвардид 18 нас хүрсэн, сэтгэхүйн болон бие бялдрын хувьд эрүүл, урьд нь гэмт хэрэгт холбогдож байгаагүй иргэн орж болно.

2.Гвардын гишүүн нь цэргийн сургалтын төвд жилд 3 удаа тус бүр нь 3 хоногийн сургалт, жилд нэг удаа 7 хоногийн цэргийн сургалтад хамрагдана.

3.Долоо хоног бүрийн хагас бүтэн сайн өдрүүдэд гвардын гишүүн өөрийн сайн дураар буудлагын полигонд явагдах буудлагын сургалтад хамрагдаж болно. Гишүүдийн жилд хэрэглэх сумны тоог тогтоож өгөх ба сумыг үнэ төлбөргүй зарцуулна.

4.Үндэсний гварди нь тус улсын газар нутаг, засаг захиргааны мужуудад хуваагдана.

5.Тайван цагт Үндэсний гвардийн хүчин орон нутгийн удирдлагын хүсэлтээр байгалийн болон хүний оролцоотой үүссэн гамшиг, сүйрлийн хор уршигийг арилгах ажилд дайчлагдан оролцоно.

6.Гвардын гишүүн цэргийн дүрэмт хувцас, хэрэглэл, сургалтын бууг өөрсдийн зардлаар худалдан авч гэртээ хадгалах ба улс эдгээрийн үнийг нөхөн төлнө.

¹⁴⁰ www.vv-mbd.ru

7.Гвардын гишүүн нь өөрийн ажлын газраас үндсэн амралтаас гадна цалингүй 4 долоо хоногийн нэмэлт амралт авах эрхтэй.

8.Гвардын гишүүн нь орлогын албан татвараас чөлөөлөгдөнө.

9.Гвардын гишүүн нь тайван болон дайны цагт явагддаг ОХУ-ын цэрэг татлагаас чөлөөлөгдөнө.

10.Үндэсний гвардийн офицеруудыг дэвшүүлэх тогтолцоо нь өөрийн удирдаж буй бүлэг, ангиа байлдааны нөхцөлд хэрхэн удирдаж байгаагаас хамаарна. Бодит байдал дээр хэрхэн удирдаж байгаа эсэхийг шалгахдаа дайны нөхцөлд ойртуулсан лазерийн систем бүхий дуурайлган үзүүлэх тусгай сургалтын хөтөлбөр ашиглана.

11.Үндэсний гвардийн офицерууд хошууч цолтой болбол байнга ажиллаж болно. Түүний цалин нь Оросын байнгийн армийн офицертой адилхан байна.

12.Гвардийн дүрмийг боловсруулах, өөрчлөх асуудлыг гварди өөрсдөө хариуцана.

13.Гварди нь дивизийн бүтэц, зохион байгуулалттай байна.

14.Гвардийн үйл ажиллагааг явуулах зардлыг холбооны төсвөөс гаргана. Түүний төсөв нь холбооны төсвийн 5 хувь орчимтой тэнцүү байна.

Уг хуулийн үр дүнг Оросын хууль тогтоогчид өмнөд хөршүүдээс хийж болох том хэмжээний дайралтаас хамгаалах өндөр бэлтгэл бүхий байнгийн бэлтгэл хүчинтэй болно, иргэд өөрсдийн аюулгүй байдалд илүү итгэлтэй болно, нийгэм дэхь эх оронч үзэл нэмэгдэнэ гэж үздэг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Зэвсэгт цагдаа:

Хятадын Ардын чөлөөлөх арми. Хятад бол баялаг түүхтэн уламжлалтай нэн эртний гүрэн билээ. Хятадын түүхэнд хаад, ноёд, цэргийн жанжидын удирдсан дайн, байлдаан, тариачдын бослого, үймээн олон тохиож байсан бөгөөд Күнз, Сүнз, Мэнз, Лаоз зэрэг гүн ухаантан, сэтгэгчдийн цэрэг, дайны тухай онол, сургаалиуд ч цөөнгүй¹⁴¹ байдаг байна. Хэдэн зууны туршид хятад үндэстний хувьд цэрэг арми нь тайван цагт, үймээн самууны үед гэсэн 2 үндсэн чиглэлээр ашиглагдаж, нийгэмд голлох үүргийг гүйцэтгэж байна.

Энхийн цагт цэрэг армийг энгийн улс төрчид удирддаг байсан бөгөөд ийм үед цэрэг арми нь дотоодын бослого тэмцэл, гадаадын түрэмгийлэгчдийг бут цохих хэмжээний хүчтэй байдаг ч улс төрийн тогтолцоо болон иргэний удирдлагадаа ямар ч аюул занал учруулахгүйгээр оршин тогтнож байжээ. Харин дотоодын үймээн самууны үед цэргийн шинэ жанжид хуучин системийг халж, шинэчилж байсан нь улс төр нийгмийн тогтолцоог цэрэгжүүлэхэд хүргэж байсан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний цэргийн төв зөвлөл бол төрийн цэргийн ерөнхий командлалын байгууламж байж бvх хятадын зэвсэгт хvчнийг удирддаг. Үндэсний цэргийн төв зөвлөл нь дарга, орлогч дарга нар болон хэд хэдэн гишvннээс бvрдэж, даргын хариуцлагын дvрэм хэрэгжvүлдэг. Үндэсний цэргийн төв зөвлөлийн даргыг Бvх хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын чуулганаар сонгоно¹⁴². Тэр нь Бvх хятадын ардын төлөөлөгчдийн их хурал болон тvний байнгын хороонд хариуцана. Үндэсний цэргийн төв зөвлөлийн бvрэн эрхийн хугацаа нь 5 жил байдаг боловч улиран сонгогдож болдог.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зэвсэгт хvчин нь Хятадын ардын чөлөөх арми юм. Хятадын ардын чөлөөх арми бол үндэсний ердийн цэрэг юм. Үүнд:

- Хуурай замын цэргийн хүчин;
- Агаарын цэргийн хүчин;
- Тэнгисийн цэргийн хүчин;
- Пуужит цэргийн хүчин;

¹⁴¹ Б.Даваажав, “Хятадын ардын чөлөөлөх арми”, УБ, 2011 он, 5-5 дахь тал

¹⁴² Mongol.cri.cn.chinaabc/chapter2/chapter20204.htm

- Бусад цэргийн хүчин гэж ангилдаг.

Бусад цэргийн хүчин гэдэг нь Хятадын ардын чөлөөлөх армийн Тагнуулын байгууллага, Ардын зэвсэгт цагдаа, Иргэний цэрэг зэргээс бүрдэнэ. Хятадын ардын зэвсэгт цагдаа бол төрөөс өгсөн аюулгүй байдлын хамгаалалтын үүргийг хариуцаж, нийгмийн дэг журмыг баталгаажуулдаг. Иргэний цэрэг бол үйлдвэрлэлээс салдаггүй иргэний зэвсэгт хүчин юм.

Хятадын Ардын зэвсэгт цагдаа нь 1983 оны 04 дүгээр сард Хятадын коммунист нам болон засгийн газрын яамд, газруудыг хамгаалах, Аюулгүй байдлын яам болон орон нутгийн аюулгүй байдлын товчооны /цагдаагийн байгууллага/ удирдлага дор гал унтраах, хилийн хамгаалалтын цагдаа гэсэн үүрэгтэйгээр Хятадын ардын чөлөөлөх армийн нэгжүүдтэй нэгдэх замаар байгуулагдсан байна.

Хятадын Үндсэн хуулиар Ардын зэвсэгт цагдаа нь тус улсын зэвсэгт хүчний 3 гол элементийн /Хятадын ардын чөлөөлөх арми, Ардын зэвсэгт цагдаа, нөөц хүчин/ нэг юм. Ардын зэвсэгт цагдаа одоо нийтдээ 660000 орчим, Дотоодыг аюулаас хамгаалах хүчин 400000 орчим бие бүрэлдэхүүнтэй алба ажиллагаагаа зохион байгуулан явуулж байна. Ардын зэвсэгт цагдаа нь Цэргийн төв зөвлөл, Орон нутгийн аюулгүй байдлын товчоо гэсэн 2 удирдлагын системтэй. Одоо Ардын зэвсэгт цагдаагийн бүтэц зохион байгуулалтад 8 салбар нэгж багтаж байна. Үүнд:

- Дотоод хамгаалалт;
- Хил хамгаалалт;
- Гал унтраах;
- Хамгаалалтын корпус;
- Уснаас аврах;
- Алтны;
- Тээврийн;
- Ойн аж ахуйн зэрэг болно.

Иргэний цэрэг: Хятадын бага хүчний цохигч хэмээх Иргэний цэрэг буюу орон нутгийн цэрэг нь олон нийтийн цэрэгжүүлсэн байгууллага юм. Иргэний цэрэг нь тайван цагт үйлдвэрлэлийн болон бүтээн байгуулалтын салбараас үл хөндийрэх бүрэлдэхүүн багтах бөгөөд уг бүрэлдэхүүн орон нутгийн үйлдвэрийн бүсүүдээр зохион байгуулагдан, цэргийн бэлтгэл сургууль явуулдаг байна.

Иргэний цэрэг нь цэргийн бэлтгэлтэй дайчилгааны дэлгэн байрлуулах нөөцийг бүрдүүлдэг учир Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүнд багтдаг байна.

Иргэний цэргийн ерөнхий удирдлага нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Төрийн зөвлөл, Цэргийн төв зөвлөл байх бөгөөд цэргийн мэргэжлийн удирдлага нь ХАЧА-ийн Жанжин штаб байна. Одоо иргэний цэрэг нь 30 орчим сая хүнтэй үндсэн бүрэлдэхүүн /хоёр дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн/-д цэргийн сургалт бэлтгэлд хамрагдаагүй 18-35 хүртэлх насны иргэд хамрагддаг, удирдлагын бүрэлдэхүүнд 6.5-аас 10 сая хүнтэй цэргийн жинхэнэ алба хаасан 28 нас хүртэлх иргэд, батальоны захирагч, орлогч байсан 40 хүртэлх насны бэлтгэл офицероос бүрдэх бөгөөд түүнд эмч, инженер зэрэг нарийн мэргэжилтэй эмэгтэйчүүд багтдаг, сургалтыг зохион байгуулахдаа иргэний цэргийн удирдах бүрэлдэхүүний бэлтгэл сургуулийг 2 жилд тус бүр 15-30 хоног цугларалтын хөтөлбөрөөр сургалтыг явуулдаг байна. Хоёр жилийн иргэний цэргийн бэлтгэл сургалтын хөтөлбөрийн шалгалтад 2-3 удаа амжилт үзүүлсэн иргэдийг албан тушаал дэвших цугларалтад 3-5 хоног хамруулдаг байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хууль тогтоомжид иргэний цэргийн дайны болон тайван цагийг хуульчилсан байна. Тайван цагийн үүрэгт чухал объект болон нийгмийн хэв журам сахиулахад Хятадын ардын чөлөөх армийн болон Хятадын цэргийн анги, салбартай хамтран ажиллана гэж заасан байна.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зэвсэгт хүчнээс Хятадын Ардын зэвсэгт цагдаа, Иргэний цэрэг нь манай улсын Дотоодын цэрэгтэй ижил төстэй чиг үүрэгтэй байна¹⁴³.

Бүгд найрамдах Франц улсын Үндэсний жендарм:

Францын сенешаль¹⁴⁴ (фр:sénéchal de France, ор : сенешаль Франции) нь Баруун Франси¹⁴⁵ (France occidentale) Улсын хаан Лотарь-ийн шийдвэрээр 978 онд бий болж, үүний дараа тус улсыг Франц Улс гэж нэрлэж эхэлсэн эхэн үеэр буюу 1191 онд коннетабль (фр:connétable, лат:comes stabuli, анг:constable, ор:коннетабль) гэсэн нэршилтэй цэргийн гүн бий болжээ.

Армид зэвсэгт хүчний цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлдэг, цэргийн цол, статустай байдлаар цэргийн шинж нь илэрдэг ажээ. 1849 оноос Бүгд найрамдах улсын хамгаалалт (фр:garde républicaine) гэх хүндэт харуулын ангийг жендармид нэгтгэж байжээ.

Өнөөгийн жендарм¹⁴⁶ нь цэргийн статустай цагдаагийн хүчин (фр:force de police a statut militaire) бөгөөд хот орчмын бүс, хөдөө орон нутгийн аюулгүй байдлыг хариуцахын зэрэгцээ Францын далайн чанад дахь нутаг дэвсгэрт, эх газрын бараг бүх газар нутагт үйл ажиллагаагаа явуулж байна.

Жендарм нь 2009 оноос эхлэн Батлан хамгаалахын сайдаас гадна Дотоод явдлын сайдын бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш хотын бүс нутагт (хот дотор) ч цагдаагийн хамт ажилладаг болжээ. Тус байгууллага нь энэ зуунд францын нутаг дэвсгэрийн 95 хувьд чиг үүргээ гүйцэтгэж, нийт франц түмний 55 хувьд хүрч ажиллаж байна. Үндэсний жендарм нь аюулгүй байдал, хамгаалалт хариуцах, гэмт хэрэгтэй тэмцэхээс гадна далай тэнгис, уул нуруу, зам, агаарын цагдаагийн мэргэшсэн чиг үүргийг гүйцэтгэдэг ажээ. Энэ үйл ажиллагаандаа орчин үеийн байлдааны зэвсэг, техник хэрэгсэл ч ашиглана.

Жендармын үндсэн чиг үүрэг нь:

Шүүхийн цагдаа¹⁴⁷ (фр:police judiciaire)-гийн чиг үүрэг буюу мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг хэрэгжүүлэх

Захиргааны цагдаа (фр:police administrative)-гийн чиг үүрэг болох нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг сахиулах, тусламж дэмжлэг үзүүлэх, замын хөдөлгөөнийг зохицуулах, байгаль орчныг хамгаалах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх

Цэргийн чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд цэргийн цагдаа, хамгаалалтын болон байлдааны чиг үүрэг (цөмийн зэвсгийн хяналт, хамгаалалт, батлан хамгаалах тодорхой ажиллагаа) -ийг тус тус хэрэгжүүлдэг байна.¹⁴⁸

¹⁴³ Б.Даваажав, “Хятадын ардын чөлөөлөх арми”, УБ, 2011 он, 5-6 дахь тал

¹⁴⁴ <https://www.police-nationale.interieur.gouv.fr/Presentation-generale/Histoire>

¹⁴⁵ [https://fr.wikipedia.org/wiki/Commissaire_de_police_\(France\)](https://fr.wikipedia.org/wiki/Commissaire_de_police_(France))

¹⁴⁶ Энэ армийн зэвсэгтэй хүн гэсэн үгнээс гаралтай ажээ.

¹⁴⁷ Шүүхийн цагдаа гэж шууд орчуулагдах “police judiciaire” нэршил нь утга агуулгаараа мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг нэрлэж буй эрүүгийн процессын хуулийн нэр томъёо юм. Францын эрх зүйд “police judiciaire” гэх ойлголт эрүүгийн процессын хуулийн 12-15 дугаар зүйлүүдэд тодорхойлогдсон байдаг. “Police judiciaire” хэмээн томъёологдсон чиг үүргийг үндэсний цагдаагийн газар, үндэсний жендарм, гааль, хотын цагдаагийн газраас гадна тусгай бүрэн эрх олгогдсон зарим төрийн байгууллага дахь төрийн албан хаагчид хэрэгжүүлж болно. Тухайлбал, Францын үндэсний төмөр замын нийгэмлэгийн болон Парис хотын тээврийн газрын агент, хөдөлмөрийн байцаагч /inspecteurs du travail /, байгаль орчны байцаагч /inspecteurs de l'environnement/, татварын захиргааны агент /agents de l'administration fiscale/, тусгай хамгаалагч /garde particulier/, хотын мэр, түүний орлогч гэх мэт. Энд нэрлэгдсэн төрийн албан хаагчид эрүүгийн хуульд заасан болон бусад дүрэм журамд заасан зөрчлийг /contravention/ шалгаж шийдвэрлэдэг байна. Францын гэмт явдал гурван ангилалд хуваагдаж онц хүнд гэмт хэрэг, гэмт хэрэг /ердийн/, жижиг хэрэг, зөрчил гэж ангилагддагийг мэднэ. Тэгэхээр зөрчил шалган шийдвэрлэж буй процесс ч “police judiciaire” хэмээх ойлголтод багтана.

¹⁴⁸ Ш.Баасандорж. Ром-Германы эрүүгийн процесс. УБ., 2018. 171 дахь тал

Одоогийн Үндэсний Жендармын ерөнхий газар (фр:direction g n rale de la Gendarmerie nationale) нэрээр цэргийн статусын доор цагдаагийн  йл ажиллагааг г йцэтгэдэг гэдгийг дээр дурдсан. Жендарм нь нэн эртний улсын цагдаагийн х чин (фр:C'est la force de police  tatique la plus ancienne) байсан гэдэг нь т  ний   сэл, хөгжлөөс тодорхой харагдаж байна. Жендармын б рэлдэх  нд нь 100 000 албан хаагч ажиллаж байна. Жилийн т с в нь 8,3 тэрбум евро байдаг ажээ.

Тус газрын б т ц, тогтолцоо нь их энгийн бөгөөд  ндэсний жендармын газар, б с тойрог, муж, хорооны жендармын газар гэсэн босоо тогтолцоотой.   нд:

- Үндэсний Жендармын ерөнхий газар (фр:direction g n rale de la Gendarmerie nationale)
- Жендармын б сийн газар (фр: gion de gendarmerie)
- Мужийн жендармын групп (фр:groupement de gendarmerie d partementale)
- Мужийн жендармын анги (фр:compagnie de gendarmerie d partementale)
- Мужийн жендармын бригад (фр:brigade de gendarmerie d partementale)

Д гнэлт

Гадаадын улс орнуудын Дотоодын цэргийн байгууллагатай манай орны Дотоодын цэргийн г йцэтгэж байгаа   рэг нь т стэй боловч байгууллагын б т ц нь ихэнхдээ яамны статустай, хувь х н, нийгэм улс орны дотоод аюулг й байдлын талаар т р  с баримтлах бодлого,  йл ажиллагаатай, тухайн албанд орохыг х ссэн иргэдийг  е шаттайгаар тодорхой хугацаанд судалж, албан тушаалд тэнцсэн иргэдийг мэргэжлийн болон мэргэшлийн сургалтуудад  е шаттайгаар тогтмол суралцуулж, тухайн албан тушаалд нь дадлагажуулан ажиллуулдаг, м н тухайн улс орнуудын хөгжлийн т вшинг  с хамаарч алба хаагчдад олон т рлийн хангалт, нийгмийн хамгаалалд хамруулдаг, олон улсын  йл ажиллагаанд идэвхитэй оролцуулдаг байна.

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ТЭТГЭВЭР ТОГТООЖ ОЛГОХТОЙ ХОЛБОГДСОН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

*С.Лхагвадорж
ДХИС-ийн магистрант*

Аливаа улс, нийгэмд хүн амын нийгмийн баталгааг хангах асуудал нь төрөөс нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлж байгаа бодлогоор дамжин хэрэгждэг.

Хүн амын нийгмийн хамгаалал гэдэг нь өргөн утгаар авч үзвэл нийгмийн бүх гишүүдийн амьдралын хэвийн нөхцлийг хангах нийгэм, эдийн засаг, эрх зүйн цогцолбор арга хэмжээ юм. Энэ ойлголт нь нийгмийн давхарга, бүлэг бүрийн эрх ашиг, сонирхол, хэрэгцээний онцлогийг илэрхийлж, түүндээ тохирсон арга хэрэгсэл, оновчтой механизм, хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн нөхцөлд хэрэгжих боломжтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Монгол Улсын иргэн өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй”¹⁴⁹ гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуульд төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулахаар тунхагласан. Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтлах нь зүйтэй.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2 дахь хэсэгт “эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгоход оршино” хэмээн эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөлийг тодорхойлсон.


